



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр, Баасан гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	<b>2-22</b>
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	<b>23-86</b>
<hr/>	
1. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	26-38
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	38-46
3. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.12.26-ны өдөр ирүүлсэн/	46-53
4. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, нэн яаралтай/	53-62
5. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	62-63
6. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	63-64
7. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	64-69
8. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	69-71
Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/	71-72
9. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	73-74
10. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороод боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	74-75
11. Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах	75-83
Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох	83-86

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 46 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Г.Амартүвшин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Ганбаатар, Г.Дамдинням, Б.Жавхлан, Д.Сарангэрэл, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Ц.Сэргэлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ш.Раднаасэд;

Тасалсан: А.Адъяасүрэн, П.Анужин, Д.Батлут, Ж.Батсуурь, С.Бямбацогт, Г.Ганболд, Б.Дэлгэрсайхан, Ж.Сүхбаатар, Ч.Ундрэм, Б.Энх-Амгалан, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин;

Хоцорсон: С.Амарсайхан -40 минут, Ц.Анандбазар -13 минут, Б.Бат-Эрдэнэ -41 минут, Т.Доржханд -49 минут, Г.Мөнхцэцэг -30 минут, Ц.Туваан -1 цаг 08 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

**Нэг.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монголбанкны Бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын референт Д.Батсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал С.Цогтсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Д.Ганбат, Н.Ганибал, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 14:00 цаг хүртэл завсарлага өгөв./11:43/

*Хоёр.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Хөрс, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 48 минутаас хуралдааныг даргалав.*

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Н.Ганибал, Ц.Туваан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

*Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

Төслийн 1 дүгээр зүйлийн “улаанбуудайн” гэсний дараах “баяжуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 18  
Бүгд: 40  
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “улаанбуудайн” гэсний дараах “баяжуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 17  
Бүгд: 40  
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 17  
Бүгд: 40  
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.*

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.***“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.12.26-ны өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн захирал П.Эрдэнэтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал танилцуулав.

Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Д.Тогтохсүрэн нарын тавьсан асуултад Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:48/

*Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, нэн яаралтай/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монголбанкны Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал А.Батсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Ашигт малтмал газрын тосны газрын дарга Л.Баярмандал, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга Д.Батмагнай, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар хариулж, тайлбар хийв.

*Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.3.Хуримтлалын болон Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанк дахь төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцох, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 16  
Бүгд: 38  
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.6.Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын болон өөрийн хөрөнгө оруулсан авто зам, төмөр зам, дэд бүтцийн төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага зохион байгуулалтаар хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 15  
Бүгд: 38  
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.4” гэсний дараа “, 12.6” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.9.Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдэд төвлөрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39  
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

### **Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 1/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:**

“5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 10  
Бүгд: 40  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 3/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:**

9.1.5.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 8  
Бүгд: 40  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.



3.Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 9  
Бүгд: 40  
77.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.8.Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшлийн хувьцаа, Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээдийн хувьцаанд энэ хуулийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 8  
Бүгд: 40  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монголбанкны Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал А.Батсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Ашигт малтмал газрын тосны газрын дарга Л.Баярмандал, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга Д.Батмагнай, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооноос гаргасан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 10  
Бүгд: 40  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

**Зургаа.Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монголбанкны Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал А.Батсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Ашигт малтмал газрын тосны газрын дарга Л.Баярмандал, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга Д.Батмагнай, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооноос гаргасан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 12  
Бүгд: 39  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, “Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо”-ны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 37 минутаас хуралдааныг даргалав.*

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Н.Учрал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

*Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

#### **“ГУРАВДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ**

**10 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт**

10.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, гишүүдээс бүрдэнэ.

10.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, дэд зөвлөлийн нийтлэг дүрэм, тэдгээрийн эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох,

дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3.Мэргэжлийн нэгдсэн холбооны дэргэд тухайн салбарын онцлогоос хамаарсан үйл ажиллагаа, мэргэжлийн чиглэлээр дагнасан дэд зөвлөл ажиллаж болно. Дэд зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, дүрмийг удирдах зөвлөлийн хурлаар батална.

10.4.Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд болон бусад албан тушаалтан энэ хуулийн 12.1.10-т заасан ёс зүйн дүрмийг зөрчсөн, тухайн салбарын болон мэргэжлийн эрх ашгийг хөндсөн, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл гаргасан бол хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тухайн албан тушаалтныг чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

10.5.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах ажлын албатай байж болно.

10.6.Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.7.Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.8.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр барилга, хот байгуулалтын салбарт авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хийх Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, мэдээллийг хойшлуулав./13:55/

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 18  
Бүгд: 39  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.*

*Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монголбанкны Бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын референт Д.Батсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал С.Цогтсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./14:00/

*Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “төсөв хооронд,” гэснийг, 6.2 дахь хэсгийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон” гэснийг тус

тус хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “6.2” гэсний дараа “, 6.3” гэж нэмэх:

“6.3.Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 17  
Бүгд: 38  
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.*

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 16 минут үргэлжилж, 14 цаг 02 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 48 минутад эхлэв.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг танилцуулав./14:48-14:54/

***Ес.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Хөрс, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсувд, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодоос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хороодын танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

***Арав. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороод боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Хөрс, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хороодоос гаргасан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	14
Бүгд:	39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван нэг.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлахтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Т.Доржханд нар үг хэлэв.

**Г.Занданшатар:** 1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 1

Бүгд: 40

97.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 2

Бүгд: 40

95.0 хувь буюу олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 2

Бүгд: 40

95.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** 2.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 0

Бүгд: 39

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 1

Бүгд: 39

97.4 хувь буюу олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.



**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38  
Татгалзсан: 1  
Бүгд: 39  
97.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** 3.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 39  
Татгалзсан: 1  
Бүгд: 40  
97.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 0  
Бүгд: 40  
100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 0  
Бүгд: 40  
100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 0  
Бүгд: 40  
100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39  
Татгалзсан: 1  
Бүгд: 40  
97.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38  
Татгалзсан: 2  
Бүгд: 40  
95.0 хувь буюу олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39  
Татгалзсан: 1  
Бүгд: 40  
97.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** 8.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 36  
Татгалзсан: 4  
Бүгд: 40  
90.0 хувь буюу олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39  
Татгалзсан: 1  
Бүгд: 40  
97.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37  
Татгалзсан: 3  
Бүгд: 40  
92.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Г.Занданшатар:** 8.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

11.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Хоршооны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 1

Бүгд: 40

97.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 1

Бүгд: 40

97.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 0

Бүгд: 40

100 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

***Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

1.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:53/

2.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:53/

3.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:53/

4.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:54/

5.Хоршооны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:54/

6.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:54/

7.“Тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:54/

8.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:54/

9.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай

холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:54/

10.Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:54/

11.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:55/

12.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:55/

13.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:55/

14.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:55/

15.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:55/

16.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:55/

17.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:55/

18.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:56/

19.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:56/

20.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:56/

21.Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:56/

22.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:56/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 30 минут үргэлжилж, 72 гишүүнээс 44 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 02 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 34 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданишатар:** Хаврын чуулганы 2024 оны хаврын чуулганы 4 дүгээр сарын 14-ний өдрийн, 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 2 дугаарт, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, зарчмын зөрүүтэй нэг саналтай эцсийн хэлэлцүүлэг. 3 дугаарт, Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ, сангийн орлого, зарлагын 2023 оныг гүйцэтгэл, 24 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Юу яриад байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүд хэлэлцэнэ. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээлэл Газар хөдлөлтийн гамигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр барилга, хот байгуулалтын салбарт авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулна.

Өнөөдөр, Чинбүрэн гишүүн хаачив. Чинбүрэн гишүүнийг дуудаарай. Чинбүрэн гишүүн яасан бэ. Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 4 дүгээр сарын 19-нд Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн,

Содномдаржаагийн Жигжидсүрэн, Гонгорын Надмид нарын дунд хүү болон эхээс мэндэлсэн байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэнд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшиц, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Пүрэвдорж хамгийн их тасалж байгаа Пүрэвдорж гишүүн, тэгээд холбогдолгүй үг хэлж байгаа. Дэг зөрчиж байгаа. Тийм учраас өнөөдөр Оюунчимэг гишүүн л үг хэлнэ. Байнга дэг, байнга дэг зөрчиж байгаа. 5 удаа сануулгатай байгаа. Одоо цалинг нь 3 сараар хасах. Тэгсэн харин, арай л эрхлүүлчихсэн. Одоо ерөөсөө тэр дутагдлаа засъя би одоо. Өнөрболор.

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааны ирц бүрдсэн тул 4 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудлыг танилцуулчихсан байгаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа орохын өмнө өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар үг хэлэхээр санал ирүүлсэн Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ. Өнөрболор гишүүнээ Эдийн засгийн байнгын хороо руу.

**М.Оюунчимэг:** Баярлалаа. Өглөөний мэнд хүргэе. Би өнөөдөр энэ чуулган дээр цаг авсан нэг чухал асуудлыг бас хөндье. Энэ хаврын чуулганаар зайлиггүй орох ёстой хуультай холбогдуулаад ярья гэж бодсон. Сая эмийн сонсгол 3 өдөр Монголын нийгмийг нэг талаасаа цочроолоо, нөгөө талаасаа зайлиггүй арга хэмжээ авах цаг нь болсон юм байна гэдгийг харууллаа. Гэхдээ ийм сонсголууд болох боломжийг энэ Их Хурал, Улсын Их Хурлын дарга бас нээж өгсөнд би талархмаар байна. Яагаад гэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр 28.2-т заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой, нөгөө нийтийн



ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний 1/4 нь одоо санаачилга гаргаад хүлээн зөвшөөрсөн бол түүр Хянан шалгах түүр хороо байгуулж болно гэсэн энэ заалтыг энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т оруулж өгсөн нь, бас энийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн нь өөрөө ард иргэдэд юу болоод байгаа юм бэ, энэ нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар гэдэг тэр боломжийг мэдэх эрхийг нээж өгсөн ийм чухал заалт болсон.

Тэгэхээр энийг бас ингэж ажил хэрэг болгож байгаа, энэ сонсголудыг зохион байгуулах боломж олгосон Улсын Их Хурлын дарга Занданшатар энэ Улсын Их Хурлын гишүүддээ би бас талархал илэрхийлмээр байна. Саяын энэ сонсгол эмийн сонсгол бол хэд хэдэн зүйлийг маш тодорхой болголоо. Нэг талаасаа төрийн зохион байгуулалт гэдгийг хэтэрхий их бий болгосноор төрийн тэр зохион байгуулалт дор мэдээлэлд ойрхон албан тушаалтнууд тухайн салбарынхаа ашигтай бизнес рүү хэрхэн хошуурч ордгийг нотлох баримт судалгаагаар бол гаргаж тавилаа. Эрүүл мэндийн яамны, Эрүүл мэндийн үндэсний зөвлөл, Хүний эмийн зөвлөл, энэ өөрөө хил гааль, төрийн худалдан авах газартайгаа нийлээд эм аптека, тэгээд л тэр энэ чиглэлийн бизнесийг борооны дараах мөөг шиг яаж цэцэглүүлснийг, үнэ ханш нь хэрхэн өссөнийг, эргээд энэ бүхэн ард иргэдийн нуруун дээр ямар их дарамт учруулж байгааг бид ингээд нотлох баримтаар гаргаж тавьж байна л даа.

Энэ 2015 оны Дэлхийн банкнаас хийсэн судалгаа, 2023 онд Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан судалгаа шалгалт, 21 онд 2021 онд Нийгмийн бодлогын байнгын хороо аудиттай хамтраад хийсэн энэ бүх судалгаанаас харахад эмийн үнэ ханш бол нээрээ үнэхээр огцом өссөн ийм судалгаанууд бодитоор харсан. Би зүгээр товчхон зүйлийг л хэлэхэд одоо жишээ нь эмийн үнэ гэхэд 2019 онтой харьцуулахад 114 хүртэл хувиар нэмэгдсэнийг бүх энэ

судалгаанууд харуулсан. Ялангуяа 22 оны байдлаар Монгол Улсын хэрэглээний сагсанд орсон өрхийн гол нэрийн эмийн нэмэгдлийг судлаад үзэхэд дотоодын үйлдвэрийн эмийн хувьд нэмэгдэл нь 41-ээс 98 хувь, импортын эмийн гарал үүсэл нь улсаас хамаараад 60-аас 200 гаруй хувиар ингээд нэмэгдсэн нь бүхий л энд 3 хийсэн том судалгаануудаар шалгалтаар ингээд гараад ирлээ. Тэгээд энэ нь ямар учиртай байна, дэлхийн зах зээл бусад улс орныг аваад үзэхэд мэдээж ковидын нөхцөл байдал, хил гааль, ханш, инфляц гээд ийм зүйлүүд нөлөөлсөн ч гэлээ энэ нь өөрөө бас тухайн компаниудад яаж шат шатдаа ашиг олдгийг, эцэст нь энэ бүх зарлага нь эцсийн хэрэглэгч дээр ямар их дарамт болж байгааг бид нар өнөөдөр нотлох баримтаар гаргаж тавилаа л даа.

Гэтэл Улсын Их Хурал төсөв батлах үед эмийн салбарт жишээлбэл 2019 онд 40 тэрбум төсөвлөдөг байсан бол 2024 онд 137,2 тэрбум болтлоо нэмсэн. Энэ эрүүл мэндийн салбарын багцыг 1,6 их наяд болтол нэмсэн. Гэтэл энэ бүхний зорилго нь юу байсан гэхээр ард иргэдийн энэ эмийн салбартаа эрүүл мэнддээ зарцуулж байгаа санхүүгийн дарамтыг буулгах, ачааллыг багасгах байсан. Гэтэл энэ эцсийн зорилтоо биелүүлээгүй, харин эм хангамжийн болон хэдхэн бүлэглэлийг угжсан гэж хэлж болно. Энэ нь өөрөө эргээд энэ эмийн салбарт ялангуяа аалзны сүлжээ бий болж мафижсан, энэ нь өөрөө бүүр дархлаа бий болгох ийм аюул тулгараад байна. Тийм учраас би Улсын Их хуралдаа, энэ Улсын Их Хуралдаа хандаж эрүүл мэндийн салбарынханд, Эрүүл мэндийн сайдад Эм, эмийн хэрэгслийн тухай хуулийг энэ хаврын чуулганаар зайлиггүй хэлэлцэж батлах ийм шаардлагатай байна.

Сая сонсголоор гарсан энэ бүх асуудлыг чагтлах, засах зүйл нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаа яаралтай оруулж ирж засахгүй бол энэ авлигын сүлжээ бүүр аалзны тор нь сүүлдээ бүүр эргээд

засах аргагүй болно. Эрүүл мэндээрээ иргэд асар их хохирч байна. Тийм учраас энэ хуулийн төслийг яаралтай оруулж ирж батлуулах үүргийг Эрүүл мэндийн сайдад өгөх хэрэгтэй байна. Чинзориг сайдын хэлснээр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль бэлэн болчихсон. Энийг бид нар Засгийн газарт оруулмаар байна. Хэрэг эрхлэх газарт та нар бас үүрэг чиглэл өг, өгвөл зүгээр байна гэсэн. Сая сонсгол Түр хорооноос энэ хуулийг яаралтай батлуулах үүрэг өгсөн байгаа. Өмнөх парламентын үед энэ хууль бас босгыг давж чадаагүй. Дундуур нь манай улс төрийн эрх мэдэл бүхий бүхий хүмүүс үймүүлсээр байгаад яам нь өөрөө бас энэ нөгөө мэдээллээ нуухын тулд буцаад татаж авсан. Одоо энэ 20-оос 24 онд бас энэ давах уу, давахгүй юу гэдэг байгаа учраас энд анхаарал.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн, Чинбүрэн гишүүн нар энэ эмийн сонсголыг сайн явуулсан. Одоо энэнийхээ сонсголынхоо үр дүнгээр тогтоол санаачилж Улсын Их Хурлаар хэлэлцүүлж болно. Түүн дээр тэр Эм, эмийн хэрэглэгдэхүүний тухай хууль тэрнийгээ бол холбогдох яамд яаралтай оруулж ирж хэлэлцэхээр тэр тогтоолдоо тусгаад саяын саналаа Улсын Их Хурлын хэлэлцүүлэгт оруулж болно. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр манай Монгол Улс 1 сая өрхтэй, тэр сая өрхийн 150 мянган өрх нь бол гадаадад амьдарч байгаа. Тэгээд үлдсэн 850 мянган өрхийн 250 мянга орчим нь мал аж ахуйн салбар дээр ажиллаж байгаа. Тэнд ажлын байрыг бий болгож тэр нутагтаа амьдраад явж байгаа, энэ салбарыг авч явж байгаа хүмүүс. Тэгээд энэ хүмүүс бол төрөөс мөнгө төгрөг, цалин авдаггүй ийм л хүмүүс байгаа. Тэгээд ер нь бол энэ сүүлийн 40 жил болоогүй айхтар зуд боллоо. Тэгээд энэ малчид маш их хүндэрч байна. Яг залуу малчид бол ямар бодолтой болчихсон бэ гэхээр яришиг больё, ерөөсөө энэ цаг уур нь ч хэцүүдлээ,

малын бэлчээр нь ч даац нь хэтэрлээ, тэгээд төр засгаас ч нэг их дэмжихгүй юм байна, ерөөсөө хэдэн малаа зараад ерөөсөө хот руу оръё гэдэг яг ийм бодол дээр оччихсон, яг ингээд нугарлын цэг дээр байгаа. Тийм учраас төрөөс тодорхой хэмжээгээр энэ малчдын талаар тодорхой бодлого явуулахгүй бол ерөөсөө болохгүй байгаа.

Тэгээд энэ малчид чинь хот руу ороод ирвэл яах юм. Хотын түгжрэл нэмэгдэнэ, утаа нэмэгдэнэ, дээрээс нь одоо хотынхны хэрэглэдэг махны үнэ нэмэгдэнэ, хөдөө орон нутаг, тал нутаг эзгүйрнэ. Тэрнээсээ болоод тусгаар тогтнолын асуудал яригдана. Маш тийм хортой, нөлөөтэй байхгүй юу даа. Ер нь бол Монголчууд бол нэгнийгээ одоо хүнд хэцүү үед нь байнга тусалж дэмждэг. Жишээ нь, 2012-оос 16 оны хооронд барилгын салбарт зуд нүүрлэхэд тийм ээ, уналтад орж эхлэхэд ипотекийн 3,6 их наяд төгрөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, тэр салбарыг аварч байсан ийм түүхтэй. Тэгээд өнөөдөр Улаанбаатар хотынхондоо төрөөс бас маш их дэмжлэг үзүүлдэг. Жишээ нь 2 их наяд төгрөгөөр ковидын үед хүнд хэцүү байхад нь 2 их наяд төгрөгөөр цахилгааных нь мөнгө төлж өгсөн, усных нь мөнгийг хэдэн 100 тэрбумаар нь төлж өгсөн, тэр хогийнх нь мөнгийг хэдэн арван тэрбумаар нь төлж өгсөн. Улаанбаатар хотын унааны мөнгийг жил болгон хэдэн 10 тэрбумаар нь хөнгөлж өгдөг ийм одоо хөнгөлөлтүүдийг маш их өгдөг. Тэгээд Улаанбаатар хотынхон дүүргүүдээр бол маш их тийм хоолны мөнгө, өдөр болгон хоолны талон өгдөг.

Гэтэл хөдөөгийн сумууд бүгдээрээ хоолны талоноосоо татгалзъя, авахгүй байя гэдэг ийм юм руу яваад 5, 10-хан хүнд өгдөг байсан тэр нь одоо бараг болж байна шүү дээ. Ийм байдлаар бол ер нь бол Улаанбаатар хотынхондоо бас Монголын төр бас тодорхой хэмжээгээр дэмжлэг тусалцаа үзүүлдэг. Тэгээд яг энэ хэцүү үед нь энэ одоо зудтай байж байгаа энэ 40 жил болоогүй энэ гай

гамшигийн үед энэ малчдадаа туслах ажлыг, ялангуяа 1,2 их наяд төгрөгийн зээлийг тэглэх ажлыг бас манай хотынхон ойлгож бас энэ дээр зөвөөр хандана гэж би харж байгаа. Энэ маш их олон малчид малгүй болсон байна шүү дээ. Тэр Увс аймгийн Давст сумд 90 мянган толгой малтай, тэрний 22 мянган толгой мал нь одоо хорогдчихоод байж байна шүү дээ. Тэгээд цаашаа одоо нэлээн ядарсан мал их байна, төл мал, төл байхгүй ийм хүнд үед нь бас тодорхой хэмжээгээр энэ малчдын зээлийг тэглэх асуудлыг шийдэх хэрэгтэй.

Тэгээд тэрний дагуу орж ирж байгаа тэр мал аж ахуйг, Уламжлалт мал аж ахуйг дэмжих тэр хуулийнхаа дагуу бас тодорхой зээл өгнө гэж байна. Тэгэхээр эхлээд тэр зээлийг нь тэглэж, тэр хүмүүсийг зээлийнх нь барьцаа хөрөнгийг нь гаргаж ирж байж, тэрний дараа зээл олгох ёстой байхгүй юу. Тэгээд барьцаа байхгүй, мал нь хорогдчихсон тэр хүмүүсийг зээлийг нь тэглээгүй байж байхад банк зээл өгөхгүй шүү дээ. Тэгэхээр ийм одоо уялдаатай бодлогыг авч асуудлыг шийдвэрлэхгүй бол болохгүй нь гэж үг хэлмээр байна.

**Нэг.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

**Г.Занданшатар:** Хэлэлцэх асуудалдаа орно. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын

гишүүн Цагаанхуугийн Идэрбат танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Идэрбат:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулаа. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Ажлын хэсэг үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-д заасныг баримтлан 1 саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дэмжлээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан

даргалагчаас өгснийг Ажлын хэсэг төслийн холбогдох хэсэгтэй уялдуулж саналаа татаж авсан болно. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулга зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хоршооны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Даишээгвийн Амарбаясгалан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд, Хаянгаагийн Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Найманжингийн Ариунбат Монголбанкны Бүтцийн өөрчлөлтийн газрын дарга, Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, Даваасүрэнгийн Батсүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Оюунчимэг гишүүнээр тасалсан. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууя.

**Ц.Даваасүрэн:** Та бүгдийн энэ өдрийн амгаланг эрье. Энэ уламжлалт мал аж ахуйтай холбогдолтой орж ирж байгаа хууль бол маш чухал хууль. Би 2 зүйл дээр бол их чухал гэдгийг онцолж хэлмээр санагдаж байна. 1 дүгээрт болбол бид нар өнөөдөр дан ганц уул уурхайгаас хамааралтай эдийн засгаа олон талт болгоход бидний ганц хийж чадах зүйл бол хөдөө аж ахуй буюу тэрэн дотроо мал аж ахуй. Бидний үйлдвэрлэж чаддаг зүйл бол мал аж ахуй. Нөгөө талаараа энэ мал аж ахуй дээр байгаа малчид буюу яг энэ малын захад өсөж байгаа хүүхэд гэдэг болбол төрсөн нутагтаа, тэр төрсөн нутагтаа өсөж байгаа энэ залуучууд болбол энэ хотод өсөж байгаа хүүхдүүдийг бодоход илүү эх орондоо хайртай, байгаль дэлхийдээ хайртай. Тийм учраас өнөөдөр Монголын энэ бас цаашидын тусгаар тогтнолын нэг баталгаа байсаар ирсэн. Цаашидаа ч байх ёстой улсууд бол малчид. Тэнд өсөж байгаа, өсөж торниж байгаа энэ хүүхдүүд би дахин хэлье. Тэд бол төрсөн нутагтай. Тийм учраас тэд бол төрсөн нутагтаа хамгаалахын төлөө байдаг эх орончид байдаг юм. Тэгээд энэ талаас нь бид харах ёстой.

Бид энэ эдийн засгаа харах юм бол өнөөдөр бас аюултай, эрсдэлтэй дүр төрхүүд бий болчихсон. 23 онд бид нар 13, 15,3 тэрбум долларын экспортын орлого олсон. Үүний 13,8 тэрбумыг нь зөвхөн Хятадаас, зөвхөн Хятадаас нэг орноос экспортын хувьд 91 хувийн хамааралтай улс. Тэгэхдээ тэр 13,8 тэрбум долларын 8,9 нь ганцхан нүүрснээс, тэгээд бид нар төсвөө яасан 2 дахин өсгөсөн. 12 их наядын төсвийг 24 их наядын төсөв болгосон. Тэгээд үндсэндээ ганцхан бүтээгдэхүүнээс хамааралтай эдийн засагтай нүүрснээс. Хэрвээ нүүрсний үнэ унах юм бол, дэлхийн зах зээл дээр хямрал болох юм болбол

манай эдийн засаг маш хүнд байдалд орно. Яагаад гэвэл ганцхан нүүрсээс хамаарч байна шүү дээ.

Тийм учраас энэнээс бид нар эрсдэлээ бууруулъя гэдэг юм уу, энэ зөвхөн нэг эдийн засгаас 90 хувь гаруй хувийн хамааралтай болсноо бууруулъя гэх юм бол ерөөсөө л мал аж ахуй. Тэр дотроо органик мал аж ахуй. Манай мал аж ахуй болбол бусад орны мал аж ахуйг бодоход органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, олон өвсний мал. Тэрнээс гарч байгаа тэр мах, тэрнээс гарч байгаа сүү болбол хүнд маш их хэрэгцээтэй эрдэс бодис агуулдаг ийм бүтээгдэхүүнүүдийг гаргадаг. Дэлхий дээр өнөөдөр энэ ийм олон саяараа ийм мал аж ахуй байхгүй. Бусад газар болбол наад зах нь бэлчээрийн ч гэлээ гэсэн хөрснийхөө нянг устгаж байдаг. Монголд бол яах вэ, өвөлдөө -60, 70 градус хөрс нь хөлдөхөөр тэр нян нь хөлдчихдөг, хавартаа турсан мал шинэ өвс иддэг, шинэ хүч авдаг, шинэ органик мах үйлдвэрлэдэг, шинэ сүү гаргадаг. Тийм учраас энэ гайхамшигтай энэ хөдөө аж ахуйн бид нар энэ органик хүнсний энэ давуу талаа л бид ашиглаж чадах юм болбол энэ эдийн засгийн хамаарлуудаа бууруулна. Бид нар энэ хамаарал гэдэг юмнаас их болгоомжтой байх ёстой.

Хойд хөршөөсөө болохоор эрчим хүч, тэгээд түли шатахууны хамааралтай. Нэг түли нийлүүлэхгүй болоход л энэ бүх юм дуусна. Тийм эрсдэл дор бид амьдарч байна шүү дээ. Урд хөршөөсөө экспортын орлогоор 90 хэдэн хувь хамруулчихсан. Тэгээд төсвөө нэг жилийн дотор 2 дахин нэмчихдэг ийм улс хаана ч байхгүй. Энэ их нэмэлт, энэ их өссөн эрэлтийг бид нар нэг жижигхэн ганцхан ширхэг нүүрсний үнэ унахад л бид нар өнөөдөр будаа болохоор байна шүү дээ. Дуусахаар байна шүү дээ энэ эдийн засаг чинь. Тийм учраас энэ бүгдээсээ одоо энэний ард алгуур гаръя гэж бодвол бид нар энэ хөдөө аж ахуйг анхаарахаас өөр арга байхгүй. Тэр тусмаа энэ жил болбол хөдөө.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Даваасүрэн гишүүнд 1 минут нэмж өгье, асуултаа гүйцээе.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр энэ ялангуяа бидний энэ органик хүнсний үйлдвэрлэлийн чиглэл дээр ер нь цаашидаа, бид нар яах вэ ингээд мал аж ахуйгаа энэ өвлийн саяын хүндрэл дээр болбол бас нэг өөрөөр авч явах шаардлагатай гэдгийг ойлголоо. Тэгэхээр одоогийн орж ирж байгаа төсөл дээр бол бид ингээж ойлгоод байгаа шүү дээ. Ер нь энэ өвлийг даван туулахад мал аж ахуй дээр зарим нэг жишээлбэл энэ бэлчээрийн хувьд нь өөрчлөлт хийхгүй бол болохгүй нь гэж. Тухайлбал, хэдэн га газарт бид нар жишээлбэл ногоон тэжээл тарих боломжийг олгох вэ? Сая хэлэлцүүлгийн явцад энд өөрчлөлт оров уу? Нөгөө өмнө нь хагалж байсан газарт л олгоно гээд ингэхээж байна уу, аль эсвэл бид нар ер нь болбол өвөлжөөнийхөө ойролцоо нэг 3-5 га-д ногоон тэжээл тариалах боломжийг олгож байна уу? Ингээж чадах юм бол бид нар мал аж ахуйгаа өвөлд нь болбол аваад гарч чадна. Өнөөдөр энд тэнд үер болж байна, дэлхий дулаарч байна, гамшиг болж байна. Тийм учраас бид нар энэ гамшигийн эрсдэлийг давахын тулд ийм л арга хэмжээ.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Даишээгийн Амарбаясгалан дарга Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариулна.

**Д.Амарбаясгалан:** Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Ер нь хоршоонд нэгдээд, хоршоо мал аж ахуйн үйлдвэрлэл явуулах зориулалтаар 5 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар нэг удаа үнэ төлбөргүй авах эрхтэй болж байгаа. Уг газар болбол дан ганц ногоон тэжээл тарих зориулалтаар биш, ногоон тэжээлээ тарьж болно, мал аж ахуйн анхан шатын үйлдвэрлэл эрхлэх боломж нөхцөлийг хангаж болно, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг хийж болно гэдэг ийм агуулгаар явж байгаа. Зарим төрлийн хоршоо

малын ногоон тэжээл тариалах зориулалтаар хоршоо байгуулагдах бас боломжтой. Тэдгээр хоршоо болбол өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуулиараа сум орон нутагтайгаа гэрээ хийж, урт хугацаанд ашиглах боломжийг болбол нээлттэй бүрдүүлж байгаа. Энэ чиглэл мэдээж газар олголттой холбоотой асуудлыг сум, аймаг орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нь уялдуулж Засгийн газар байршилыг нь батлахаар болбол Газрын тухай хуулиараа зохицуулагдаж байгаа. Тэгэхээр тэр зарчмаар бол асуудал шийдэгдээд явна.

Ер нь мал аж ахуйн салбарын тухайд дан ганц мэдээж малчин гэж харахаас илүүтэйгээр мал бүхий иргэд, малын эмч, мал аж ахуйн салбарт оролцогч нар бүгдээрээ энэ хөдөлгөөнд болбол хамрагдах бүрэн боломжтой байх ёстой. Энэ нөхцөлийг хангаж өгөх юм болбол хөдөө орон нутагт энэ ажлын байр бий болох, эдийн засгийн эргэлт нь сайжрах, мал аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд үзүүлдэг нөлөөлөл богино хугацаанд нэмэгдэх энэ нөхцөлүүдийг болбол бүрэн тооцож судалсан байгаа. Засгийн газраас бас энэ хуулийн төслийг өргөн барихаас өмнө малчдын дунд социологийн судалгааг хийж үзсэн. Малчдын хувьд үндсэндээ энэ хоршоо байгуулж, хамтарч хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг шууд дэмжиж байгаа хувь нь болбол 66 хувьтай. Ер нь дэмжих талдаа байгаа нь 14 хувьтай гээд буюу нийт дүнгээрээ судалгаанд оролцогчдын 80 хувь нь дэмжиж байгаа юм.

Тэгээд бидэнд өнөөдөртөө нэг удаадаа хөнгөлөлт үзүүлэх, буцалтгүй тусламж үзүүлэх гэдэг асуудлаас илүүтэйгээр цаашидаа бид урт хугацаанд мал аж ахуйн салбарыг дагнаж явахад орлого сайжрах, амьдралын чанар дээшлэх нөхцөлийг хангах зорилгоор Улсын Их Хурал, Засгийн газраас бодлого гаргаж, түүнийгээ хэрэгжүүлээч л гэдэг асуудлыг ярьж байгаа юм. Мэдээж өнөөдөр тулгамдсан асуудалтай

холбогдуулан өр зээлийн асуудал ярьж байгаа боловч өрөө тэглэлээ гээд маргааши бид яаж амьдрах вэ гэдэг асуудлыг үндсэндээ малчид болбол ярьж байна. Сая бас Улсын Их Хурлын гишүүд тойргоороо явж иргэдтэй уулзаж бас санал онолын сонсож, нөхцөл байдлыг хэрхэн шийдвэрлэх тал дээр бол нэлээн олон талаас болбол ярилцсан байна лээ. Голчилж ярьж байгаа зүйл болбол мэдээж цаашидаа бид яах вэ. Энэ салбар нийлж нэгдэж, хамтарч илүү үр бүтээлтэй, бүтээмжтэй байх нөхцөлийг яаж бий болгох вэ гэдэг дээр болбол илүү төвлөрч ярьж байна лээ гэдгийг бас хэлье.

**Г.Занданишатар:** Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

**Д.Ганбат:** Та бүхнийхээ амар амгаланг айлтгая. Энэ хуулийг бол дэмжиж байгаа. Тийм. За яах вэ, ерөнхийдөө бол мянган жилийн өмнө ямар байсан энэ манай уламжлалт мал аж ахуй яг л тийм л байгаа юм л даа малчид. Энэ бэлчээрийн мал аж ахуй ийм л байсан, одоо ч ийм л байгаа. Гэхдээ өнөөдөр Монголчууд бол махны хэрэглээгээрээ бол дэлхийд бол эхний 3-т л ороод л явж байгаа л даа. Ийм чанартай сайн мах идэж байна. Энэ бол бэлчээрийн мал аж ахуйн давуу тал. Зардал өртөг мах багатай байдаг. Эрдэлтэй тал нь бол байгаль орчны, байгаль цаг уурын өөрчлөлтөөс болоод нэлээн хэцүүдэж байна. Бэлчээрийн даацад 2 бодлого л байсан юм Монгол Улсын төрөөс. эг нь бол ардчилал ялаад мал эзэндээ очсон. Энэ 25 саяас дээш гардаггүй байсан мал бол ингээд 70, 80 сая хүрсэн. Нөгөөдөх нь анх Үндсэн хуулийг баталж байхад манай нэлээн олон нэгдлийн дарга нар сонгогдож ирээд, мал бол төрийн хамгаалалтад байна гэсэн ийм л 2 заалт байгаа. Тэгээд энэнээс өөр дорвитой өөрчлөлтүүд ерөөсөө хийгдээгүй.

Та нар маань 8 жил засаг төр барилаа. Тэгээд та нарын явуулж байгаа бодлогыг хараад манай Их Хурлын дарга

тэр индэр дээрээс нэг П гээд хэлж байсан даа. Тийм. Яг л бүгдийг нь харж байгаад л тэгж хэлж байгаа байхгүй юу манай малчид маань одоо, ард түмэн маань. Иймэрхүү л бодлого, шийдвэртэй л ингэж үргэлжиллээ. Нэг олигтой үйлдвэр завод ашиглалтад орсонгүй, баахан пакет хийж мөнгө төгрөг ингээд л идэж уугаад л таарсан. Малаас гарч байгаа түүхий эд эргэлтэд орсонгүй. Өнөөдөр бол манай Монгол Улсын эдийн засгийн 10 хувийг бол хөдөө аж ахуйн салбар хангаж байгаа. Ажлын байрны бол 21,6 хувь нь байгаа, 300-гаад малчин өрх байгаа.

Тэгээд техник технологи, дэвшил хөгжиж байна. Дэлхий нийтээрээ хотжих процесс явж байна. Тэгээд өнөөдөр бол залуу малчид маань гэр бүл зохиох, орчин үеийн аятайхан амьдрал ахуйд яах тал дээр бол дутагдалтай байна. Тэр инновац шингээсэн 21 дүгээр зуунд ийм бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ талаар одоо хийж хэрэгжүүлж байгаа юм байна уу, судалгаа байгаа юу? Одоо өвөлжөө хаваржаа байхгүй, нүүдэл суудал хийгээд явах тийм газаргүй болсон. Тэгээд салхины өмнөөс шүлсээ хаяж байгаа юм шиг л ийм бодлого хэрэгжүүлж байна. Баруунтан, зүүнтний нугалаа гээд түүхэнд байсан. Энэ нугалаа ахиад давтагдах вий. Нөгөө хувьчилсан малыг эзэндээ оччихсон малыг ахиад нэгдэл нийгэм гээд баахан бужигнуулаад ингээд үлдэх вий.

Тэгээд Монгол Ардын намын нэг хэдэн нөхдүүд зээл аваад, нөгөө малчдад нь хүрдэггүй, ингэж болохгүй. Тэгээд дараа нь одоо тэгс ингэс хийгээд өнгөрдөг. Тэр ялыг нь малчид үүрдэг, өр зээлийг ийм байж таарахгүй шүү. Ийм нугалааг олон жил юу явуулаад сурчихсан ийм нам л даа танайх та нар. Тэгээд мал бүхий иргэд гэж байгаа. Мал бүхий иргэд чинь одоо энэ олон мянган малтай энэ Их Хурлын гишүүд чинь багтаж байгаа юу, ямар байгаа вэ? Эд нар бас баахан хөнгөлөлттэй зээл туух уу, авах л байх л даа. Тэгээд л яаж ийгээд л өөрсдийгөө л багтаах юм. Одоо тэр бүх юманд л.

Тэгээд намайг асуухаар та нар хариулдаггүй шүү. Уул уурхай, бэлчээрийн мал аж ахуй 2 бол одоо нэг саванд багтахад маш хэцүү.

**Г.Занданиатар:** Даишээгийн Амарбаясгалан дарга хариулна 3 номер.

**Д.Амарбаясгалан:** Ганбат гишүүнээ, уучлаарай, их харамсалтай байна. Та мал аж ахуйн салбарыг хөгжүүлж болохгүй гэдэг үг хэлж байна шүү дээ. Хотжих ёстой гэдэг үг хэлж байна шүү дээ. Яагаад та ийм үг хэлж байгааг одоо гайхаж хүлээж авч байна. Мал аж ахуйн салбар малчид нэг жоохон чинээлэг болчихоосой гэж бодож хөтөлбөр хийж байна гээд танилцуулаад яваад байх тусам зориудаар энэ хөтөлбөрийг мушгин гуйвуулж байна. Малчдын малыг нийлүүлж, нэгтгэж хоршоо байгуулах гэж байгаа зүйл огт байхгүй. Шинээр мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх зорилгыг агуулж, хөрөнгө оруулалтын зээл олгох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс энэ хуулийг оруулж ирж хэлэлцүүлж байгаа.

Мал аж ахуйн салбар Монгол Улсын нийт газар нутгийн 72 хувийг бэлчээрийн зориулалтаар ашиглаж байна. Монгол Улсын нийт ажиллах хүчний 24 хувийг мал аж ахуйн салбар бүрдүүлж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 10 хувийг мал аж ахуйн салбарын орлогоор бий болгож байна. Тэгэхээр энэ мал аж ахуйн салбар өөрөө хөгжих зайлшгүй шаардлагатай болсон. Өнөөдөр Монгол мал малаас дунджаар 31 долларын орлогыг бүрдүүлж авч чадаж байна. Шинэ Зеланд улс 20 жилийн өмнө нэг малаас 59 доллар олдог байгаад бидний яг энэ хэрэгжүүлэх гэж байгаа либералчлалын бодлогыг мал аж ахуйн салбартаа нэвтрүүлж чадсаны үндсэн дээр 20 жилийн дараа нэг малаас олдог орлого нь 353 доллар болж өсөн нэмэгдсэн. 2000 онд Шинэ Зеланд улсын малын тоо 56 сая орчим байсан. Гэтэл 20 жилийн дараа тоо буурч, чанар нь сайжирсан байна. Энэ үзүүлэлт сайжирсан.

2 дугаарт таны асуугаад байгаа, өчигдөр ч бас асууж байсан. Бэлчээрийг яах юм бэ, бэлчээр хүрэхгүй байгаа учраас та нар хоршоо хийх гэлээ гээд та бас өчигдөр бухимдал илэрхийлж байсан. Бэлчээрийн даац хэтэрчихсэн учраас мал аж ахуйн салбарыг тооноос илүү чанарт шилжүүлэх ёстой. Нэг малаас олдог орлогыг нэмэгдүүлэх ёстой. Бэлчээрийн хүрэлцээ хангалтаа сайжруулах ёстой гэж. Бэлчээр хүрэлцэхгүй байгаа 2 шалтгаан байгаа байхгүй юу. 1 дүгээрт малчид маань олон тооны малтай байж арилжааны банкнаас хэрэглээний зээл авах боломжтой байдаг. Тийм учраас тоогоо нэмэгдүүлдэг. 2 дугаарт малынхаа тоог олон болгож байж өнөөдөр амьжиргаагаа залгуулж байгаа нөхцөл үүсчихсэн учраас малчид олон тооны малтай байх гэж зориод байгаа.

Тэгэхээр энэ нөхцөлийг өөрчлөх буюу цөөн тооны чанартай малтай, нэг малаас олдог орлого нь өнөөдөр 31 доллароор хэмжигдэж байгаа бол бид энийг богино хугацаанд 2-оос 3 дахин нэмэгдүүлэх тэр нөхцөл рүү л анхаарлаа хандуулж байгаа юм. Тийм учраас энэ хууль цаг үргэлж хэрэгжиж байх шаардлагатай учраас хугацаа тавихгүйгээр оруулж ирж батлуулж байгаа юм. Цаашидаа Засгийн газрууд хөтөлбөрийг тухайлан гаргаж хэрэгжүүлдэг байх ёстой. Харин энэ хөтөлбөр, энэ бодлого урт хугацаанд тогтвортой байж мал аж ахуйн салбар, малчин хүний амьдралын баталгаа хангагдана гэж ингэж үзэж байна.

Мал бүхий иргэн гэдгийг зөв ойлгох ёстой юм байгаа юм. Мал бүхий иргэнд малын эмч багтдаг, мал бүхий иргэнд хөдөө сумд, аймагт ажиллаж, амьдарч байгаа иргэд багтдаг. Тэдгээр иргэд өөрөө энэ хөтөлбөрт хамрагдаж байж, мал аж ахуйн салбарын оролцогч болж байж энэ салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэх учиртай. Гэтэл энд зүгээр хий хоосон улс төрийн үүднээс мал бүхий иргэн нь нэг морьтой, нэг хоньтой, нэг үхэртэй хүн багтаж байна гэдэг

нэрийдлээр хасаж байгаа байдал нь бас л мал аж ахуйн салбарын оролцогчдын тоог цөөрүүлэх, илүү бизнес хийх, хөрөнгө оруулалт хийх боломжийг нь хумигдуулсан ийм л үйлдвэр болж, үйлдэл болж байна. Эмч нар нийлээд мал эмнэлгийн хоршоо байгуулж болох тэр боломжийг хаасан.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн 1 минут.

**Д.Ганбат:** Манай дарга нар битгий бухимдаарай тийм, аядуу жсоохон зөөлөн байж үзэцгээгээрэй. Уул уурхай, бэлчээр 2 чинь бэлчээрийн мал аж ахуй 2 чинь нэг саванд багтахгүй байна л гэж би хэлээд байгаа. Нөгөө гүний усыг нь хэрэглээд байхгүй болчхож байна. Эмзэг бэлчээрийг үгүй хийчхэж байна тэр зам тээвэр нь нааш цаашаа яваад. Ийм хүнд нөхцөл байдалтай байна.

Тэгээд залуу малчдаа бол бид нар бол сүүлийн 8 жил бол ерөөсөө тоохгүй орхичихлоо шүү дээ. Тэгээд сонгууль болохоор л гэнэтхэн санаад ингэж байгаа. Тэгээд энэ зээлийг ямар ч жижиж бага юм байсан бүгдийг нь би дэмжиж байна малчдад очих юмыг бол. Гэхдээ бодлого энэ тэр чинь бол жсоохон буруу яваад байна. Энэ талаар одоо ярья гэвэл бараг 2 өдрийн лекц та нарт унших байх. Угаасаа тэгээд нөгөө нэг тийм коммунист маягийн улсууд чинь тэр талаараа л хандах юм байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Мал аж ахуйн салбарыг сайжруулах гээд байгаа санаачилга нь бас сайн байна. Харамсалтай нь яг цаг үеэ олоогүй, энэ мал аж ахуйн салбарт салбар дээр тулгамдаад байгаа энэ асуудлынхаа эрэмбийг ер нь яагаад олохгүй байгаа юм бэ? Өнөөдөр Засгийн газар энэ гамшигтай нүүр тулахгүй байх юм. Ингээд тойрч зугтаагаад асуудлынхаа ар дээр нь гарахгүй. Өнөөдөр идэх хоолныхоо тухай бодож байгаа малчид,



тэр залуу малчдын асуудал үнэхээр хүнд байна шүү дээ. Арай чүү гэж малын захтай болоод, тэгээд өнөөдөр малаа бүгдийг нь энэ гамшигт алдчихсан, тэгээд цаашидынхаа амьдралыг яаж авч явах вэ гэдэг асуудлыг олон мянган залуучууд ингээд бодоод сууж байхад өнөөдөр ингээд бүүр эцсийн шийдлийн асуудлуудыг оруулж ирчхээд ингээд хэлэлцээд сууж байна. Ер нь малчдын зээлийг тэглэх асуудал дээр ер нь Засгийн газар ер нь ямар бодлого бариад байгаа юм бэ, энэ талаар ер нь хэлэлцэж ярилцаж үзсэн үү?

2-т нь өнөөдрийн энэ малаа алдчихсан хүмүүс энэ хоршоо байгууллаа гэхэд хар листэд орчхоод яаж зээл авах юм, энэ талаар та нар ер нь тооцож үзсэн үү? Өнөөдөр Хөдөө аж ахуйн тэр дэд сайд залуу ярьж байна лээ. Хоршоонд орсон малчин болгонд 50 сая төгрөгийн зээл өгнө л гэж байна. Тийм боломж бас байгаа юм уу? Тэгээд тэр мөнгөөрөө юу хийх гэж байгаа юм, энэ талаар та нар ямар нэгэн зураглалгүй орж ирээд байна.

2-т нь энэ хууль чинь одоо Монгол Улсад хэрэгжиж байгаа бүх хуулиудыг зүгээр нийлүүлээд тавьчихсан л хууль байна шүү дээ. Юун Засгийн газрын бүрэн эрх, юун асуудал хариуцсан төрийн төв байгууллага гээд. Засгийн газар, энэ Хөдөө аж ахуйн яам 2 чинь салчихсан юм уу? Энэ асуудлуудаа яагаад ингээд тусад нь оруулж ирээд ингэж явж байгаа юм бэ? Ер нь одоо ингээд та бүхэн бод доо ерийн хорогдол нь, ердийн хорогдол чинь 6 хувь байдаг. Өнөөдөр Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад маш олон сумдууд нь 50-аас дээш хувийн хорогдолтой байгаа. Тэгээд энэ асуудал дээр энэ гамшиг дээрээ та нар ямар нэгэн тусгайлсан бодлого байна уу? Зөвхөн нийгмийн сэтгэл зүйг ингээд зээл өгнө гээд хаана гэвэл энэ чинь маш буруу шүү. Энэ явахгүй шүү.

Өнөөдөр Хэнтий аймгийн энэ гишүүд бас энэ асуудлаа яагаад ярихгүй байгаа юм, Дорнодынхон яагаад ярихгүй, яагаад зөвхөн Сүхбаатар аймаг яриад

байгаа юм бэ? Хэнтий аймгийн тэр Хэрлэн голын урд талын сумуудын ердийн хорогдол чинь, зудын энэ гамшигийн хорогдол чинь 50-аас дээш хувь энэ тэр гарчихсан байдаг юм шүү дээ. Тэгээд ингээд бүгдээрээ нийлээд энэ асуудлаа ярихгүй. Бид зөвхөн ингээд нэг Сүхбаатарынхан энэ асуудлыг шийдэх гээд байгаа юм шиг ийм буруу ойлголт бас төрүүлээд байх юм. Дорнод аймагт ч гэсэн 50 хүртэл хорогдолтой зөндөө л сумууд байна лээ шүү дээ. Тэгээд энэ дээрээ та нар эхлээд энэ гамшиг энэ чинь зүгээр нэг зуд биш байхгүй юу даа. Энэ гамшигийнхаа ар дээрх асуудлаа нэг ярьчихмаар байх юм. Тэгээд дараа нь энэ сайн сайхнаа ярья.

Ер нь Монгол Улсын Засгийн газар олон улсын төсөв төсөөлөл, олон улсын хөнгөлөлттэй, хөнгөлөлтгүй баахан зээлээр өнөөдөр бид нар энэ хоршооны асуудлыг 30 хэдэн жил ярьсан. Энэ чинь зүгээр шинэ сэдэв бас биш байхгүй юу. Тухайн үедээ эдийн засгийн хөшүүрэг хийгээд өгөхөөр хоршигдог юм. Тэгээд тэр нь байхгүй болчхонгуут эргээд бие даасан амьдрал руугаа орчихно. Өнөөдөр манай малчдын ер нь хамгийн их хүсдэг нь өөрсдийн гэсэн бие даасан аж ахуйгаа хөтлөх ийм зорилт олон жилийн энэ мянга, 5 мянган жилийн энэ туршид хийгдсэн өөрсдийнх нь тэр уламжлал нь өөрөө энийгээ ингээд болохгүй байгаад байна шүү дээ. Одоо бид нар нэгдэл гээд 70 жил бүүр хүчээр хийгээд болоогүй эдийг өнөөдөр бид нар бас ярьж л байгаа байхгүй юу.

Үнэхээр хийе гэж бодож байгаа бол, тэр үнэхээр эдийн засгийн хувьд нийлээд үр ашигтай байх тэр хөшүүргүүдийг нь бид нар хийж өгөөд, тэр нь өөрөө юу вэ гэхээрээ энэ хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний үнийг чөлөөл, энэ махныхаа үнийг чөлөөл, битгий төр оролц. Тэр ноолуурынх нь үнийг бас одоо эргээд 7 сарын 1-нд бас нэг арга хэмжээ авч байгаа шүү дээ. Тэрний ар дээр эргээд өөр юм болно шүү. Одоо энэ.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Даишээгвийн Амарбаясгалан дарга хариулъя.

**Д.Амарбаясгалан:** Малчдын зээлтэй холбоотой асуудлыг шийдвэр гаргаад Монголбанк, арилжааны банкнууд хэрэгжүүлээд эхэлчихсэн байгаа. Зээлийн эргэн төлөлтийг малчдад гаргасан хүсэлт гаргасан өдрөөс нь хойш нэг жилээр хойшлуулах, нэг жилээр хойшилж байгаатай холбогдуулаад хуримтлагдах хүүгийн 75 хувийг төр төсвөөс, татвар төлөгчдийн мөнгөөр төлнө. Үлдэгдэл 25 хувийг малчин өөрөө төлнө. Ер нь яах вэ, сонгууль ойртчихсон учраас зээл тэглэх асуудлыг та ярьж байгаа гэж би бас ойлгож байна. Зээл тэглээд, зээл тэглээд малчид цаашаа яаж амьдрах вэ гэдэг асуудлыг бодохгүй байна. Жоохон өргөн хүрээгээр харах нь зүйтэй болов уу.

Мал аж ахуйн салбарт өнөөдрийн Засгийн газраас хэрэгжүүлэх гэж байгаа шиг хөрөнгө оруулалтын зээлийн боломж өнөөдрийг хүртэл гараагүй. Гаднын зээл, тусламжаар тодорхой хэмжээнд хорших, нөхөрлөх тэр боломж нөхцөлийг хангах үүднээс тодорхой хэмжээний багахан хэмжээний хөшүүрэг өгч байсан. Өнөөдөр жишээ нь Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас сум болгонд орон нутгийн хөгжлийн сангаар нь дамжуулаад багахан хэмжээний хоршооны дэмжлэгийн мөнгө очиж байгаа юм. Нэг сумд дунджаар 20, 30 сая төгрөг л очиж байна. Сум болгон дээр бас байхгүй. Тэгэхээр 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийгээд малчин мал аж ахуйн салбарыг яаж сэргэ гэж хэлэх гээд байгааг ойлгохгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр хоршоо байгуулагдаад хэдэн гишүүнтэй байхаас хамаараад 2 тэрбум төгрөг хүртэл хэмжээний хөрөнгө оруулалт хийх боломжийг энэ хөтөлбөр бий болгож өгөх юм. Тэр хоршоонд хэдэн гишүүн байхаас хамаараад нэг гишүүн нь хэдэн төгрөгийн зээл авах боломжтой вэ гэдэг асуудал хөндөгдөнө.

2 дугаарт өнөөдрийг хүртэл малчид мянган малтай байж 10 сая

төгрөгийн л зээл авдаг, тэрнээс илүүг авч чаддаггүй. 200 малтай малчин хүн 2 сая төгрөгөөс илүү зээл авах боломжгүй. Тийм учраас энэ хуулиар Зээлийн батлан даалтын сангийн баталгаа өгөх боломжийг нэмэгдүүлээд, мянган малтай хүн мянган малаа барьцаанд тавиад 50 сая төгрөгийн зээл авах боломжийг нь нээж өгч байгаа юм. 200 толгой малтай малчин 30 сая төгрөгийн зээл авах боломжийг нээж өгч байгаа юм. Энэ боломжийг богино хугацаанд эргэлтэд оруулж чадсанаараа, мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг хийж чадсанаараа анхан шатын боловсруулалт, үйлдвэрүүд бий болоод нэмүү өртөг нь малчны хотонд, сумд шингэж үлдэх боломжийг бий болгож өгч байна. Дунд шатын үйлдвэрүүд, боловсруулах үйлдвэрүүд бас хэд хэдээр ашиглалтад орж байна. Гэхдээ л тэр үйлдвэр бизнесийн байгууллагууд учраас илүү ашигийн төлөө ажилладаг. Малчдаас авч байгаа мал, малын түүхий эдийг хамгийн хямд үнээр авах л нөхцөлийг бий болгож байгаа.

Тэгэхээр малчдын гар дээр яаж нэмүү өртөг шингэж үлдэх боломж байна вэ гэдгийг эрэлхийлж энэ хөтөлбөрийг, энэ хуулийн төслийг батлаад цаашаа Засгийн газар хөтөлбөрөө баталж хэрэгжүүлэхийг зорьж байгаа юм. Ингэж чадсанаараа малчид сумдаа малаа үйлдвэрийн аргаар нядалж чаддаг болно. Энэ хууль батлагдсаны үр дүнгээр ноолуур нэгхэн ижил үнээр зарагддаг биш ангилан ялгагдаад, олон төрлийн үнээр зах зээл дээр гарч борлуулагддаг болох боломжийг нээж өгч байгаа юм. Сүү, сүүн бүтээгдэхүүн зөвхөн зун, намрын цагт хийгддэг биш, жилийн 4 улиралд сүү, сүүн бүтээгдэхүүн сумын түвшинд боловсруулалт хийж, зах зээл дээр гардаг байх тэр боломжийг бий болгож өгч байгаа юм. Ингэж байж Монгол Улсын хүнсний салбарын тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ бий болно. Ингэж чадаж байж мал, мах, түүхий эд үнэд орж, өгөөжөө малчны хотонд өгөх юм.

**Г.Занданшатар:** *Наянтайн Ганибал гишүүн тодруулъя.*

**Н.Ганибал:** *Үгүй ээ үгүй цаасан дээр биччихээд тэрийгээ тайлбарлах бол амархан. Яг бодит амьдрал дээр шал өөр шүү. Өнөөдөр сум хөгжүүлэх сангийн мөнгийг хоршооны гишүүнд өгнө гээд одоо нэг ч хүн авч чадахгүй байгаа шүү дээ. Та хэд ер нь мэдэж байгаа юу? 2 жилийн туршилагатай хоршоонд өгнө гээд заачихсан. Тэгээд авч чадахгүй байхгүй юу. Одоо дээрээс нь хэрвээ тэр 200 малтай хүн 30 саяын зээл авч болох юм бол заавал энийг хоршооны гишүүн болгож яах гээд байгаа юм бэ? Өөрсдөө аваад юмаа хийг л дээ. Өнөөдөр бид нарт тэр 9 мянган менежер чинь олдохгүй шүү, 9 мянган менежер. Та нарын тооцоолсон тоогоор хоршооны бүх гишүүд нэг, нэг хоршоон дээр зээл авна, хадгаламж зээлийн хоршооны араас оров. Зүгээр л ингээд нэг мөнгө тараах гээд байна шүү дээ, ингээд нэг зээл гээд. Тэрийг чинь менежерүүд байхгүй хоршоо гэдэг чинь болдоггүй байхгүй юу даа. Энэ чинь дандаа сайн менежертэй хоршоо цаашаа явдаг болохоос зүгээр нийлсэн болгон ингээд зээл авбал, энэ чинь бүтээнэ, хийнэ гээд олон асуудал байна шүү дээ. Энэ чинь хадгаламж.../минут дуусав/*

**Г.Занданшатар:** *Дашзэвгийн Амарбаясгалан дарга хариулна 3 номер.*

**Д.Амарбаясгалан:** *Та малчдыг чадваргүй, мэдлэггүй гэж бас ингэж гүтгэж болохгүй шүү. Мал дээр байгаа малчдын Монгол ухаан бол ер нь танаас, биднээс илүү ухаантай, илүү цөлөх гэж бид ярьдаг. Малчдад байна шүү дээ өнөөдөр боломж нь олдохгүй байна. Хөрөнгө оруулалт хийх боломж нь олдохгүй байна. Энэ боломжийг өнөөдөр Улсын Их Хурлаар энэ хуулийг батлуулаад, Монгол Улсын Засгийн газраас гаргаж өгч байна. Малчдад хөрөнгө оруулалт хийх боломж байсан бол өнөөдөр мал аж ахуйн үйлдвэрлэл ямар түвшинд хүрчихсэн байх ёстой вэ гэдгийг та мэдэж байгаа байх гэж би*

*бодож байна. Тэгэхээр малчдыг мэдлэггүй, чадваргүй, тийм учраас зээл өгөөд нэмэргүй гэж хэлсэн үгээ та харин буцааж авах ёстой шүү. Би харин энэ үгний чинь төлөө таны тойрог дээр чинь очиж малчидтайгаа нийлж жагсана шүү.*

**Г.Занданшатар:** *Одоо болно. Одонгийн Цогтгэрэл гишүүн.*

**О.Цогтгэрэл:** *Чимээгүй байж байгаарай. Энэ хуультай бас ингээд танилцаж байгаа. Уламжлалт мал аж ахуйг байгаль цаг уурын хамаарлаас хамгаалах гэдэг уг нь их чухал агуулга. Гэтэл орж ирж байгаа хуулийнх нь үзэл санаа үнэндээ хорлонтой, үнэндээ авах юм байхгүй нэг ийм хууль орж ирж байна. Бараг энэ хуулийн нэрийг уламжлалт мал аж ахуйг социалист тогтолцооноос нь салгах гэдэг нэртэй хууль уг нь энэ хуулийн нэр ийм нэртэй баймаар байна. Яг малчдын орлогыг, тэр чөлөөт үнийг бүх зүйлийг нь хаачихсан, тэр малчдыг та нар Монголын хөдөөг харж хамгаалж байх ёстой бараг харуулууд шүү гээд хөөрөгдчихсөн. Монголын уламжлал соёлыг тээж явах хүмүүс шүү гээд хоосон хошиг, социалист хошируулалт нь хэтэрчихсэн энэ явж ирсэн энэ тогтолцоог бид нар яаж өөрчлөх юм, яаж энийг эдийн засагжуулах юм гэдэг чиглэлд үнэндээ энэ хуульд чинь авах юм үнэндээ алга. Үнэндээ энэ зүйл алга.*

*Ямар ч шинэ зүйл энэ хууль дотор байхгүй байна. Яг одоо ч гэсэн Сум хөгжүүлэх сангийн мөнгийг сум хөгжүүлэх сангийн дэмжлэгийн зээлийг хоршоодод өгнө гэсэн тэр хууль, бодлого хөтөлбөр чинь одоо ч гэсэн 2, 3 жил үргэлжлээд явж байгаа шүү дээ. Энэний үр дүн нь хаана байгаа юм, энэний үр дүн, эргэн төлөлт ямар байгаа юм, найдваргүй зээлийн хувь ямар байгаа юм маш өндөр байгаа шүү дээ яг үнэндээ. Яагаад гэвэл бодлого нь буруу учраас энэ чинь бас ингэж явагдаад байна шүү дээ. Тэгээд энэ арга барилдаа хүрэхийн тулд сонгуулийн өмнө нэг ийм санхүүгийн*

механизм ашиглаж мөнгө тараахын тулд, мөнгө тараахын тулд Монгол Улсын бүхий л хууль тогтоомжийг одоо бүгдийг нь уландаа гишгэсэн.

Төсвийн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль энэ бүгдийг баримтлах ёстой Монгол Улсын Улсын Их Хурлын бүрэн эрхийг уландаа гишгэж, яг 2, 3 жилийн өмнө Ковидын үеэр нэг ийм хууль гаргаж байсан нэг удаагийн хууль гэж. Тэр хуулийн дагуу ямар их завхрал болж, энэний тайланг тавь гэж бид бүгд Улсын Их Хурал дээр өнгөрсөн хугацаанд чадлаараа нэхээд одоог хүртэл ямар ч тайлан байхгүй. Яг тэр Ковидын хуулийн 2 дугаар хувилбарыг одоо баталъя, бүх эрхийг Засгийн газарт өгчихье. Энэ Улсын Их Хурал гэж ер нь байгаад хэрэг байгаа юм уу? Төсөв баталдаг. Тэр Төсвийн тогтвортой байдлын хууль, өр зээлийн босго хэмжээг бүгдийг нь харгалздаг энэ хуулиудыг хэрвээ энэ хуулиудтай зөрчилдвөл тэр Төсвийн хууль энэ тэрийг баримтлахгүй гэж байгаа юм. Ийм хууль гэж бас байж болохгүй шүү дээ.

Үндсэндээ нэг ийм зорилго нь аргаа зөвтгөдөг, гоё уриа лоозон тавьчхаад, тэрэндээ хүрэхийн тулд бусад хохирч байх, хууль, эрх зүйт ёс нурж байхыг хамаагүй гэж үздэг энэ чинь яг л коммунист л арга шүү дээ. Социализм байгуулахын тулд хүн амынхаа бараг 10 хувийг ...чихье, энэ болбол зорилгодоо хүрч байвал хамаагүй гэдэг социалист арга шүү дээ энэ чинь, тэгээд.

Төгсгөлд нь яг энэ 5 их наядын зээл гэдгийн чинь цаана эдийн засгийн ямар утга байгаа билээ? Монголын хөдөө аж ахуй чинь GDP-ийнхээ 10 хувьд хүрчихсэн хөдөө аж ахуй шүү. Газар тариалантайгаа нийлээд. Энэ чинь одоо үндсэндээ 6, 7-хон их наяд болчихсон. Үндсэндээ 5, 6-хан их наяд болчихсон, 6-хан их наяд болчихсон тэр хөрөнгө бүхий тэр салбарт 5 их наядын зээл шууд цутгаж өгнө гэдэг чинь үндсэндээ яг энэ тогтолцооны чинь дараа малчдад

өнөөдөр байгаа 1 их наядын зээл чинь 5 дахин их өртэй л болох гэж байна. Энэний цаана шинэ техник технологи, know how, тэр эрчимжсэн мал аж ахуй, энэ олон, олон зүйлүүд, тэр малчдын орлого руу нь хандсан бодлого чиглэл энд чинь өгүүлбэрт чинь үнэндээ алга.

Хоршоог дэмжиж байна л гэнэ, яг одоо ч гэсэн байгаа хууль хоршоог дэмжиж л байгаа хууль байгаа шүү дээ. Төсвийн хууль, Сум хөгжүүлэх сан олон, олон зүйлүүд. Тэгэхээр үнэндээ энэ хууль болбол үнэхээр утга агуулгын хувьд үнэхээр тийм маш их асуудалтай ийм хууль болчихлоо. Бас нэг зүгээр л нэг социалист тархи угаалт, социалист пропаганда гэж хэлдэг зүйлийн нэг хэсэг болсон ийм хууль орж ирж байгаад асар их харамсаж байна.

Тийм учраас Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ хууль дээр ажлын 3 хоногийн завсарлагаа авъя. Бид бүгд бас ирэх 1 дэх өдрийн бүлгийн хурлаараа асуудлаа ярилцъя. Хууль санаачлагчтай дахин бас асуудлыг тодруулж ярилцъя. Ажлын хэсэгтэй нь ярилцъя. Үнэхээр маш чухал өөрчлөлт хийгдэх ёстой зарчмын өөрчлөлт хийгдэх ёстой.../минут дуусав/

**Г.Занданиатар:** Хаянгаагийн Болорчулуун сайд ажлын хэсгийн гишүүн хариулъя. Үгүй ээ, чи баахан асуулт асуучхаад асуултын цагаар.

**Х.Болорчулуун:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн цас зудын байдлыг мэдэж байгаа. Энэ болбол жалгын нэг натурал аж ахуйтай малчид болбол цас зудыг давж чадахгүй гэдэг нь одоо амьдрал дээр харагдлаа шүү дээ. Тийм ч учраас одоогийн байдлаар 6, 7 сая мал хорогдчихоод байна. Тэгэхээр бид нар энэ цас зудны эсрэг, аливаа ер нь хүн төрөлхтөн болбол бэрхиээлийн эсрэг бол нэгдэж нийлж байж гардаг болохоос ганцаараа яваад гардаггүйг бүгд мэдэж байгаа. Тийм учраас нэгдэж нийлэх хөшүүргийг л төр засгаас бас

хөшүүрэгдэж энэ хуулийг оруулж байгаа юм гэдгийг хэлье.

2 дугаарт малчид нэгдэж нийлж хоршоо байгуулснаараа өвс хадлан, тэжээлийн ургамал тариалах энэ болгон дээрээ болбол, энэ болгон хангагдаж, бэлтгэх боломжтой болно. Нөгөөтээгүүр түүхий эд, арьс шир, ноос ноолуураа хоршоо болсноороо болбол зах зээлд гаргах ийм боломжтой болно. Хөдөө аж ахуйн бирж дээр ч гэсэн харьцахад малчин болгон 200 мянган малчин болгон харьцаж чадахгүй шүү дээ. Хоршоо болж байж энэ нэгдэж нийлж зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулах ийм боломжтой болж байгаа юм. Тийм ч учраас зайлшгүй цаг үе маань болбол нийгэм энэ цаг агаарын байдал хүртэл энэ нэгдэж нийлэхийг л шаардаж байгаа болохоор энэ хоршооны хуулийг, хоршоог дэмжсэн бодлогын хуулийг оруулж байгаа юм. Түрүүний тэр 5 их наяд болбол нэг дор гаргах эд биш. Урт хугацаандаа 5 их наяд зарцуулах ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг бас хэлэх байна.

**Г.Занданишатар:** Дашизэвгийн Амарбаясгалан дарга хариулъя. Доржханд гишүүн Эдийн засгийн байнгын хороо орж байна уу.

**Д.Амарбаясгалан:** Ардчилсан намын бүлгийн дарга завсарлага авъя гэж байх шиг байна. Тэгээд мэдээж улс төрөө мэдэж байгаа байлгүй дээ. Тэгээд өчигдрөөс хойш энэ хууль батлагдах гээд явахаар Ардчилсан намын зарим гишүүд нь орж ирж бас уурлаж бухимдаад болж өгөхгүй юм. Мал аж ахуйн салбар Монгол Улсыг өнгөрсөн цаг үед нуруун дээрээ үүрч тэжээж ирсэн. Өнөөдөр ч мал аж ахуйн салбар хөгжиж дэвжиж яваа. Цаашид дан ганц уул уурхайгаас хамааралтай бус улс болохын тулд мал аж ахуйн салбарын сэргэлтийг бодлогоор дэмжих зайлшгүй шаардлагатай байгаа.

Харамсалтай нь мал аж ахуйн салбарт цас зудын нөхцөл байдал,

хүндрэл бэрхшээл ирсэн байгаа энэ цаг үе дээр хэрэгжүүлэх гэж байгаа хөтөлбөрийг батлах, энэ хэрэгжүүлэх энэ хуулийг батлахад олон талаар саад учирч байгаад үнэхээр харамсалтай байна. 5 их наядын хөтөлбөрийг нэг өдөр хийх гэж байгаа зүйл биш шүү дээ. Урт хугацаандаа мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх бололцоог нь урт хугацааны бага хүүтэй зээлээр бий болгож өгч байгаа хөтөлбөр. Малчид үүгээр алдаж онох бүх боломжоо олж авах ёстой. Ингэж байж мал аж ахуйн салбар босож ирнэ. 90-ээд онд Монголчууд өөрчлөлт шинэчлэлт хийсний ард дээр бүгдээрээ ганзагын наймаанд явж, нэг хэсэг нь сайхан чинээлэг бизнесменүүд болж хувирсан. Нэг хэсэг нь боломжийн амьдралаа залгуулуулж явдаг хэлбэрт шилжиж чадсан. Малчдад энэ боломж өнөөдрийг хүртэл гараагүй.

Энэ хууль батлагдаж, энэ хөтөлбөр хэрэгжих болсноор энэ боломж мал аж ахуйн салбарт, малчдад бий болж очиж байгаа юм. Энийг ойлгохгүйгээр жадлан эсэргүүцэж, энэ хуулийн хэрэгжилтийг удаашируулах зорилго агуулж завсарлага авч байна гэдэг болбол та бүхэн ард иргэдийг төлөөлөх эрхэм үүргээсээ няцаж байгаа хэлбэр шүү гэдгийг зориуд сануулж хэлэх нь зүйтэй. Мал аж ахуйн салбар яаж хөгжих боломжтой вэ гэдгийг маргааш 10 цагаас 3 дугаар цахилгаан станцын хажууд Хөдөө аж ахуйн корпорацын хашаанд үзэсгэлэн зохион байгуулагдана. 21 аймгийн Хөдөө аж ахуйн газрын дарга, 21 аймгийн Тамгын газрын дарга нар, маш олон хоршоологчид ирж энэ ажилтай танилцана. Энэ салбарыг хэрхэн яаж хөгжүүлэх гэж байгаа вэ гэдгийг та ч бас маргааш очиж танилцаж үзээрэй.

**Г.Занданишатар:** Завсарлага авахаа больчихсон юм уу? Тэгвэл завсарлага авах болбол тодруулга байхгүй шүү дээ. Үргэлжлэх юм бол завсарлага авахгүй болно гэсэн үг. 1 минут Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Завсарлага авна шүү. Сая тэр Ардчилсан намын бүлгээс завсарлага авах гэсэн хүсэлтийг Их Хурлын дарга биелүүлж өгөхийг хүсье. Энэ дээр нэмээд одоо энэ хууль дотор чинь бас олон, олон тийм механик, олон, олон шийдэх ёстой олон асуудлууд байгаад байна. Механикаар хүмүүсийг нэгд гээд яг органикаараа, тэр бодлогоор, хөрөнгө оруулалтаараа, тэр ирж байгаа ашиг орлого дээрээ биш механикаар хүмүүсийг нэгдүүлээд зээлд түлхэх юм байна л даа. Тэгэхээр энэ эцсийн зээлийн хариуцлагыг хэн хүлээх юм, хоршоо гэдэг хууль, эрх зүйн этгээд хүлээх үү, хоршоонд хувь нийлүүлсэн нөхдүүд хүлээх үү? Хариуцлагыг нь яг хариуцлагын тогтолцоо энэний цаана яаж явах юм бэ? Би хоршоонд элсчихсэн, нөгөө манай хоршоо тэнд зээл авсан, манай хоршооны дарга тэнд зээлийн гэрээнд гарын үсэг зурсан. Энэний өмнөөс нөгөө нөхдүүдийн яг үүрэг хариуцлагууд юу болох юм гэх мэтийн энэний цаана чинь маш олон тийм тогтолцооны шинжтэй, маш олон тэр иргэдийн хувийн эрх, эрх ашиг, малчдын эрх ашгийг магадгүй дордуулж болох олон зүйл, заалтууд энэний.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Дашизэгвийн Амарбаясгалан дарга хариулъя.

**Д.Амарбаясгалан:** Цогтгэрэл гишүүнээ, хоршоонд нэгдэх хоршооны гишүүн сайн дурын үндсэн дээр л нэгдэнэ. Түүнээс бүгдийг нь механикаар, зохион байгуулалттайгаар гэдэг ойлголт ерөөсөө байхгүй. Та ингээд л ойлгочих. Мал аж ахуйн салбар өнөөдөр бараг 80, 90 хувьтай төрөөс хамааралтай байгаа зүйлийг, төрөөс огт хамааралгүй салбар төр бодлогыг нь гаргаж, хөрөнгө оруулалт хийх бололцоог нь олгож, дэмжиж либералчилж өгч байгаа гэдгийг л та ойлгох хэрэгтэй. Өөрөө өөрсдөөрөө хөдөлмөрлөж хөгжих, илүү чинээлэг сайхан амьдрах тэр боломж замыг нь нээж өгч байна.

Энэний үр дүнгээр малчны өнөөдөр сарын дундаж орлого 1 сая 500 мянга, дундаж зардал нь 2 сая 100 мянга, сар болгон 600 мянган төгрөгийн алдагдалтай амьдарч байгаа ийм хэлбэрийг өөрчлөөд, малчны сарын дундаж орлого 5 сая төгрөгөөс дээш болох боломжийг бүрдүүлнэ. Тэгж чадсанаараа малчид Монгол Улсын ядуу иргэдийн эгнээг бүрдүүлдэг биш, чинээлэг дундаж давхаргыг төлөөлдөг ийм хэмжээний хөрөнгө мөнгөтэй, амьдралын чанартай хэсэг болж хувирах юм. Өнөөдөр мал аж ахуйн салбар дээр сая гаруй мянган хүн ам амьдарч байна. Амьдралаа залгуулж байна. Энэ боломжийг бид малчдадаа өгснөөр хөдөлмөрлөх, хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх тэр нөхцөл бүрдэнэ гэдгийг бас танд хэлье.

**Г.Занданишатар:** Энэ асуудал Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн баригдсан, хэлэлцэх эсэх асуудлыг шийдэж байх үед энэтэй холбоотой ямарваа нэгэн завсарлагыг Ардчилсан намын бүлгээс аваагүй. Өнөөдөр Байнгын хорооны танилцах, танилцуулгатай холбогдуулж асуулт, хариулт явагдаж байгаа. Байнгын хорооноос болбол төсвийн зохицуулалтыг тухай бүрд нь Улсын Их Хуралд танилцуулна гэсэн саналыг нэмж оруулсан. 1 горимын зарчмын зөрүүтэй санал нэмэгдэж байгаа. Энүүгээрээ Улсын Их Хурлын төсвийн хяналт тавих эрхээ хэрэгжүүлж байгаа гэж үзсэн байгаа юм.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд оны 1 дүгээр улирлын байдлаар 6,3 сая мал хоргодсон байсан. Одоогийн байдлаар 7 сая мал хоргодоод байна. Нийт малчдын 80 хувь нь 500 хүрэхгүй толгой малтай, хамгийн их мал 42,5 хувь нь Сүхбаатар аймагт мал хоргодсон. Ингээд ер нь 7, 8 аймагт бол 12-оос 25 буюу улсын дунджаас их хэмжээний мал хоргодчихоод байгаа. Улсын дунджаар одоо 11 хувь нь, нийт малын 11 хувь хоргодчихоод байгаа. Тэгээд ийм яаралтай нөхцөл байдлын үед

ер нь энэ мал аж ахуйн ган, зудын эрсдэлийг давах чадавхыг бэхжүүлэх хамгийн гол хөшүүрэг нь хоршоолол юм. Хоршооллыг төрийн бодлогоор дэмжих зүйтэй гэсэн ийм зөвлөмжийг Азийн хөгжлийн банкнаас малын ашиг шимийн судалгаа болон бэлчээрийн мал аж ахуйн судалгаа хийгээд зөвлөмж өгчихсөн байдаг юм.

Тийм учраас энэ болбол зүгээр нэг санамсаргүй гэнэт босоод ирчихсэн асуудал биш. Олон улсын байгууллагууд ч гэсэн, малчид ч гэсэн энийг дэмжиж ярьж, Малчин өрхийн нэгдсэн холбоо энэ малчны хоршооллыг дэмжих гээд, Архангай аймгаас Жарантай гэдэг малчин өчигдөр ирж уулзсан. Энэ их зүйтэй санаачилга байна. Би ийм 10 гэрийн зохион байгуулалтад орно. Тэгээд ингээд малчид дэмжиж байгаа, болж байгаа ийм санаачилгыг байна шүү дээ, ийм санаачилгыг. Зээл олгохгүй. Үүгээр чинь дэмжиж байгаа юм. Тэгээд энэ асуудал чинь эмзэг асуудал. Тэр сумын Засаг дарга нь бурхан болчихсон юм, одоо тийм асуудлуудыг ярьж хэрэггүй.

Ийм учраас ийм яаралтай асуудал учраас Ардчилсан намын бүлэгт хэлэлцэх эсэх дээр яриагүй учраас 2 цаг хүртэл завсарлага өглөө. 2 цагийн завсарлага, 2 цаг хүртэл.

11.43 цаг

Өнгөрсөн долоо хоногт хэлэлцэхгүй яасан юм. Нэн яаралтай асуудал байна. Та хэд чинь энэ чинь гамшигийн онцгой, онцгой нөхцөл байдалд, гамшигийн онцгой нөхцөл байдалд яаралтай горимоор хэлэлцэх ёстой гээд танайх өөрсдөө хүртэл хууль санаачилчихсан явж байгаа шүү дээ. Тэр чинь хуулийн зөрчилтэй, нэг аравны, Засгийн газрын санал ч аваагүй. Бүрдүүлбэр дутуу.

Ингээд дараагийн асуудалд орно. Дараагийн, Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 24

оны Төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ундрам танилцуулна. Энэ Ундрам хаачсан юм бэ? Эдийн засгийн байнгын хороо хуралдаж дуусаж байна уу? Эдийн засгийн байнгын хороо хуралдахаар бусад асуудлуудаа хэлэлцье. Пүрэвдорж гишүүн гарч хэрэлд, эмэгтэй хүнтэй битгий ингэж хэрэлдэж, дээрэлхэж бай. Ингээд хэн танилцуулах юм бэ? Нэгдсэн холбоо, Эдийн засгийн байнгын хороо дуусаагүй учраас Нэгдсэн холбоо ярилцаж болохгүй болчихоод байна. Хэн танилцуулах юм бэ? Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэн танилцуулах юм бэ? Цогтгэрэл, Цогтгэрэл. Энэ асуудал танилцуулагч нь байхгүй тул хойшлууллаа.

**Хоёр.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл**  
/Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 3 дугаар сарын 21, 28-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 49 дүгээр захирамжаар хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, гурилын үнийг зохиомлоор нэмэгдүүлж байгаа эсэхийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Т.Энхтүвшин нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал өргөн мэдүүлсэн төсөл нь үзэл баримтлалтайгаа зөрчилдөж байгаа, гурилын үнэд бодитой тооцоо судалгаа хийсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс төслийн 1 болон 2 дугаар зүйлийн улаан буудайн гэсний дараах баяжуулсан гэснийг тус тус хасах, мөн хууль хэрэгжих хугацааг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх нь зүйтэй гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 48 минутаас хуралдааныг даргалав.

**Л.Мөнхбаатар:** Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Даишээгийн Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Довчинсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсувд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. Байхгүй байна. Байхгүй байна уу, дарсан юм уу? Энэ дээр яагаад гарч ирэхгүй байна. Ганибал гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ гурилын үнэтэй холбоотой асуудлаар би 2023 оны 10 сарын 5-ны өдрийн



хуралдаанаас эхлээд нийтдээ 7 удаа, 1 сарыг, 1 сарын 10 хэдэн хүртэл хэлсэн байна. Энэ жишээ нь Ховд аймагт ч юм уу, аль эсвэл авто тээврээр Ховд аймагт ирэх, Улаанбаатар хотод юу төмөр замаар энэ тээврээр ирэх 2 адилхан үнэтэй байдаг байхгүй юу. Тэгээд Новосибирскоос гурил аваад наашаа Улаанбаатарт авчрах, Ховд аймагт авчрах 2 яг адилхан үнэтэй, 55 мянган төгрөгөөр ард иргэддээ өгөх боломжтой байсан юм. Тэр үед Монгол гурилын үнэ 120 мянган төгрөг байлаа. Тэгээд энэ гурилынхаа импортыг нээгээч. Энэ ядарсан Монголчуудаа бага орлоготой, бага цалинтай төрийн албан хаагч нар, дээрээс нь бага тэтгэвэртэй ахмадууд энэ гурилын чинь үнэд нэрвэгдээд маш их хүнд хэцүү байна гэж зөндөө хэлсэн.

Зөвхөн гурил хэрэглээд хоолондоо хэрэглээд болчихдог юм биш, үүгээр чинь олон бүтээгдэхүүн хийж байгаа. Тэгээд энэ инфляцад ордог гол нэрийн бүтээгдэхүүн чинь энэ замбараагүй өсөөд, энэнээсээ болоод иргэдийн амьдрал хүндрээд байна гэж зөндөө хэлсэн. Гэвч ерөөсөө тоогоогүй. Тэгээд өнөөдөр энэ асуудлыг хэлэлцэж байгаа нь бол яах вэ дээ хөдөөгөөр нэг сайд нар хөдөөгүүр явсан л даа. Гишүүд хөдөөгүүр явсан, сонгууль дөхсөн чинь та нарыг ёстой нэг хариуг чинь өгнө л гэсэн байхгүй юу даа. Тийм учраас аргагүйн эрхэнд л одоо хэлэлцээд, энэ хуулиа батлуулж байна. Би батлуулж байгаа нь зөв л дөө. Дахиад л гурил, гурилын үнэ буурах юм чинь бас ард иргэддээ хэрэгтэй учраас би дэмжиж байгаа юм. Тэгэхдээ ард иргэддээ шулж, шулж, хамаг хормой хотыг нь байна шүү дээ бүгдийг нь суйлж, суйлж суйлчхаад, тэгээд өөрсдөө баяжиж авчхаад, тэгээд тэрний дараа ингэж шийднэ гэдэг бол үнэхээр хариуцлагагүй зүйл л гэж би хэлмээр байгаа юм.

Тэгээд энэ тэр нөгөө олон үйлдвэрүүд нь Ардчилсан намынх байна гэж нэг яриад байх шиг байгаа юм. Тэгэхдээ энэ чинь шийдвэр гаргадаг албан тушаалтнууд нь дандаа өнөөдрийн

эрх баригч нар шүү дээ. Тэгээд буруу болгоныг өөрөөр хэлбэл аливаад бараа, бүтээгдэхүүн үнэтэй бол тэрнийг нь импортлох зөвшөөрлийг нь олгох, татварыг нь бууруулах энэ бүх эрх нь бүгдээрээ эрх баригч нарт байж байхад үйлдвэрлэгч нар лугаа дайрч байгаа ийм тохиолдол бас байгаад байгаа юм.

Тэр тэгээд би энэ бас үйлдвэрлэгч нарт бас асуудал байна гэж үзэж байгаа. Яагаад гэвэл буудай тариалдаг хүмүүс нь урамишуулал авч байгаа, дээрээс нь үйлдвэрлэгч нар нь хангалттай хэмжээний зээл, хямдралтай зээл өгч байгаа. Тэгсэн мөртөө яагаад ийм үнэтэй байгаад байгаа юм бэ? Тэгээд энийгээ шалгаж тогтоох тэр ажлын хэсэгт болохоор намайг оруулахгүй байгаа л даа. Тэгээд Бат-Эрдэнэ гишүүн энэ тэр би ахлаад явж байгаа бас сүрхий гаргачихна гэж би харж байгаа. Уул нь намайг оруулчихвал би бол тэгээд хүний өөрийн гэхгүй арьсыг нь хуулаад өгөх байхгүй юу даа. Бат-Эрдэнэ гишүүн зөөлдчих вий л гэж бодоод байна.

Тэгээд ийм одоо ингээд нэг тийм сонгууль дөхөж байгаа. Тэгээд хэдэн жил өндөр үнэтэй гурил идчихсэн хүмүүсийг сонгууль дөхүүлэнгүүт нэг 2 сар хямд гурил идүүлээд л, тэгээд л сонгуульдаа орно. Тэгээд л бид нар ёстой сайхан санал авна даа гэж бодож байгаа бол эндүүрэл дээ л гэж хэлмээр байна даа.

**Л.Мөнхбаатар:** Асуулт мөн юм уу? Хариулт хариулах юм уу? Ажлын хэсгийн гишүүн Амарбаясгалан дарга товч хариулья. Ерөнхийдөө санал хэлсэндээ. Гурилын үнэ буулгахыг дэмжиж байгаа тухайгаа их олон талаас нь тайлбарлалаа.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвдорж гишүүний санал, асуулт бас дотор нь явчихлаа л даа. Яагаад нэмэгдсэн юм бэ гээд. 2019 онд гурилын салбарын үйлдвэрлэл 210 мянган тонн байхад гурил үйлдвэрлэгч нарын олсон орлого нь 240 тэрбум төгрөг, 2023 онд Пүрэвдорж

гишүүнээ 2023 онд үйлдвэрлэлийн хэмжээ 20 мянгаар буураад, 190 мянган тонн гурил үйлдвэрлэсэн. Олсон орлого нь 430 тэрбум. 2 жилийн дотор гурилын үнэ нугарсан. Энэний цаана одоо улс төрийн асуудал байх магадлалтай гэж ингэж харж байгаа.

Зарим нөхдүүдийг үгсэн хуйвалдсан гээд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас торгууль тавьсан. Шүүхэд өгөөд ахиад нэг жил хагасын хугацаанд гацаачихсан. Тэгэхээр энэ шийдвэр хэрэгжихгүй байгаа учраас Засгийн газраас импортын татварыг нь тэглүүлэх бодлогыг оруулж ирсэн. Тэгэхээр одоо Пүрэвдорж гишүүнээ танаас хүсэлт тавьж байна. Танай намын бүлгээс. Энэ малчны хоршооны асуудал, энэ гурилын асуудал гээд нэн тулгамдсан асуудлуудаар бага шиг улс төржөөд, завсарлага авахгүй үргэлжлүүлж өгөөч гэж ард иргэдийнхээ өмнөөс хүсэлт тавьж байна танд.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал асуултаа асууя. Пүрэвдорж гишүүн асуулт тавиад хариултаа авсан, чимээгүй байгаарай. Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Энэ одоо манай Хөдөө аж ахуйн сайд маань хэлчихсэн юм чинь бид нар чинь дэлхий дээр хамгийн үнэтэй гурил идэж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг чинь буулгахгүй бол болохгүй биз дээ. Тийм учраас бол энэ бодлогын арга хэмжээнүүд авах нь бол зөв л дөө, зөв. Харин газар тариаланчидтайгаа та хэд чинь ер нь асуудлуудаа яаж ойлголцсон юм бэ? Би энийг бүүр тодорхой асууя. Энэ жил ер нь яг улаан буудай тарих гэж байгаа яг хэдэн га байна вэ? Дээрээс нь тарьсан тэр улаан буудайг нь өнөөдөр яг та хэд экспортод гаргана гээд яриад байх юм. Яг улс орнуудтай хэлцэл хийчихсэн байна уу? 2-т нь рапс тарихыг хорьчихсон гээд нэг заалтууд байгаа шүү дээ. Тодорхой хэмжээнд тэдэн га-д нь нөгөө нэг рапсын хэмжээ гээд байгаа. Энийгээ та нар эргээж харсан уу? Яг газар

тариалангийнхан маань бас байр суурь 2 байх шиг байна лээ.

Мэдээж үйлдвэрлэгч нарт улаан буудайгаа шахаж байгаад үнэтэй зарья гэдэг оролдлого нь зөв л дөө. Гол нь энэ гаргаж байгаа арга хэмжээ чинь нөгөө нэг зах хязгааргүй, тодорхой хугацаагүй болоод ирэнгүүт нөгөө энэ үйлдвэрүүд чинь хөөрхий худалдаж авах чадамжгүй болно шүү дээ тийм үү? Үйлдвэрлэлээ багасгана шүү дээ. Тэгэхээрээ энэ дээр яг тэр нэг газар тариалангийнхандаа та нар бүүр нэг товч, тодорхой нэг хариултыг нь өгөөрэй. Одоо яг явж байгаа арга хэмжээ 2.

Ер нь нэг ийм юм байгаа юм. Энэ асуудлыг бас ингээд өмнө нь хэлсэн байхгүй юу. Одоо ингээд нөгөө хивгийн асуудал яригдаж байна шүү дээ. Хивэг ч одоо хэрэглээгүй болчихлоо шүү дээ. Ирэх цаг хугацаанд хэрэглэх л байх. Тухайн үед үндэсний гурилын үйлдвэрүүдийн хивгийг экспортод гарч байхад нь хорьчихсон. Тэр үед би хэлсэн байхгүй юу, үгүй ээ энийгээ явуулж бай, харин тэр гаднаас орж ирэх хивгийн импортыг зогсоочих, юу тэглэхч. Тэгэх юм бол тарифын зохицуулалт хийчих юм бол Оросоос бид нар бас хямдхан хивэг оруулаад ирнэ, зах зээлээ бас ингээд зөв зохицуулаад явчих ийм боломж байна гэж байсан. Тухайн үед бол ер нь хүчилсээр байгаад л ер нь нэг ийм үзэн ядсан байдалтайгаар л зогсоож л байсан л даа.

Одоо тэгээд хивэг нь хоорондоо өөр байдаг юм уу, ямар байдаг юм тэгээд, цаана нь эргээд бид нар бас нөгөө гурил үйлдвэрлэгч нартайгаа бас эргээж зөв харьцахгүй бол эргээд хохирогч нь бол манай тариаланчид болох магадлал бас өндөр байна шүү. Энэ дээр нэг та нар яг бүүр нэг гарц гаргалгаатай, сая Ерөнхий сайд очсон Солонгост оччихсон улаан буудай аваач гээд явж байх юм. Хэрвээ тийм байдалтай байгаа бол энэ асуудал чинь явахгүй, тийм. Энэ чинь чанар, стандарт, чийг, цавуулаг гээд маш олон зүйл, заалт протоколд тохирсны дараа

энэ чинь экспортын асуудал яригддаг болохоос амаараа очоод уулзаад гар бариад энэ болно гэж бодож байгаа бол энэ чинь бүтэхгүй асуудал шүү гэдгийг бас хэлье.

**Л.Мөнхбаатар:** Хэн хариулах юм бэ? Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Пүрэвдорж гишүүн зөөлдөнө байх эд нар гэж байх шиг байна. Пүрэвдорж гишүүнээ.../үг тасрав/

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүн сууж байгаарай, хариултаа сонсьё.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг ажилласан. Энэ болбол бас нэг төрийн зохицуулалт, зохион байгуулалтын хүрээнд ажилласан гэж ойлгож байгаа. Ер нь болбол төр аливаа зохицуулалтыг хийх ёстой. Нэн тэргүүнд гурилын үнэ ямар хэмжээнд байгаа гэдгийг бид нар тодорхойлох хэрэгтэй. Ард иргэддээ хямд гурил идүүлэх, хямд гурил хэрэглүүлэх энэ зарчим болбол хамгийн нэг номерын зарчим шүү. Нэг номерын зарчим.

Дараагийн асуудал болбол тариаланчид, дараагийн асуудал болбол гурилын үйлдвэрүүдийн асуудал. Өнөөдрийн одоо хэмжээнд үндсэндээ болбол дөрөвхөн үйлдвэрийн асуудал яригдаж байна шүү дээ. Дөрөвхөн үйлдвэр. Энэ болбол бид нарын зохицуулалт, зохион байгуулалтын байхгүй, төрийн зохицуулалт алдаатай байгаагийн шинж байхгүй юу. Дөрөвхөн үйлдвэр ажиллаж байна шүү дээ. Дөрөвхөн үйлдвэр болбол 70 гаруй хувийн энэ буудайг болбол хүлээн авч байгаа шүү дээ. Гурил хийж байгаа. Тэгэхээр ер нь бол яах вэ 12 үйлдвэр байгаа л даа. Тэрнээс яг гол авч байгаа нь болбол дөрөвхөн үйлдвэрийн асуудал байна шүү дээ.

Би болбол үндсэндээ мэдээллийг болбол төрийн байгууллагын мэдээлэл дээр үндэслэж ажилласан шүү ажлын хэсэг. Тийм болохоор ямар нэгэн хов жив, илүү дутуу юман дээр ажиллаагүй шүү, Пүрэвдорж гишүүнээ, Ганибал гишүүнээ. Тэгээд ер нь болбол энэ дээр хэд хэдэн асуудлуудыг шийдэхээр Улсын Их Хурлын тогтоолыг бас дагалдуулж оруулж ирж байгаа юм. Энэ дотор юу гэхээр 1 дүгээрт болбол наад зах нь гэхэд гурилын үйлдвэрүүд дээр ажиллаж байгаа лабораториудыг хөндлөнгийн итгэмжилсэн лаборатори болгох асуудлыг 1 дүгээрт ярьж байгаа юм. Энэ орж ирнэ.

2 дугаарт гурилыг буудай, буудайг ямар нэгэн байдлаар бид нар биржээр худалдаалдаг ийм зохицуулалтыг зөв зүйтэй зохицуулалтыг нь болбол бас энэ тогтоолоор оруулж ирэхээр зохицуулж орж бол ирж байгаа юм.

3 дугаарт ер нь болбол нийт буудайны 100-гаад мянган тонныг улс худалдаж авч нөөц байгуулъя. Энэ болбол олон улсад байдаг жишиг байхгүй юу. Тийм болохоор нөөц байгуулъя гэж байгаа юм. Элеваторын хувьд болбол 180 мянган тонныг авах элеваторын бид нар хүчин чадал улсад байгаа байхгүй юу. Энийг ашиглая, энийг нөгөө тариаланчдадаа ашиглуулъя, тариаланчдадаа ямар нэгэн байдлаар зохицуулалтыг нь өгөөд, тэр зөвхөн намар нийлүүлдэг биш, магадгүй элеватортоо хадгалж байгаад, дараа нь тодорхой хугацааны дараа зарах ийм боломж бололцоотой бас өндөр үнээр зарах боломж бололцоотойг нь хангая гэж байгаа юм.

Тэгэхээр энэ тогтоолын цаад утга нь болбол 1 дүгээрт болбол тариаланчдаа дэмжсэн, 2 дугаарт болбол бас гурилын үйлдвэрүүдээ болбол бас ингээд хаяхгүйхэн шиг тодорхой хэмжээнд аваад явах ийм боломж бололцоог хангасан ийм тогтоолын төсөл болбол дагаж орж ирэх юм

гэдгийг бас хэлье. Тэгээд ажлын хэсэг өөр бас нэмэлтээр хэлэх байх.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах уу? Ажлын хэсгийн гишүүн Амарбаясгалан сайд хариулъя.

**Д.Амарбаясгалан:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Гурилын үнэ өндөр байгаа. Ард түмэн хямдхан гурил идэх эрхтэй. Бид энэ нөхцөлийг хангаж өгөх ёстой. Ялангуяа та орон нутгаас сонгогдсон гишүүний хувьд орон нутгийн иргэдийн худалдан авч байгаа тор бүтээгдэхүүний 70-аас 80 хувь нь гурил болон гурилан бүтээгдэхүүн байдаг гэдгийг та мэддэг байх ёстой. Тийм учраас энэ үнийг буулгах зайлигүй шаардлага тулгарсан.

Газар тариалангийн салбарыг Засгийн газар орхигдуулахгүй. Сая Бат-Эрдэнэ гишүүн маш тодорхой хариулчихлаа. Энэ салбарыг жинхэнэ утгаар нь бизнес болгож өгч байгаа юм. Өнөөдөр гурилын үйлдвэрүүдийн хараат болчихсон газар тариалангийн салбарыг 400 мянган тонноос хэтрэхгүй үр тариа тарих нөхцөлд оруулчихсан байгааг өнөөдрийн Улсын Их Хурлын тогтоолоор нээж өгч байгаа юм. Хараат бус болгож өгч байгаа гэсэн үг. Монгол Улсын Засгийн газар стратегийнхаа нөөцөд 100 хүртэл мянган тонн улаан буудай худалдаж авах нөхцөлийг бий болгож өгч байгаа юм. Зах зээлийг нь тэлээд, экспортод гарах боломжийг нь нээж өгч байгаа юм. Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүнийг манай урд хөрш Бүгд Найрамдах Хятад Ард улсаас эхлээд хэрэгцээ шаардлагатай улс орон маш их байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тухайд жил болгон 12 сая орчим тонн улаан буудай нэг хувийн татвартайгаар импортоор авдаг. Тэр квотод Монголын тариаланчдын тариалангийн салбарынхныг хамрагдах боломжийг нь хангаж өгнө. Мэдээж дотоодынхоо үйлдвэрлэлийн хэрэгцээг хангасны үндсэн дээр илүүдэл улаан буудайг экспортод гаргах боломжийг гаргаж өгнө.

3 дугаарт нь гурилын үйлдвэрийн хараат байх нэг нөхцөлийг гурилын үйлдвэрүүд нь өөрийн лабораториор үр тарианы чанарыг тогтоодог. Тэгвэл өнөөдрийн энэ Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаар Монгол Улсын чанар, стандартын баталгаажуулалтын төв лабораториор улаан буудайн чанарыг тогтоодог болох нөхцөлийг бүрдүүлж өгч байгаа юм. Улсын хэмжээнд стратегийн нөөцөд тодорхой хэмжээний улаан буудай худалдаж авахтай зэрэгцээд улаан буудай биржээр худалдаалах нөхцөлийг нь өнөөдрийн Улсын Их Хурлын тогтоолоор хийж өгч байгаа юм. Биржээр нэг ёсондоо улаан буудай тарьсан тариаланчид маань гурилын үйлдвэрүүдэд очиж улаан буудайгаа гуйж зардаг байсан тогтолцоог нь биржээр гурилын үйлдвэрүүд нь өрсөлдөж улаан буудай худалдаж авдаг тэр тогтолцоог нь бий болгож өгч байгаа юм.

Ингээж чадсанаар улаан буудайн салбар жилдээ 400 гаруйхан мянган тонн улаан буудай тарьдаг биш, цаашилаад 2 сая, 3 сая тонн улаан буудай тарьдаг болох боломжийг бий болгож өгч байна. Энэ хэт их вакумжчихсан, монополд идэгдчихсэн салбарыг чөлөөлж өгч байна гэсэн үг. Үр дүнгээр нь жил болгон улаан буудайгаас 500 орчим сая долларын орлогыг экспортод гаргасныхаа төлөө олох нөхцөл бүрдэнэ гэж ингээж тооцож, энэ асуудлыг шийдвэрлэж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу? Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя.

**Н.Ганибал:** Үгүй ээ, үгүй тодруулчихъя. Энэ яг одоо сая Амарбаясгалан сайдын хэлж байгаагаар сайхан юм ярьж л байна л даа. Яг одоогийн нөхцөлд өнгөрсөн цаг хугацаанд илүүдэл улаан буудайгаа хэдэн тонныг гаргасан юм бэ? Яагаад сая тэр гамигийн үеэр аймгуудад тэр задгай улаан буудайг авч очиж, малдаа өг гээд яагаад шахаад байсан юм бэ? Үгүй ээ,

тэр улаан буудайгаа гарга л даа. Үгүй ээ, үгүй, тэгээд та нар тэгж хадгалдаг л юм байна шүү дээ. Тэгээд яагаад ингээд бодит нөхцөл байдал та хэдийн яриа 2 чинь бүүр ингээд тэнгэр, газар шиг ялгаатай байгаад байгаа байхгүй юу. Хэдэн тонн улаан буудай Бүгд Найрамдах Хятад Ард улс руу өнгөрсөн 34 жил экспортолсон юм бэ, тоогоо өчих? Тэр өнөөдөр тэлээд гаргахад бэлэн байна гээд байх юм, тэр нь сав нь бэлэн байна гээд байх юм, яагаад гамшигийн үед малчдад улаан буудайг ирж аваад, тээвэрлээд, нунтаглаад өг гээд шахаад байсан юм бэ? Тэр улаан.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулъя. Ажлын хэсгийн гишүүн Амарбаясгалан сайд хариулъя.

**Д.Амарбаясгалан:** Ганибал гишүүнээ, та Хөдөө аж ахуйн яаманд бас газрын даргаар ажиллаж байсан хүн. Үгүй ээ, үгүй. Та мэдээлэлтэй байгаа гэж би, үгүй ээ, үгүй доромжлоогүй. Та мэдээлэлтэй хүн байна шүү дээ. Лоббид идэгдээд, салхи орохоо байчихсан салбарыг Засгийн газар өнөөдөр салхи оруулж задалж өгч байна. Энэ улаан буудайн салбар малчин, тариаланч 2 энэ салбартаа ажиллах тусам улам бүүр эрсдэлтэй, улам бүүр ядуурдаг энэ цаг нөхцөлөөс нь өөрчлөх гэж Засгийн газар энэ бодлогыг оруулж ирж байна. Ард иргэд хямдхан гурил идэх эрхтэй. Энийг нь бид хангах ёстой. Ингээд лоббид идэгдээд, хөдөлгөөнгүй болчихоод, янз бүрийн арга саамаар асуудалд хандаад байдаг нөхцөлийг нь таслан зогсоох бодлого орж ирж хэрэгжүүлэх гэж явж байна.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан асууя.

**Ц.Туваан:** Би энэ ажлын хэсэгт орж ажилласан. Тэгээд энэ дээр юу нэг юм хэлчихье. Ард түмнээ үнэтэй гурил идүүлэх гэсэн эрх баригч ч байхгүй, сөрөг хүчин ч байхгүй. Ер нь улс төрчид тийм бодол байхгүй. Тэгэхээр энэ дээр бол бас

ингээд олуулаа гээд ингээд нэг их сөрөг хүчин тэгж байна энэ тэр гээд байх хэрэг байхгүй. Бодитой юмаа ярьа хэдүүлээ энэ дээр бол.

Энэ асуудал дээрээс хонь бүрэн, чоно цатгалан гарч ирмээр байна. Тийм. Яагаад гэхээр наад улаан буудайн импорт гэдэг юм байхгүй гээд сая Ганибал гишүүн хэлж байгаа чинь зөв, үнэн шүү дээ. Бид нар өмнө нь үзсэн юм, бардаггүй юм, тийм юм байдаггүй юм. Одоо улаан буудай экспортолсон түүх ч байхгүй. Тэгэхээр асуудал нь өөрөө хүнд гээд эрүүл юмаа хэдүүлээ эрүүлээр ярьа. Нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолчих вий дээ. Атрын аянууд хэрэгжүүлж ирсэн энэ тариалангийн салбараа нокаутад оруулж, мэс заслын ширээн дээр унагаачих вий дээ.

Өчигдөр би ажлын хэсгээ төлөөлөөд төвийн бүсийн Монгол Улсын тариалангийн салбарын 80, 90 хувийг авч явдаг Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн тариаланчдын зөвлөгөөн дээр орж очиж тариаланчидтай уулзаж ирлээ. Яг үнэндээ бол энэ асуудалд аягүй дургүй байна шүү тариаланчид. Яагаад гэхээр тэд нар чинь аргагүй шүү дээ. Тэд нар экспорт байхгүйг мэдэж байгаа. Нөгөө хэдэн гурилын үйлдвэрийг царай алдаж, гурил юу улаан буудайгаа зарахаа мэдэж байгаа. Тэгэхээр тэд нарын хүсэл бол нэг л хүсэл байгаа. Энэ хаврын тариалалт эхлэхээс өмнө улаан буудайн үнээ зарла гэдэг хүсэлт. Засгийн газрын тогтоол дээр бид нар энийг хүссэн, Засгийн газрын тогтоол дээр орж батлагдаагүй. Аргаа бараад дараа нь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр би санал оруулж байгаад улаан буудайн үнийг ойрын хугацаанд зарлаа гээд Байнгын хороон тогтоол гарсан, 4 сарын 28-ны дотор улаан буудайн үнийг зарлахаар болсон. Тэгэхээр иймэрхүү, иймэрхүү байдлаар л хэдүүлээ юман дээрээ бодитоор хандъя.

Энэ өөрөө яагаад стратегийн хүнс юм бэ. Улаан буудай, улаан буудайн гурил яагаад стратегийн хүнс юм.

Яагаад гэвэл Монголчуудын түгээмэл түлхүү хэрэглэдэг 2 хүнсний нэг нь байхгүй юу. Мах, гурил. Мах, гурилтайгаа байвал бид нар нээрээ ямар ч эдийн засгийн хүндрэл, дайн байлдаан, тэр ковидын үед даваад л гарна. Тэгэхээр энэний нэг нь буюу гурил маань эрсдэлд орчих вий дээ. Яг гурил хийх гэсэн чинь будаагүй болчих вий дээ гэдэг л асуудлыг яриад байгаа юм. Энэ дээр бол ойлголцоод, дундуур нь шийдвэр гаргачихмаар байгаа юм.

2 дугаарт энэ Хүнсний аюулгүй байдлын зөвлөл гээд энийг чинь шийддэг газар байгаа. Хүнсний тухай хуульд энэ заалт орчихсон байгаа. Хэдүүлээ заавал энэ хугацаагүй, хэмжээ хязгаарын дээд талгүйгээр асуудлыг оруулж ирж ингэж шийддэг нь зөв үү, буруу юу, сайн л ярих хэрэгтэй. Тэгвэл яах гэж энэ салбарын яам байж байгаа юм. Салбарын яам чинь өөрөө бүх асуудлаа мэддэг яам чинь ондоо юу оруулж ирсэн байхгүй юу, санал. Тэр нь хэмжээтэй байя, хугацаатай байя гээд. Тэгэхээр энэ асуудлыг л хэдүүлээ нэг их одоо юу гэдэг юм яг голыг нь олоод, тунгийн нормыг нь тааруулаад л шийдчихмээр байгаа юм. Тэрнээс биш мэдээж энэ гурилын үнийг өндөр байлгая гэдгийг бодож байгаа сөрөг хүчин ч байхгүй, эрх баригч ч байхгүй. Энэ дээр бол хэдүүлээ ойлголцоод, асуудлаа яг эвтэйхэн дундуур нь зөв шийдчихмээр байна хамгийн гол нь. Тэгэхээр улаан буудайн энэ үнэ зарлалтын энэ асуудал байгаа.

Дээрээс нь энэ төвийн бүсийн тариаланчид бол хэлж байна лээ. Энэ жил бол онцгой сайхан жил. Одоо бол сайхан ногоо соёолчихсон байгаа. Газрын чийг хангалттай байна, цаг уурын төлөв байдал гоё байхаар байна. Гуурсанд тарьсан ч ургац авчихаар байна. Тэгэхээр их хэмжээний улаан буудай бид нар тарьж сурсан, тарина, энэ ургацаа авна. Тэгэхээр тэрнийхээ борлуулалтад санаа зовж байгаа энэ тариаланчдынхаа асуудлыг л хэдүүлээ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гишүүд танхимд орж ирье. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. 3 саналын саналаар санал хураалт явуулна. Гишүүд танхимд байраа эзлэе. Саяынх дээр хариулах юм уу? Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулъя. Дараа нь ажлын хэсгээс нэмж хариулах шаардлагатай бол хариулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Туваан гишүүн, Ганибал гишүүн хоёулаа л Хөдөө аж ахуйн яаманд ажиллаж байсан 2 шүү дээ. Тэгээд хамгийн гол нь бид нар хэрвээ хугацаатай, квоттой болгоно гэдэг болбол хэн нэгэнд эрх өгчхөөд байгаа шүү дээ хамгийн гол нь. Тэнд чинь лобби явчхаад байгаа байхгүй юу. Тодорхой хэмжээний хүмүүс, яг эрх мэдэлтэй хүмүүс гээд квот өгдөг. Тэд нар нь ашигладаг. Ийм зүйлээс зугтахын тулд, энэ зүйлээс бид нар тойрохын тулд өнөөдөр квотгүйгээр зүгээр хэн нэгэн чадалтай, боломжтой нь болбол оруулаад ирье гэсэн ийм нөхцөлийг л бид нар гаргаж ирж байгаа юм шүү.

Квот гэдэг юман дээр дандаа лобби явдаг. Квот гэдэг юман дээр дандаа нөгөө нэг ар, өврийн хаалга явдаг байхгүй юу даа. Тийм болохоор өнөөдөр хэдүүлээ нэг сайхан зүгээр нээлттэй байлгаад, квотгүйгээр, хугацаагүйгээр, нээлттэй ингээд зарлаад явчихъя л гэж байгаа юм шүү.

**Л.Мөнхбаатар:** Туваан гишүүний асуултад нэмж хариулъя. Ажлын хэсгээс Амарбаясгалан сайд нэмж хариулъя. Гишүүд байраа эзэлье, санал хураалтад.

**Д.Амарбаясгалан:** Туваан гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурал татвар тэглэх асуудлыг нь шийдвэрлэж өгсний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газар Хүнсний аюулгүй байдлын зөвлөлтэй жил бүрийн импортоор орж ирэх гурилын хэмжээг тогтдог байя. Хэмжээгүй зүйл бас биш. Орж ирж байгаа гурил гол нь гурилын салбарыг өрсөлдөөнтэйгөөр, үнийн зөв зохистой хэмжээнд хүргэх тэр

нөхцөлийг л хангаж өгөхөд орших юм 1 дүгээрт.

2 дугаарт та өнөөдөр энэ Улсын Их Хурлаар батлагдах гээд одоо хэлэлцэгдэж байгаа тогтоолыг та нэг тогтоод нэлээн сайн хараадхаарай. Тариаланчид энэ талын мэдээллийг аваагүй байгаа учраас өнгөц дутуу мэдээлэлтэй, зарим улс төрчид маань тэрэнд нь тааруулж ярьж явж байгаа учраас магадгүй зарим талаар эсэргүүцээд байхыг үгүйсгэхгүй. Ер нь болбол гурил хямдрах ёстой, тариаланчид хохирохгүй байх ёстой, салбар эрсдэлд орохгүй байх ёстой. Тэгэхээр энэ бүх нөхцөлийг Засгийн газар бодлогоор хангаж ажиллана гэдгийг бас танд албан ёсоор хэлье. Энэ бодлогоо тариаланчдад бас танилцуулж явна. Тийм учраас бас энэ хуулийг, энэ тогтоолыг цаг алдахгүй батлуулах зайлигүй шаардлага байна.

Таны хэлсэн үнэн. Юугаа тарих вэ, улаан буудайгаа тариад зарж чадах юм уу гэдэг эргэлзээ байгаа учраас энэ тогтоол, энэ шийдвэр нэг цагийн өмнө ч болсон гарч байж үр дүнгээ өгнө гэдгийг бас тийм. Үнэ зарлах асуудал Засгийн газраар шийдэгдсэн байгаа. Жил бүрийн 4 дүгээр сард багтааж Хүнс, хөдөө аж ахуйн сайд жишиг улаан буудайн үнийг зарлана. 8 дугаар сард өртөг дээр суурилсан үнийг албан ёсоор баталгаажуулж зарлана гэдгийг Засгийн газрын тогтоолоор шийдвэрлэсэн. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороогоор шийдвэрлэсэн байгаа гэдгийг бас та бүхэнд хэлье. Мөн, тийм.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Зарчмын зөрүүтэй 3 санал байна. Гишүүд суугаарай. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн улаан буудайн гэсний дараах баяжуулсан гэснийг хасах. Санал гаргасан улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Өнөрболор, Сандаг-Очир, Туваан, Энхтүвшин, ажлын хэсэг гэнэ цаашид. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүдээ. 55 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн улаан буудайн гэсний дараах баяжуулсан гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх. 3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ. Одоо энэ Байнгын хороо хуралдана.

12.19 цаг

**Гурав. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай”**

Дараагийнхаа асуудалд оръё. Дараагийнхаа асуудалд оръё гишүүдээ. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Наянтайн Ганибал гишүүн танилцуулъя. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

**Н.Ганибал:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг болон Монголбанкнаас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж, уг тогтоолын төслийг 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар Монголбанканд төвлөрсөн валютын нөөцийн талаар, Монголбанкны бодлогын хүүгээс шалтгаалан хадгаламж, зээлийн хүү өндөр байгаа нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учруулж байгаа тул бодлогын хүүг бууруулахтай холбогдуулж Монголбанкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Эрдэнэсийн сангийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн талаар болон Монголбанк, Монголбанкны салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байгаа талаар тус тус асуулт асууж, санал хэлсэн болно.

Тогтоолын төслийг хэлэлцэж, санал хураахад гишүүдээс тодорхой санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжиж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасныг баримтлан чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Монголбанкнаас ирүүлсэн санал болон тус саналыг үндэслэн Байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 24 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ганибал гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн захирал Пүрэвдоржийн Эрдэнэтуяа нар оролцож байна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Батиугар гишүүнээр тасаллаа. Байнгын хорооны дарга Энхбаярын Батиугар асуултаа асууя.

**Э.Батиугар:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Монголбанкны удирдлагууд ирсэн тул би бас цаг үетэй холбоотой асуулт асууя гэж бодож байна. Сая энэ 7 хоногт Монголбанкнаас мэдэгдэл гаргасан. Энэ нь нөгөө нэг бид нарын ярьдгаар хар жагсаалтад орсон болон чанаргүй, эргэлзээтэй зээлдэгч нарыг өршөөсөн тийм Монгол Улсын Монголбанкны Ерөнхийлөгчийн тогтоол гарсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор бас хэд хэдэн асуулт асууна гэж бодож байгаа юм.



Нэг нь болбол энэ тушаал болбол жижиг, хэрэглээний зээл авсан иргэдийг өршөөж гэж ойлгож байна. Тэр нь болбол юутай холбоотой вэ гэхээр гар утасны зээл аваад тодорхой хугацаанд төлж амжаагүй, тэгснээ эргэж төлчихсөн, мөн зээлээ төлчхөөд зарим тохиолдолд 5, 10 мянган төгрөгийн үлдэгдэлтэй зээлдэгч нар байдаг, тэрийгээ мэдэхгүй явж байгаад хар жагсаалтад орчихсон явдаг. Тэгэхээр энэ зээлдэгч нарыг Хөгжлийн банк болон Засгийн газрын тусгай сантай зээл авчхаад төлөхгүй байгаа, мөн хоцрогдож төлсөн иргэдтэй адилхан өршөөж байгаа юу, үгүй юү гэж хэлмээр байна. Яагаад гэвэл энэ бол шал тусдаа 2 зүйл л дээ. Хэрэглээний зээл болон жижиглэнгийн зээл болбол нэг ёсны амьдралд тохиолддог л зүйл. Үүнтэй холбоотой хэрэглэж зээлдээ төлж дууссаны дараа өршөөх улам илүү уян хатан тогтолцоонд оруулах нь зөв л дөө.

Харин Хөгжлийн банкнаас зээл авчхаад төлөхгүй байгаа хоцролт төлсөн, зориулалтын бусаар ашигласан, мөн Засгийн газрын тусгай сангаас авсан зээлдэгч нарыг болбол өршөөх нь би болбол буруу гэж бодож байгаа юм. Энэ бол шал тусдаа 2 зүйл. Бас энэ зээлийн мэдээллийн сан, тогтолцоо нь өөрөө өөрчлөгдөх цаг ирсэн гэж бодож байна. Хууль нь бол 2011 онд батлагдсан. Харин өнөөдөр 13 жил манай банк санхүүгийн салбар хэд дахин том болж өссөн. Мөн дэлхийн чиг хандлага ч өөр тийшээ явж байгаа. Тэгэхээр яагаад би ингэж хэлээд байгаа нь нөгөө өнөөдрийн тогтолцоо хэд хэдэн тийм доголдол байгаад байна. Мөн шударга бус зүйлүүд байгаад байгаа юм. 1 дүгээрт болбол энэ жижиг зээл авчихсан нөхдүүд ээ, яг одоо том системд эрсдэл авчрах зээлдэгчидтэй адилхан санхүүгийн 6 жилийн ял үүрүүлээд байгаа. Энийгээ илүү уян хатан хандах ёстой.

2-т нь болбол бас нэг хачирхалтай зүйл нь болбол энэ боловсролын зээлийн сан байгаа юм. Дотоодын 2 сая төгрөг авчихсан оюутнуудыг, залуучуудыг энэ

төлөхгүй байгаа, магадгүй ковидоос болоод ажлын байр олдохгүй байгаа залуучуудыг шууд энэ зээлийн мэдээллийн санд хар жагсаалтад оруулчхаад байгаа юм. Тэгсэн мөртөө хэдэн мянган долларын зээл авчхаад гадаадад сурчихсан, нөгөө гадаадад авчихсан нөхдүүдээ оруулахгүй байгаа нь болбол шударга бус хараад байгаа юм. Мөн зээлээ цаг хугацаанд нь төлөөд байгаа санхүүгийн сахилга баттай иргэддээ ямар ч урамшуулал байхгүй ийм нэг тогтолцоо байдаг юм байна л даа. Тэгэхээр зээлийн мэдээллийн сангийн аргачлалыг өөрчлөх цаг нь болсон байна. Мөн санхүүгийн дэлхийн санхүүгийн зөв аргачлалыг Монголд нутагшуулах нь зөв л дөө. Ингэж байж нөгөө 1 дүгээрт болбол жижиг зээл авсан, хэрэглээний зээл авсан нөхдүүдийг том Хөгжлийн банкны зээл авсан нөхдүүдтэй адилхан санхүүгийн ял үүрүүлэхгүй байна. 2 дугаарт зээлээ цаг хугацаанд нь төлөөд байгаа иргэдээ болон аж ахуйн нэгжүүддээ илүү урамшуулал өгөөд, магадгүй зээлийг нь илүү бага хүүтэй болгоод, барьцаа хөрөнгийг нь ч өөрөөр ханддаг болгоод ийм тогтолцоонд бол шилжих нь л зөв л дөө.

Тэгээд эцсийн үр дүндээ болбол санхүүгийн хүртээмжийг л нэмэгдүүлэх нь хамгийн чухал гэж харж байгаа юм. Мөн санхүүгийн хариуцлагатай иргэдийг Монгол Улсад бий болгохын тулд энэ зээлийн мэдээллийн сан дээр илүү credit score-ийн болон зээлдэгч нарын үнэлдэг, мөн эрсдэлийг нь үнэлдэг систем рүү шилжих нь зөв гэж харж байна л даа. Яах вэ, асуултыг болбол яг үүнтэй холбоотойгоор энэ өршөөгдсөн аль эсвэл мэдээллийн сангаас хасагдсан хэдэн иргэд байгаа вэ, мөн давтаж өршөөгдсөн иргэд байгаа юу, үгүй юү гэж асуумаар байна. Тэгээд энэ Боловсролын сангийн зээлийн талаар бас ямар өршөөл үзүүлэх вэ? Мөн гадаад.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван хариулъя.

**Г.Энхтайван:** Батиугар гишүүний асуултад хариулъя. Батиугар гишүүн зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хөндлөө. Ер нь бол зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох, иргэдэд ээлтэй нэг талаасаа, нөгөө талаасаа бас хариуцлагатай зээлдэгчийг төлөвшүүлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх асуудлаар энэ зээлийн мэдээллийн санг илүү боловсронгуй болгох асуудлаар бол Батиугар гишүүн нэлээн олон удаа хэд хэдэн удаа энэ бодлогын асуудал дэвшүүлж, 3 дугаар сарын сүүлээр бол Монголбанкн дээр ирж ажилласан. Яг энэ чиглэлээр бол бас асуудал хөндөж тавьсны дараа бол Монголбанкнаас бол шийдвэр гаргасан. Энэ дээр бол бид бүхэн бол 2024 оны 4 сарын 1-ний өдрийн байдлаар анхаарал хандуулах хэвийн бус, эргэлзээтэй болон муу зээлийн ангилалтай боловч зээл нь бүрэн төлөгдөж дууссан зээлдэгчийн зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд тусгахгүй байх шийдвэрийг бол гаргасан байгаад байгаа.

Тэгэхээр иргэд болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр бол энэ хар жагсаалт энэ тэр гэсэн тийм мэдээлэл бол гарсан байна лээ. Ер нь бол зээлийн мэдээллийн санд бол хар жагсаалт гэж байдаггүй. Энэ бол зөвхөн зээлдэгчийн зээл авсан мэдээллийг бол бүртгэдэг тийм сан байгаад байгаа. Тэгэхээр бол зээлээ бүрэн төлж дууссан боловч ангилал зөрчигдсөн зээлдэгчдийн мэдээллийг бол энэхүү сангаас бол тусгахгүй болсон байгаа байх. Тохируулгыг хийсэн.

Гишүүн тэр Боловсролын зээлийн сантай холбоотой мэдээллийг хөндлөө. Энэ дээр бол дотоодын их дээд сургуулиудад зээл авч сурсан оюутнуудын зээлийг бол Боловсролын зээлийн сангаас зээлийн мэдээллийн санд нийлүүлдэг. Яг энэ хүрээнд бол 2018-аас 2023 оны хооронд бол 24573 ширхэг

оюутны зээлийн мэдээллийг бол дотоодын зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд бол нийлүүлсэн байгаад байгаа. Гадаад улсад Боловсролын зээлийн сангаар сурсан зээлийг бол Боловсролын зээлийн сан бол нийлүүлээгүй байгаа. Ер нь бол гадаад, дотоод гэж ялгалгүй төрийн болон тусгай сангуудаас зээл авч байгаа аливаа зээлдэгчдийн бүгдээрэнгийнх нь материалыг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх нь бол илүү ёс зүйтэй, шударга байх нь бол зайлиггүй.

Гишүүн мөн зээлийн мэдээллийн сан илүү цаашидаа иргэдэд ээлтэй, нөгөө талдаа хариуцлагатай зээлдэгчийг төлөвшүүлэх чиглэлдээ зээлийн одоо credit score буюу зээлдэгчдийн оноог бодох чиглэлд бол хөгжих ёстой гэдгийг онцоллоо. Энэ дээр бол Төв банк бол зайлиггүй шаардлагатай зүйлсийн нэг гэж бол харж байгаа. Яг энэ чиглэлээр бол Төв банк зээлдэгчдийн оноог бодох зээлдэгчид цаашидаа өөрийн санхүүгийн салбарт авсан энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлснээс үл, биелүүлснээс хамааран зээлдэгчдийн оноо нь бодогддог, үүгээрээ зээлийн эрсдэл нь тодорхойлогддог, хүү нь тодорхойлогддог энэхүү системийг төлөвшүүлэхэд бол Төв банк цаашид цаашидаа анхаараад явна.

Ер нь бол зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 2 компани байгаа. Энэ 2 компанийн бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд бол дараа дараагийн credit score-ийн буюу одоо зээлдэгчдийн оноог бодох чиглэлээр бол үйл ажиллагаагаа тэлээд явна гэсэн тийм бол бизнес төлөвлөгөө байгаа. Батиугар гишүүн бол нэлээн олон удаа энэ зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр бол идэвх санаачилгатай ажилласан. Гишүүний энэ тавьж байгаа бодлогын саналуудыг бол Төв банкны зүгээс бол дэмжиж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Их Хурлын гишүүд байраа эзэлье. Одоо санал хураалт явагдана. Тогтоолын төслийг батлах санал хураалт явагдана. Гишүүд байраа эзэлье. Үдээс хойш Ерөнхий сайдын мэдээллийн цаг байгаа учраас одоо холбогдох асуудлуудыг хэлэлцэж дуусгана. Энэний дараа Баялгийн сан, Мэргэжлийн холбоодын тухай хуулийн төслүүд Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж бэлэн болсон байна. Хэлэлцээд дууссан байна. Одоо хэлэлцэнэ. Тодруулах уу? Батшугар гишүүн, та ер нь тодруулаад асууж байгаарай. Батшугар гишүүн тодруулж асууя.

**Э.Батшугар:** Энэ давагдашгүй хүчин зүйлээс болоод одоо зээл нь тодорхой хэмжээгээр доголдсон нөхцөл байдал үүсдэг. Энэ бол яалт ч үгүй ковид байна. Дээрээс нь нэмээд үер ус гэх мэтчилэн гал гэж зүйл бол гардаг. Үүн дээр бас тодорхой хэмжээний уян хатан байдлаар ханддаг тийм тогтолцоо руу шилжсэн нь зөв гэж харж байгаа юм. Яагаад тухайн иргэнээс, аж ахуйн нэгж ямар ч хамааралгүйгээр орлого нь доголдоод, үүнтэй холбоотойгоор зээлээ төлж чадахгүй тодорхой хугацаанд болбол цаг хугацаанд төлж чадахгүй доголддог. Тэгээд эцсийн үр дүндээ болбол энэ болбол тэгээд л шударга, санхүүгийн шударга ёсны л асуудал яригдаад байгаа л даа. Тэгээд бас энэ Засгийн газрын тусгай сангаас авсан зээлүүд яагаад ер нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэгддэггүй юм бэ? Хөдөө аж ахуйг дэмжих сан байна. Түрүүн ярьсан хэлж байна бас, гадаадад нөгөө нэг зээлийн боловсролын сангаас гадаадад сурахаар хэдэн мянган доллароор зээл авчихсан нөхдүүдийг бүртгэхгүй байгаад байна юу ч төлөөгүй байхад нь.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Батшугар гишүүний тодруулгад хариулъя. Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван хариулъя. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Санал хураалт явуулна шүү.

**Г.Энхтайван:** Батшугар гишүүн энэ Засгийн газрын тусгай сангийн зарцуулалттай холбоотой зарим зээлдэгч нарын мэдээллийг зээлийн мэдээллийн санд бүртгэхгүй байгаа тухай бол хөндлөө. Боловсролын зээлийн сан бол дотоодын зээлдэгчтэй зээлийн мэдээллийн санд нийлүүлээд гадаад улсад, их, дээд сургуульд сурсан зээлдэгчдийн мэдээллийг бол одоогоор бол зээлийн мэдээллийн санд нэгд ирүүлээгүй байна. Хөдөө аж ахуйг дэмжих сантай холбоотой бол зээлдэгчдийн одоо мэдээллийг бол зээлийн мэдээллийн санд гэрээ байгуулсны үндсэн дээр бол нийлүүлж эхэлсэн байгаад байгаа. Гэхдээ бол бүрэн гүйцэт нийлүүлэгдээгүй байгаад байгаа.

Ер нь бол цааш цаашидаа зээлийн мэдээллийн санд төрийн тусгай сангаас авсан бүхий л зээлдэгчдийн мэдээллийг бол тусгах нь бол зүйтэй. Ингэснээрээ бол илүү хариуцлагатай гэрээний үүргээ биелүүлсэн тийм зээлдэгчдийг бол төлөвшүүлэх, хариуцлага үүрэхэд бол.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гүйцээгээд хариулчихъя. Гүйцээгээд хариулчих. Тэгээд дараа нь Батшугар гишүүн.

**Г.Энхтайван:** Тусгай сангаас зээл авсан аливаа зээлдэгчдийн бүгдээрэнгийнх нь мэдээллийг бол зээлийн мэдээллийн санд тусгах нь бол зүйтэй. Энэ дээр бол төв банк бол бодлогын хувьд бол бүхий л зээлдэгчдийг бол зээлийн мэдээллийн санд бүртгэх нь бол зүйтэй гэсэн бодлогын байр суурьтай байгаа.

**Л.Мөнхбаатар:** Батшугар гишүүн их чухал асуудал хөндөж тавиад байгаа юм. Нэмээд нэг минут тодруулж асууя.

**Э.Батшугар:** Мөн Монголбанктай холбоотой нэг ахиад нэг асуудал байгаа юм. Энэ ковидын нөхцөл байдалтай холбоотой ер нь гадаад валютын хомсдолд Монгол Улс ороод, Монголбанкны нөгөө гадаад валютын

нөөц нь буурахтай холбоотойгоор валютын орлоготой компаниудаа шууд Монголбанк өөрөө аваад, ченж хийгээд эхэлсэн. Тэгэхдээ энэ тогтолцоо өнөөдрийн төлбөр тооцоо, төлбөрийн тэнцэл эерэг болсон. Мөн худалдааны тэнцэл эхний 3 сардаа 1,3 тэрбумын ашигтай гарсан үед болбол илүү зах зээлийн рүүгээ шилжмээр байна л даа. Тэгэхгүй бол 7 хоног болгон ойролцоогоор 100 сая доллар зах зээл рүүгээ нийлүүлдэг. Тэгсэн мөртөө ханиш одоо бол хангалттай буурч чадахгүй байна. Харин эсрэгээр илүү гадаад валютын орлоготой компаниуд бол шууд банкнууд руугаа гадаад валютаа нийлүүлээд, тэгээд илүү зах зээлийн зарчимтайгаа хоорондоо банкнууд, диллерүүд нь арилжаагаа хийгээд, илүүдсэн доллароо Монголбанканд зараад, оронд нь төгрөг аваад, энэ нь бол ханишийг бол бүүр эрчимтэй бууруулах нөхцөл байдал.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Энхбаярын Батшугар гишүүний асуулт тодруулгад нэмж хариулъя. Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван хариулъя.

**Г.Энхтайван:** Батшугар гишүүний асуултад тодруулъя. Гадаад валютын албан нөөцийн хэмжээ бол сүүлийн 26 сарын хугацаанд бол дээд хязгаартаа хүрч, 5,2 тэрбум долларт бол 1 дүгээр улирлын төгсгөлөөр бол хүрсэн байгаад байгаа. Гадаад валютын албан нөөц нэмэгдэхэд үндсэн суурь урьдач нөхцөл нь бол төлбөрийн тэнцэл ашигтай гарсантай холбоотой байгаад байгаа. Гадаад валютаар орлого олж байгаа экспортлогч уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд бол доллароо бол Төв банканд бол зарж, эргээд бол энүүгээр бол төгрөг авдаг. Ер нь бол цааш цаашидаа гадаад валютын валютаар орлого олж байгаа аж ахуйн нэгжүүд бол долларын орлогоо бол арилжааны банкандаа зараад, тэрүүгээрээ арилжааны банк нь өөрөө зах зээл дээрх энэ ханишийн тэнцвэрийг хангах чиглэлд бол явах нь бол зүйтэй.

Мэдээж төв банкны зүгээс бол зах зээл дээр богино хугацааны энэ савлалт үүсгэхгүй, богино хугацааны шок үүсгэхгүй байх үүднээс бол гадаад валютын албан нөөцөөс бол нөөцийг бүрдүүлэхэд бол тодорхой хэмжээний валютыг бол энэ экспортын орлоготой аж ахуйн нэгжүүдээс бол аваад богино хугацааны тохируулгаа хийгээд явдаг энэ олон улсын жишигээрээ бол явж байгаа.

Гишүүний тавьж байгаа асуудлыг бол ер нь бол ойлгож байгаа. Энэ бол бас олон жил бол яригдаж байгаа бодлогын бол асуудал. Ер нь бол цааш цаашидаа илүү зах зээлийнхээ суурь зарчимд нийцсэн арилжааны банкнууд нь өөрсдөө экспортын орлоготой аж ахуйн нэгжүүдээсээ валютаа худалдаж аваад, эргүүлээд гадаад валютаар гадагшаа төлбөрөө хийж байгаа аж ахуйн нэгжүүдээ валютаа зараад явдаг энэхүү системдээ бол ороод явна. Энэ бол ер нь илүү зах зээлийн зарчимдаа нийцсэн асуудал.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд танхимдаа орж ирээрэй, санал хураалт явагдах гээд байна. Тогтохсүрэн гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд байраа эзэлье. Оюунчимэг дарга гишүүд рүүгээ холбогдоорой. Оюунчимэг, танд хандаад хэлээд байгаа. Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн асуултаа асууя.

**Д.Тогтохсүрэн:** Асуулт асууя даа бас. Баярлалаа. Энэ Монголбанкныхнаас нэг орж ирсэн дээр 2 асуулт асууя. Яах вэ эрдэнэсийн сангийн орлого, зарлагатай холбоотой орж ирж байгаа санал, гарах гэж байгаа тогтоолын төслийг бол дэмжиж байгаа юм. 2 асуулт нь юу байна вэ гэхээр одоо энэ Пүрэвдорж гишүүн өдөр бүр л ярих юм энэ микрофон дээр. Малчдын зээлийг тэглэ гээд л ингээд л шаардаад байгаа юм. Тэгээд малчид эрсдэлд орсон нь үнэн, үнэн. Ялангуяа зүүн 3 аймаг болбол зуд биш гамшиг болчихсон. Энэ Төв аймаг, Архангай гээд аймгууд нэг хэсэг нь

гамшиг, нэг хэсэг нь зуд байгаа. Тэгээд цаашаага Увс, Говь-Алтай, эд нар гээд олон аймаг эрсдэлд орсон л доо. Тэгэхээр би болбол ойлгохдоо эрсдэлийг болбол банк үүрэх ёстой арилжааны банк өөрөө. Тэгээд энэ арилжааны банк яагаад эрсдэл үүрэхгүй байгаа юм бэ? Арилжааны банк огт эрсдэл үүрдэггүй, тэгээд байнга төр эрсдэлийг нь үүрдэг. Хүү, ашиг олохоор зэрэг арилжааны банк авдаг.

Тэгээд нийгмийн хариуцлага ч байдаггүй, өөрсдийн хариуцлага ч гэж байдаггүй нэг ийм байдал руу болж ирчхээд байна шүү дээ. Уул нь болбол энэ чинь эрсдэл үүслээ, малчин хүн яасан малынхаа тоо толгой, орлогоороо, мал аж ахуйн орлогоороо зээлийн хүүгээ төлөөд амьдарч байсан байгаа, явж байсан байхгүй юу. Гэтэл тэр нь байхгүй болчихлоо. Эрсдэл хаана үүсэх вэ банканд дээр үүснэ. Гэтэл банк энэ эрсдэлээ бүгдийг нь төрд үүрүүлдэг болчихсон сүүлийн үед. Тэрийг нь улс төрчид ингээж зуучилж, нөгөө зохион байгуулалтад оролцдог болчихсон. Тэгээд л юм л болохтой нь зэрэг л зээл тэглэ, зээлийн хүү хөнгөл гээд ингээд л арилжааны банкнаас орж ирдэг. Тэгэхээр энэ арилжааны банкнууд Монголбанкнаас асуухад арилжааны банк өөрсдөө эрсдэлээ ямар түвшинд үүрч байгаа юм бэ нэг дэх асуух гээд байгаа зүйл энэ байгаа юм.

2 дахь юм бол Монголд нэг бий болоод байгаа юм. Энэ зээл олгохоо больчихсон арилжааны банкнууд Энхтайван захирлаа, ерөнхийлөгчөө, арилжааны банкнууд зээл олгохоо больчихсон. Яагаад олгохгүй байна вэ гэхээр үйлчилгээний төлбөр нь аягүй өндөр, тэрүүгээрээ бүх ашгаа олчихдог, зээл олгох сонирхол байхгүй. Зээл олгоё гэвэл хааяа нэг бонд шиг юм худалдаж авчхаад ингээд сууж байдаг. Арилжааны банкнууд Монголбанкны бонд авчхаад ингээд сууж байдаг ийм л байдалтай болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд зээл байхгүй болохоор наад бизнес чинь яах

юм бэ, ерөөсөө хөдлөхгүй болчихоод байгаа байхгүй юу.

Гэтэл энэ чиглэлээр Монгол банк дорвитой ерөөсөө ажил хийхгүй байгаа байхгүй юу. Арилжааны банкнууд нь ерөөсөө морфолл. Энэ морфоллыг задална гэж яриад байгаа. Хамгийн түрүүнд задлах ёстой юм нь арилжааны банкнууд чинь болчихсон байхгүй юу. Тийм учраас би 2-т асуух гээд байгаа юм яагаад энэ арилжааны банкнууд хүүгээ бууруулж, зээлээ өгөхгүй байгаа юм бэ? Зээлийг огт өгөхөө больсон. Яагаад гэхээр ашиг нь зээл биш, ашиг нь үйлчилгээний зардал болчихсон байхгүй юу. Ийм 2 зүйлийг би Монголбанкнаас асууя гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Энхтайван дэд ерөнхийлөгч хариулъя.

**Г.Энхтайван:** Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. 2 дахь асуултаас нь эхлээд хариулчихъя. Гишүүн арилжааны банкнууд зээлийн олголт бол харьцангуй тааруу байна 1 дүгээрт нь.

2 дугаарт нь энэ зээлийн хүү буурахгүй байна гэдэг асуудлыг хөндлөө. Зээлийн хүүтэй холбоотой асуудал бол одоо ер нь бол бодит амьдрал дээр зээлийн хүү гэдэг чинь нэг талаасаа манай Монгол Улсын төгрөгийн үнэ цэн л гэсэн үг л дээ. Тэгэхээр өнгөрсөн жилүүдэд энэ дэлхий нийтийг хамарсан цар тахал, тэгээд өөр бас геополитикийн хүндрэлтэй асуудлууд, дайнаас шалтгаалаад бол дэлхийн бүхий л орнууд бол өндөр инфляцтай нүүр тулсан. Инфляцыг нам доор түвшинд буюу Төв банкны зорилтот түвшинд авчирч байж иргэдийн болон аж ахуйн нэгжүүдийн бодит орлогыг хамгаалах зайлшгүй шаардлагатай болсон. Тэгээд тэр учраас, тийм учраас бол Төв банкны зүгээс өнгөрсөн 3 жилийн хугацаанд бол мөнгөний бодлогыг бол төлөвийг хатууруулсан. Энэ хүрээнд бол бодлогын хүүг бас тодорхой хэмжээнд 6-аас 13% хүртэл өсгөсөн. Үүнтэй холбоотойгоор

бол мэдээж эх үүсвэрийн зардал нэмэгдсэн байгаад байгаа. Тэгээд эх үүсвэрийн зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор бол банкны зээлийн хүү дээр бол тодорхой хэмжээний бол дарамт ирсэн.

Өнгөрсөн 10 дугаар сард батлагдсан 2024 онд төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээр бол энэ хөрөнгө оруулалтын буюу бизнесийн зээлийг дэмжиж, илүү хэрэглээний зээлийг танах тухай тогтоол дээр бол орсон байгаад байгаа. Энэ хүрээнд бол Төв банкны зүгээс бол илүү бодлогын тохируулгыг хийж, арилжааны банкнуудыг илүү хөрөнгө оруулалтын болон бизнесийн зээл гаргах чиглэлд нь бол бодлогын тохируулгалтууд, тохируулгуудыг бол хийж явсан байгаад байгаа. Энэтэй холбоотойгоор бол заавал байлгах нөөцтэй холбоотой болон мөн актив ангиллын журам болон бусад журмуудтай холбоотой бол уян хатан зохицуулалтуудыг бол хийж өгч байгаа.

Малчны зээлтэй холбоотой асуудал дээр бол малчны зээлийг тэглэх тухай асуудал бол ерөөсөө байхгүй. Төв банкны 2024 оны 1 дүгээр улиралд хуралдсан Мөнгөний бодлогын хорооны хурлаар бол энэ байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлаас хамаараад зээлийн төлөлт нь саатсан малчдын зээлийг ангилахгүй буюу актив ангиллын журамд бол өөрчлөлт оруулсан байгаад байгаа. Тэгэхээр бол малчин өөрөө арилжааны банканд дээрээ хүсэлт гаргаад, зээлийн эргэн төлөлтөө бол хойшлуулах боломжтой байгаад байгаа. Үүний үр дүнд бол тухайн малчны болон иргэний авсан зээлийн ангиллыг бол арилжааны банк бол хэвийн түвшинд хадгалах буюу зээлийн ангиллыг бууруулахгүй байх тэр амлалтыг бол өгч байгаа.

Ер нь бол цаашидаа энэ арилжааны банк энэ малчдын энэ зээл дээр бол илүү уян хатан хандаж, зээлийн эрсдэлийг бол хувааж хуваах чиглэлд нь буюу даатгалын системийг илүү хөгжүүлэх,

малчдын амьжиргааны гол орлого бол болсон энэ мал аж ахуйг илүү даатгалын системтэйгээ уясан, малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааг хөдөө орон нутагт илүү хүртээмжтэй, илүү олон малчныг хамарсан чиглэлд нь бол зохион байгуулах бол зайлшгүй шаардлагатай байгаад байгаа. Зээлтэй малчны зээлтэй холбоотойгоор бол энэ малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчны зээл бол хүүгийн хувьд бол тодорхой хэмжээний хөнгөлөлт авч байгаа. Энийг бол илүү олон малчинд хүргэх чиглэлд нь бол энэ Санхүүгийн зохицуулах хороо, Төв банк бол энэ дээр бол хамтраад бодлогын арга хэмжээнүүдийг бол аваад ажиллаад явж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдъя, явуулъя. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 56,4 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

12.48 цаг

**Дөрөв.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны**

**өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн  
хэлэлцүүлэг, нэн яаралтай/**

Дараагийнхаа асуудалд орно. Дараагийнхаа асуудалд оръё. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөрт танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо 2024 оны 4 сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн болно.

Нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заалтыг үндэслэн хуралдаан даргалагчаас зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах

чиглэл өгсний дагуу Ажлын хэсгээс Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 4 саналын томъёолол, дээрх хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг, төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 3 саналын томъёолол бэлтгэснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл, Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Хууль батлагдсанд холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёолуудыг хэлэлцэн шийдвэрлэж,

хууль, тогтоолын төслүүдийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр даргад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Лхамсүрэнгийн Баярмандал, Ашигт малтмал, газрын тосны Кадастрын хэлтсийн дарга Доржийн Батмагнай, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Даишээгийн Амарбаясгалан нар оролцож байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя. Дараа нь санал, санал хураалттай байгаа гишүүд орж ирээрэй.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Энэ өчигдөр яригдсан нөгөө улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болох бөгөөд гээд тэгээд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь хэмжээг стратегийн ач холбогдолгүй ашигт малтмалын ордыг ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр оруулж болно гэсэн нэг ийм заалт өчигдөр яригдсан. Нөгөөдөх нь 34 хувьтай холбоотой. Энэ хоёрыг ажлын хэсэг, сая Байнгын хороо ямар маягаар өөрчилсөн бол энэ дээр нэг хариулт өгөх

үү? Би тэгээд үргэлжлүүлээд юугаа авмаар байгаа юм, хугацаагаа би авч нэмэлт асуулт асуух гээд байгаа юм.

Одоо болбол бодит байдал дээр ийм л байгаа шүү дээ. Энэ Оюу толгой гэдэг ордод тэр гаднын хөрөнгө оруулагч гэж нэрлэж байгаа, зээл зуучилдаг, мөнгө хүүлдэг энэ компанид бол маш тааламжтай ийм нөхцөл бий болгочихсон. Өөрийнхөө дотоодын үйлдвэр Эрдэнэтээс бол нөөц ашигласны төлбөр 17, 8 хувь авч байхад Оюу толгойгоос болбол 5-хан хувийн татвар авч байгаа. Ингээд орлогын албан татвар ч гэдэг юм уу ингээд авах ёстой юмаа өөрийн мэдлийн Эрдэнэтээс бол бүх юмаа авч байдаг, Оюу толгойгоос болбол юу ч авч чадахгүй иймэрхүү л одоо байдалтай байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр бол тэр юуны ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулна гэдэг юм болбол би байж болохгүй.

Нөгөө талынх нь бол ер нь хувь эзэмшиж болно гэдэг нэг ийм хоёрдмол утгатай заалтгүй, байгалийн баялгаа эзэмшигчийн хувьд шууд 34, 50-иас доошгүй хувийг нь эзэмшинэ гэсэн ийм заалтуудыг оруулах тухай өчигдөр бол маш тодорхой яригдсан. Тэгэхээр энэ дээр ямар зүйлийг та бүхэн маань иийдээд оруулаад ирэв? Энэ дээр асуухгүй болбол бид нар дахиад л байгалийн баялгаа ингээд л гарын салаагаар урсгаад байна гэсэн үг.

Яах вэ ер нь болбол ойлгомжтой л доо, стратегийн 16, цаад 39-ийг хэлэхээ больё. Стратегийн ач холбогдолтой 16 ордтой холбоотой болохоос биш, орд тус бүрээрээ энэ тооцоолол үндэслэлийг нь болбол нягтлах ёстой. Тэгэхээр зэрэг энийг болбол Засгийн газар луу үүрэг чиглэл өгсөн нөгөө Оюу толгойтой холбоотой бид нар 57 дугаар тогтоол гэж зарчмын ач холбогдолтой ийм тогтоолыг бид нар арайхийж байж нэг юм 2008, 9 онд бид нар батлуулж байсан шүү дээ. Тэгэхээр энэ асуудлуудыг одоо



яаж хэрхэн зохицуулж оруулсан бэ гэдэг ийм зүйл асуух гээд байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн ахлагч хариулах уу? Баагаагийн Баттөмөр дарга хариулъя. Дараа нь нэмж болно. Хэн, Баттөмөр хариулах юм уу, Цэрэнпунцаг хариулах юм уу, хэн нь юм бэ?

**Б.Баттөмөр:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ Баялгийн сангийн хууль дээр бид нар ажиллаад эцсийн хэлэлцүүлэгт оруулж ирж байна. Монгол Улс болбол байгалийн асар их баялагтай, өгөгдөлтэй. Менделеевийн үелэх систем Монголд тэр чигээрээ байна. Харамсалтай нь болбол өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улс энэ баялгийнхаа менежментийг хийж чадаагүй. Энэнээс болоод тэр 30 гэр бүл, 50 гэр бүл гэдэг асуудлууд гарсан. Тэр бол үнэн. Баян, хоосны ялгаа болбол тэнгэрт тулсан нь үнэн. Нийт ард түмний 27 хувь нь ядуурсан үнэн. Дээр нь 15 хувь нь ядуурах магадлалтай нь үнэн байгаа. Тэгээд энэ дээр дүгнэлт хийгээд энэ Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн санаачилгаар энэ Үндэсний баялгийн сангийн хуулийг өргөн баригдаад хэлэлцээд явж байна. Тэгээд энэ дээр одоо бас янз бүрийн саад болж байгаа ийм зөрчилтэй, дутагдалтай юмнууд маш их гарлаа.

Бат-Эрдэнэ гишүүний сая асуусан тэр улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн стратегийн ордуудад 50 хүртэл хувийг эзэмшинэ. Тэгээд дээрээс нь тэр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орлуулж болно. Энэ Ашигт малтмалын хуульдаа байдаг юм байна лээ. 2 дахь нь болбол тэр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хайгуул хийгээгүй, стратегийн ордод бол 34 хүртэлх хувийг эзэмшинэ, энийг мөн нөөц ашигласны төлбөрөөр төлнө гэж, тэр болно гэдэг үгийг аваад хаячихсан байгаа 1 дүгээрт энэ, ингэж хариу хэлье.

2 дугаарт энэ дээр одоо нэг зарчмын хувьд шийдсэн асуудал бол юу гэхээр энэ стратегийн ордуудыг дагасан энэ үүсмэл ордууд гэдэг нэртэй ордууд байгаа. Энийг энэ тэр стратегийн ордод нь хамруулж байгаа. Энэ овоолго болбол хаана байна вэ гэхээр овоолго гэж манайхан ярьдаг. Энэ бол Эрдэнэт дээр байна, Оюу толгой дээр байна, Дарханы төмөрлөгийн үйлдвэрүүд дээр байна. Тийм учраас энийг стратегийн ордод хамруулаад, тэгээд энэнээс болбол ард түмэн үр өгөөжөө авна гэж ингэж одоо тооцож явж байгаа.

3 сан болбол байгаа, Бат-Эрдэнэ гишүүн өөрөө мэдэж байгаа. 3 сан болбол Ирээдүйн өв сан болбол хуримтлуулна. Хөгжлийн сан нь болбол ирээдүйд улс эх оронд ашиг тустай, тэр өсөлт бий болгодог салбарыг санхүүжүүлнэ. Хуримтлалын сан нь болбол тэр тулгамдсан эрүүл мэнд, боловсрол, тэгээд тэр хүн, эрүүл мэнд, боловсрол, орон сууц гэсэн энэ төслүүдийг хэрэгжүүлэхийн хажуугаар бас иргэдийнхээ амьдралыг өөд татах энэ хуулийн заалтууд нь ингээд явж байгаа.

Энэ Оюу толгойтой холбоотой асуудлыг хөндөж ярилаа. Сая ярилаа. Оюу толгой бол 5 хувийн Амнат төлдөг. Тэгээд дээрээс нь нийгмийн даатгалын шимтгэл жижиг сажиг зүйл төлдөг. Өнөөдөр Монгол Улсын нийт төсөв 27 их наяд төгрөг. Оюу толгойн Монгол Улсын эдийн засагт оруулж байгаа тэр хэмжээ нь болбол 684 тэрбум төгрөг 24 оны тоо ярьж байна. Монгол Улсын төсвийн 2,7 хувийг бүрдүүлж байгаа нь үнэн. Энэ дэлхийд их том ийм орд. Дэлхийн 4 дэх, 5 дахь орд гэдэг шүү дээ. Тэгээд ийм байгаа. Дээрээс нь болбол Оюу толгойтой холбоотой энэ татварын маргаан байгаа. 1,3 их наяд төгрөгийн маргаан, 25 оны 9 сард Лондоны шүүх дээр хурал нь болох юм гэсэн. Тэр болтол одоо ингээд байх юм байна лээ.

Ер нь Оюу толгойтой төсөлд Монгол Улсын эрх ашгийг хангуулах 92

дугаар тогтоол гэж гарсан. Энэ тогтоолын хэрэгжилт бол хангалтгүй байгаа шүү. 2,3 тэрбум долларыг тэглэсэн, одоо зардлаа дахиад 1,6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ гээд ингээд явчихсан байж байгаа. Ордуудынхаа тэр байгаа тэр баялгийн хэмжээг бууруулчихсан явж байгаа. Алтны хэмжээ, зэсийн хэмжээ. Ийм учраас болбол энэ Оюу толгой төсөлтэй Монгол Улс ширээний хойно сууж аль, аль талдаа ашигтай ийм хувилбарыг олох ёстой гэж.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. Үүний дараа санал хураалт явагдана. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа шүү. Гишүүд суудлаа эзлээрэй. Б.Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр би ийм зүйл л асуугаад байгаа юм л даа. Тэр байгалийн баялгаа эзэмшигч, эзэн орны хувьд энэ 34, 50-иас доошгүй хувийг үнэ төлбөргүйгээр эзэмших ийм заалт оров уу? Өчигдөр бол нэлээн яригдсан шүү дээ. Энэ одоо яг хөдөлгөөн байхгүй ингэж орлоо гэдэг ийм зүйлийг хэлж чадах уу? Тэгэхгүйгээр ингээд л нөгөө 34 хувьдаа, 50 хувьдаа эзэмшиж байгаагийн хувь хэмжээндээ, төрийн эзэмшлийн хувь хэмжээндээ стратегийн ач холбогдолгүй ашигт малтмалын ордын ашигт малтмал, нөөц ашигласны төлбөрөөсөө л тэрийгээ орлуулна гэхээр чинь зэрэг энэ Монгол Улсад ирэх юм нь байхгүй болоод энийг би мэргэжлийн хүн мэддэгдээ энийг олон жил яриад байгаа зүйл биш шүү дээ. Дандаа энэ мэргэжлийн, Эрдэнэтийн ТЭЗҮ хийхэд ажиллаж байсан мэргэжлийн хүмүүсээс эхлээд энэ чиглэлээр судалгаа хийсэн, шинжлэх ухааны доктор ийм хүмүүсийн энэ санал, байр суурийг л би энд хэлээд байгаа зүйл шүү.

**Л.Мөнхбаатар:** Эдийн засгийн байнгын хороон дарга Цэрэнпунцаг нэмж хариулъя. Дараачийнхад нь санал хураалт.

**Ц.Цэрэнпунцаг:** Бат-Эрдэнэ гишүүний асуусан асуултад гүйцээж хариулъя. Яг таны саяын одоо тодруулж асууж байгаагаар энэ төр, төрөөс оруулсан оруулалт, танд уншиж өгье. Улсын төсвийн хөрөнгийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, үүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд гээд оруулсан.

Энэ өчигдрийн хэлэлцүүлгээр бол эзэмшигч болох уу, болно гэж оруулсан байсныг одоо болно гэдгийг нь аваад одоо өнөөдөр бол шууд эзэмшинэ гэдэг энэ агуулгатай нэг ямар нэгэн хоёрдмол утгагүйгээр энэ санаа орсон. Ер нь бол энэ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ашигт малтмалын хууль дээр байсан төрийг заавал хөрөнгө оруулалт оруулах ёстой гээд ингээд заачихсан байсныг нь өнөөдөр хөрөнгө оруулалт заавал оруулахгүйгээр үнэ төлбөргүйгээр авч болно гэдэг ийм дэвшилттэй санаа оруулж ирж хийсэн хууль. Тэгэхээр бол таны яг асуусан асуулт дээр ямар нэгэн хоёрдмол утгагүйгээр эзэмшинэ гэсэн энэ санаа энэ дээр орсон.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааа. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Одоо ингээд эцсийн хэлэлцүүлэгтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хурааж дуусна. Түүний дараа хуулийг эцэслэн батлах санал хураалт явагдана. Энэ бол нийт гишүүдийн 39-өөс дээш гишүүдийн саналаар явагдах санал хураалтууд байгаа. Тийм учраас гишүүд байраа эзлээд, энэ асуудалд хариуцлагатай оролцох нь зүйтэй. Зарчмын зөрүүтэй саналуудаа хурааа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын

зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. 1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

10.3.Хуримтлалын болон хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкн дахь Төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцож, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт гишүүдээ. Тогтохсүрэн дарга суугаарай. Санал хураалт шүү. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

12.6.Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын болон өөрийн хөрөнгө оруулсан авто зам, төмөр зам, дэд бүтцийн төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага, зохион байгуулалтаар хангана. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн 12.4 гэсний дараа 12.6 гэж нэмэх санал гаргасан. Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

12.9.Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ноогдох ноогдол ашгийг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдэд

төвлөрүүлнэ. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 64,1 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг үргэлжлүүлэн явуулъя. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 1/ заалт нэмэх.

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/5 дугаар зүйлийн 5.4 5.5 дахь хэсэг.

5.4.Улсын төсвийн хөрөнгө, хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал байгаа юм уу, үг

хэлэх юм уу? Үг хэлэх юм уу? Хэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн уг асуудалтай холбогдуулан үг хэлье. Та нар юугаа өг, нэрсээ кнопоо дараад нэрсээ өгөх ёстой. Бөхчулууны Пүрэвдорж, хэн, өөр хэн байгаа вэ, нэрсээ өгчихсөн үү? Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Уг зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан үг хэлье. Бөхчулууны Пүрэвдорж.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр төрийн өмчийн томоохон компаниудтай холбоотой асуудал л даа, энэ Хуримтлалын санд 3 санд орлого бүрдүүлэх асуудал. Тэгэхээр төрийн өмчийн томоохон компаниуд дээр гарч байгаа хулгай зэлгий хэрээс хэтэрсэн. Энэ юунаас болж байна вэ гэхээр хэн нэгэн Их Хурлын гишүүнийг тойрогт нь дэмжиж, санхүү мөнгөөр тусалчхаад гаргачхаад, тэндээ тэр нөхрөө гишүүн болгож авчхаад дараа нь төрийн өмчийн компани дээр захирал болно гэж очдог тэр цүнх баригч нараас болж байгаа юм. Тэгээд тэр цүнх баригч нар тэр компани дээрээ очоод тонон дээрэмддэг, хулгайлдаг зүйл хэрээс хэтэрсэн. Тэгээд энэ олон хулгай бол илэрч гарч ирж байна. Гэвч одоо яг энэ хулгайг яаж байхгүй болгох вэ, яаж цаашидаа энэ төрийн өмчийн компанийг шилэн, ил тод болгох вэ гэдэг асуудал, концепц ерөөсөө Засгийн газраас оруулж ирэхгүй байгаа. Тэгээд энэ нь одоо Баялгийн сангийн хууль дээр оруулж ирэх болов уу гэсэн ч, гэвч харамсалтай нь орж ирэхгүй байна.

Тэгэхээр энэ төрийн өмчийн компаниудыг шилэн, ил тод, ард иргэдийн хяналтад оруулахын тулд ард иргэдийн төлөөллийг төрийн өмчийн тэр стратегийн орд бүхий төрийн өмчийн компани дээр оруулах нь хамгийн зөв зүйл гэж үзэж байгаа. Тийм учраас миний 2023 оны 7 сарын 2-ны өдөр өргөн барьсан Эрдэнэт үйлдвэрийн 20 хувийг Монголын ард түмэнд үнэгүй эзэмшүүлэх, 20 хувийг нийгмийн даатгалын шилтгэл төлдөг ажилтан албан хаагчтай үндэсний компанид тодорхой үнээр борлуулж эзэмшүүлэх

энэ тогтоолын төслийг энэ хуультай хамтатгаж хэлэлцэх ёстой. Энэ тогтоолын төсөлд заасны дагуу тухайн компанийн, Компанийн тухай хуулиар ер нь 36 хувиас дээшээ болчих юм болбол тухайн төрийн өмчийн компанид ард иргэд өөрсдийнхөө төлөөллийг оруулах ийм боломж нь нээгдэх юм.

Энэ тогтоолын төслийн дагуу манайх 21 аймаг, 9 дүүрэгтэй, эндээс хамгийн шилдэг тэр хүмүүсийг аймаг болгон, дүүрэг болгон нэг хүнийг гаргаж ирэх замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлж, тэндээсээ хамгийн шилдэг менежерийг томилох замаар энэ төрийн өмчийн компанийг хариуцлагатай, ил тод, аливаа асуудал нь нээлттэй, хамгийн гол нь хулгайгүй, цүнх баригч байхгүй, томилогдохгүй болсноос болж хулгайгүй болох ийм боломж нь нээгдэх юм байхгүй юу даа. Тэгээд энэний энэ тогтоолын төсөл үр дүнтэй болчих юм болбол стратегийн орд бүхий төрийн өмчийн компаниуд дээр нөгөө энэ ард иргэдийн төлөөлөл болон хувийн хэвшлийн төлөөллийг оруулах замаар хяналтыг илүү сайжруулсны үр дүнд тухайн компани илүү үр дүнтэй ажиллана гэсэн ийм тооцоолол гарсан байж байгаа.

Тэгэхээр энэ иргэдийн төлөөллийг оруулах нь маш чухал байна. Тэгж байж энд энэ төрийн өмчийн компани дээрээ бид нар маш хариуцлагатай тэр хүмүүсийг ажиллуулж байж энэ төрийн өмчийн компани илүү олон нийтийн болох ийм боломжийг бүрдүүлэх юм. Тэгэхээр энэ Баялгийн сангийн тухай хуулиар дахиад л яам, тамгын газар, нөгөө хуримтлалын сан болон хэд хэдэн 3 сангийн удирдлагыг нь томилох тухай асуудал ороод ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө нэг цүнх баригч нар чинь дахиад очих боломж нь дахиад л нээлттэй хэвээрээ байна гэсэн үг. Ард иргэдийн хяналтад энэ төрийн өмчийн компаниуд очихгүй болно гэсэн үг. Хувьцаа хангалттай тараагдахгүй гэсэн үг. Тэгэхээр энэ иргэдийн сонирхол буурах, буурна.

Тийм учраас энэ одоо, энэ хуулийг хэлэлцэхдээ Баялгийн сангийн тухай хуулийг хэлэлцэхдээ яг энэ иргэдэд энэ хяналтад очих энэ тогтоолын төслийг миний өргөн барьсан тогтоолын төслийг хамтган хэлэлцэх ёстой гэдэг ийм шаардлагыг тавьж байгаа. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд орж ирсэн байна. Ер нь бол энэ дээр хамгийн гол нь тэр төрийн өмчийн компаниуд дээр, дээрээс нь тэр төрийн өмчийн компаниудын оруулж байгаа тэр орлогын үндсэн дээр бүрддэг тэр сангийн удирдлагууд дээр хамгийн гол нь зөв удирдлагыг томилох, хамгийн шилдэг менежерүүдийг томилох тэр үндсэн концепц ерөөсөө шийдэгдээгүй байна шүү гэдгийг бас анхааруулж хэлье.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Монгол Улсын Ерөнхий сайд Лувсандамсрайн Оюун-Эрдэнэ үг хэлнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Эрхэм гишүүддээ энэ хуулийн төслийг дэмжиж өгнө гэдэгт итгэлтэй байгаа. Сая Пүрэвдорж гишүүн ярьж байгаа зарим нэг зүйлтэй санал нэг байна. Гэхдээ, гэхдээ яг ингэж ярьж байгаад энэ стратегийн ордуудыг авчихсан шүү. 2006 онд Их Хурлаар ороод Стратегийн ордны жагсаалтад байсан төслүүдийг стратегийн орд биш гэж Их Хурлаар ээлж дараалан лоббидож гаргасан. Тэр ингээд Их Хурал дээр байж байгаа. Удахгүй энэ сонсголоор тодорхой болох байх. Ганбаатар сайд тэр талаар маш нарийн мэдээлэлтэй байгаа байх. Энэ дээр Их хурлын гишүүд янз бүрийн лобби хийж байгаа хүмүүсийн ятгалгад би автахгүй байхыг чин сэтгэлээсээ хүсэж байна. 2006 онд орсон стратегийн ордууд чинь одоо дийлэнх нь байхгүй болчихсон байгаа. Эсвэл хуваагаад нөөцийг нь багасгаад гаргаад авчихсан байгаа. Эсвэл Улсын Их Хурлыг лоббидоод, Цэцтэй нь авлигал төлж байгаад гаргаад авчихсан байдалтай байж байгаа.

Тэгэхээр энэ дээр стратегийн ордтой холбоотой энэ зохицуулалт дээр бид хатуу байх ёстой. Энэ уул уурхайн салбар хөгжссөн аль ч улс тийм байгаа. Норвег тийм л байгаа, Чили тийм л байгаа. Бид ялгаатай юм хийх гээд байгаа зүйл огт биш шүү. Огт биш шүү. Энийг би бас 1 дүгээрт хэлье гэж бодож байна.

2 дугаарт, 2 дугаарт энэ үүсмэл ордтой холбоотой асуудлыг Цагаанаас эхлээд энэ бол хог хаягдал гээд байгаа юм. Үгүй шүү, үгүй. Энд бол яг стратегийн ордтой адилхан баялаг, Оюу толгой дээр ч энэ нь бий болно, Эрдэнэт дээр ч бий болно. Дээрээс нь Пүрэвдорж гишүүнээ, стратегийн ордуудыг хувь хүнд өгчих л юм бол ил тод болно гээд байгаа үгүй шүү. Ачит ихтийн ард Элбэгдорж байгаа. Цаглавар гээд дансанд Ачит ихт 13 сая доллар шилжүүлсэн. Энэ асуудал дээрээ одоо хөдөлгөөн орж байгаа асуудлууд байгаа. Удахгүй энэ баримтаар ил болно гэдэгт би итгэлтэй байгаа. Энэ ил тод байдал юм уу? Эсвэл энийг хог гээд гаргаж аваад, үүсмэл орд болгоод ингээд нэг хүн явж байгаа энэ ил тод байдал юм уу тэгээд? Эсвэл Эрдэнэтийн 49 хувь саалийн үнээ шиг хөгшрөөд үхэх гэж байна гэж байгаад авчхаад, 600 тэрбум өнөөдөр 2 их наяд төгрөг болоод байгаа нь тэгээд ил тод байдал юм уу? Тэгээд Элбэгдорж одоо юу гэж хариулж байна вэ гэхээр миний үгийг алдаа байлаа гээд. Ийм том стратегийн орд дээр төрийн тэргүүн хүн үгийн алдаа гаргаж болдог юм уу. Тэгэхээр ийм асуудлаар дамжуулж энэ стратегийн ордыг хууль дамжуулж хулгайлдаг асуудал энд хүрээд цэглэгдэх ёстой.

Энэ Үндэсний баялгийн сантай холбоотой энэ асуудал олон жил яригдсан. Одоо бид нар эцэслэн шийдвэрлэгдэх ёстой шүү. Тэгээд стратегийн орд эзэмшээд луйвардаж авсан хэдэн компаниуд энэ тэндээс энэ хуультай холбоотой янз бүрийн ойлголтууд төрүүлэхээ одоо болих хэрэгтэй. Цагаанаа одоо болих хэрэгтэй.

МАК компани одоо хангалттай болих хэрэгтэй. Зүгээр 34 хувь хуримтлалын сан руу шилжих энэ эрхийг нь өгчих. Хэрвээ энэ дээр ямар нэгэн асуудал гарах юм бол стратегийн ордуудыг буцааж авах асуудал, стратегийн ордыг гарахад хэн, хэн яаж оролцсон бэ гэдэг асуудлыг авлига дээр ярих ийм асуудал бас байж болохоор байгаа шүү. Байж болохоор байгаа шүү. Тэгэхээр одоо хангалттай, зүгээр аятайхан байцаагч. Яасан их мөнгөтэй юм. Тэгээд одоо ингээд ярьж байгаа зүйлүүд нь яг, хаашаа юм Цагаанд очихоороо тийм ил тод байдалтай болчих гээд байгаа юм уу? Тийм юм байхгүй шүү. Тэгээд л энд хүмүүсийн юу эргүүлээд л баахан асуудлууд яриад л, тэгээд л ард талд нь ийм луйвар явдаг юмыг л таслан зогсоох гэж байгаа юм.

Би энэ дээр огт нам ярихгүй байгаа. Би хэзээ ч нам ярьж байгаагүй. Зүгээр би авлигал байгаа бол авлигынхаа асуудлыг шийдье л гэж байгаа юм. Тийм учраас энэ дээр парламентын гишүүд маань санал нэг байгаарай. Үндэсний баялгийн сангийн хууль гээд бид нар сүүлийн бараг 30-аад жил л ярилаа. Одоо үндсэн шийдэл дээрээ очих гэж байна. Энэ үүсмэл орд бол баялаг шүү. Энэ бол хог биш. Ингээж ард түмний тархи угаахаа болих ёстой шүү.

**Л.Мөнхбаатар:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би түрүүнийхээ хэлсэн санааг л би хэлэх гээд байна. Энийг болбол би бас хэлж протоколд тэмдэглүүлэх ёстой ийм хүний нэг. Яагаад гэвэл энэ мэдээжийн асуудал стратегийн ач холбогдол бүхий орд газруудад үр өгөөжтэй, үр ашигтай ийм ордууд байгаа. Энийг нь тооцоо судалгааг нь гаргах нь бол тэр ойлгомжтой асуудал. Энэ 5-ын, Ашигт малтмалын хуулийн 5.4, 5.5 гэдэг бол Оюу толгойн ордыг хулгайлж авахын тулд л Ашигт малтмалын хуулийг ажлын хэсгийн нөхдүүд хаана байсан

гадаад далай тэнгисийн цаана хуйвалдааны журмаар гадаадын хүмүүсийнхээ зөвлөгөө заавраар хийсэн ийм л хуулийн төсөл шүү дээ.

Тэгээд энэ 5.5-д одоо орж байгаа 2 сайн зүйл болбол 1 дүгээрт энэ үүсмэл ордтой холбоотой асуудлыг оруулж ирж байгаа нь маш чухал зүйл. Энэ бол өөрөө ялгаа байхгүй байгалийн баялаг орд мөн.

Дараагийнх нь юм болбол энэ хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших гээд шууд заагаад өгчихсөн нь энэ болж байгаа юм.

Нөгөө нэг юм нь болбол энэ төрөөс оруулсан, ар талд нь болохоор энийгээ үгүйсгээд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болдог болно гээд, дахиад л нөгөө төрөөс хөрөнгө оруулах, оруулж байж хувь эзэмшихтэй холбоотой асуудал яригдаад л, тэгээд л нөгөө Оюу толгойн бахь байдаг асуудал гараад ирэх вий. Энийгээ сайн анхаарахгүй болбол болохгүй байгаа юм шүү. Ингээд заавал хөрөнгө оруулж байж хувь эзэмшинэ гээд 34 хувийг эзэмшээд л бид нар 2,3 тэрбум долларын өртэй. Тэгээд энийг чинь энэ Засгийн газар, Их Хурлын үед арай гэж нэг юм тэглүүлж авсан шүү дээ. Тэгээд энэ байдал чинь дараа дараагийн ордуудад бий болохоор байгаа учраас л энийг хэлээд байгаа эд. Энэ чинь ирээдүйд 22 тэрбум долларын өрөнд орохоор ийм нөхцөл байдал үүсчихсэн л гэж ингээж л мэргэжлийн байгууллагууд нь ийм судалгаа гаргасан шүү дээ.

Тэгээд энэ дээр байж байгаа тэр дараагийнх нь юм бол энэ төрийн эзэмшлийн хувь хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулна. Бид бас тухайн үед энэ нөөц ашигласны төлбөрөөр энийг болбол орлуулж болохгүй. Хэрвээ заавал ийм хуулиа бариад ингээд энэ 34 хувьдаа өөрснөө

хөрөнгө гаргаж байж эзэмших ёстой гээд ингээд байгаа бол ирээдүйд авах ноогдол ашгаасаа та нар энийг орлуулаач гэдэг ийм асуудлыг л бид тухайн үедээ тавьж байсан шүү дээ. Тэгээд энийг нь хайхрахгүй явсаар байгаад л түрүүний 2,3 тэрбум доллартой холбоотой ийм асуудал бол гарч ирсэн. Энэ ашигт малтмалын баялгаас, энэ Үндэсний баялгийн хуулийг бол бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Ганцхан энэ хулгайн аргаар, хууль хулгайлах замаар өнөөдрийн ийм байдал руу чирээд байгаа энэ зүйл, заалт дээрээ л анхаарч үзэх ёстой юм шүү гэдэг ийм асуудлыг л тавиад байгаа хэрэг. Өөр юм болбол байхгүй.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүдээ. 75 хувиар санал дэмжигдлээ. 2, гишүүд чимээгүй байгаарай. Санал хураалт явагдаж байна.

2.Төсөлд орж дурдсан агуулгатай 2 дугаар зүйл, 3 заалт нэмэх.

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

3.9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт. 9.1.5.Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 80 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5.7 дахь хэсгийг доор дурдсаар өөрчлөн найруулах.

5.7.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглоно. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 77,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

5.8.Төрийн өмч, төрийн өмчийн оролцоотой орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшлийн хувьцаа Монгол Улсын Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээдийн хувьцаанд энэ зүйлийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 80 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

13.26 цаг

**Тав.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудал. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл. Одоо дараагийнхаа асуудалд орно шүү. Хуулийн төсөл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн,

Байнгын хороон дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 4 сарын 18-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжсэн, дэмжигдсэнтэй холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагаж мөрдөх тухай хуулийн төслийг тус Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар төслийн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй үндэслэл гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр даргад баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна, байгаа юм уу? Одоо санал хураалтыг явуулъя. Байнгын хороо Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжсэе гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд. 75 хувиар санал дэмжигдлээ. 75 хувиар санал дэмжигдсэн байна. Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

13.30 цаг

**Зургаа.Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Дараагийнхаа асуудалд оръё. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэн танилцуулах вэ? Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөрт танилцуулна.



**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг дэмжигдсэнтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус Байнгын хорооноос Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хороонд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр даргад баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хороо Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжсэе гэсэн саналын томъёоллоор санал хураая. Баттөмөр гишүүн суудалдаа сууя. Санал хураалт. 69,2 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

13.33 цаг

**Долоо.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Дараагийнхаа асуудалд оръё. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хороон дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Баттөмөр гишүүн та ер нь энд ойрхон байж байвал яасан юм бэ? Энэ индрийн оролцоо өнөөдөр. Энэ байна, энд байна, энд байна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Учралаас 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 сарын 12, 18-ны өдрүүдийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд ишлэжүүлсэн.

Тус Байнгын хороо 2024 оны 4 сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх асуудлыг хэлэлцээд, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн болно. Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хуралдаан даргалагчаас Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны зохион байгуулалт, гишүүнчлэл, чиг үүрэгтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгээс Мэргэжлийн нэгдсэн холбоо нь дэд зөвлөлтэй байх, мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд болон бусад албан тушаалтан нь ёс зүйн дүрмийг зөрчсөн, тухайн салбарын болон мэргэжлийн эрх ашгийг хөндсөн, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл гаргасан бол Хяналтын

зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ. Тухайн албан тушаалтныг чөлөөлөх хүртэл арга хэмжээ авдаг байхаар өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжлээ.

Нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг нэмж тусган, тусгасан эцсийн хувилбарын төсөл, Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Улсын Их Хурлын дарга  
Г.Занданишатар 13 цаг 37 минутаас  
хуралдааныг даргалав.

**Г.Занданишатар:** Би гадагшаа олон улсын баримтад киноны нээлтэд. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Учрал, Ням-Осорын Учрал. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Мэргэжлийн нэгдсэн холбоо гээд уг нь маш чухал хуулийн төсөл байна л даа. Иргэний нийгэм, мэргэжлийн холбоодыг үйл ажиллагаанд оролцуулах. Тэгээд энэ хуулийн төслийн энэ танилцуулгыг энэ тэгэхдээ анхны хувилбарыг нь бид нэлээн уншиж үзлээ. Жишээ нь энэ дээр би та бүхэнд бас ингээд танилцуулъя л даа. Энэ дээр байгаа 4, 5 заалт. Нэгдүгээрх нь нэг

салбарт зөвхөн нэг мэргэжлийн холбоо байна. Энэ мэргэжлийн холбоог зөвхөн тухайн салбарын яам зөвшөөрнө. Яам зөвшөөрснөөр энэ салбарын холбоог бүртгэнэ, улсын бүртгэлд зөвхөн тухайн салбарын яамны зөвшөөрлөөр бүртгэнэ. Энийгээ 5 жил тутам итгэмжилнэ. Энэ итгэмжилснийгээ хагас жилээр, бүтэн жилээр, 4 жилээр гэрээ байгуулж дүгнэнэ. Энэ салбарт өрсөлдөөн үүсэхгүй байх нөхцөлийг хуулиар авна гэсэн үндсэндээ юун мэргэжлийн нэгдсэн холбоо, иргэний нийгэм, мэргэжлийн холбоод биш зүгээр л төрийн алба, төрийн алба цаашаа ийм бүтцийг л яг ийм үзэл баримтлал бүхий хуулийн төсөл хэлэлцэх эсэх нь яваад одоо ажлын хэсэг нь явж байгаа юм байна л даа. Ажлын хэсэг дээрээ ямар өөрчлөлтүүд ороод яаж явж байгааг одоо үнэндээ сайн мэдэхгүй байна.

Тэгэхдээ энэ хуулийн төслийн энэ анхны үзэл баримтлал, энэ бүх зүйл чинь бид нарын явж байгаа чиглэл, энэ олон зүйлтэй чинь ер нь нийцэж байгаа юм уу? Энэ дээр ажлын хэсгээс бас энэ дээр тайлбар өгөхийг хүсье. Саяын тийм энэ чинь гоё эелдэг соёлтой нэртэй зүгээр л төрийн байгууллага бүүр социализм цаашаа л ийм үзэл санаа энэний цаана чинь яваад байна шүү дээ. Тухайн салбарт нэг мэргэжлийн холбоо байна, энийг яам батална, яамны сайд батална, энийгээ 5 жил тутам итгэмжилнэ, яамны сайд нь итгэмжилнэ, хагас, жилээр бүтэн жилээр гэрээ хийнэ, энийгээ яамны сайд гэрээгээ дүгнэнэ гэдэг яг ийм мэргэжлийн холбоо ер нь байх ёстой юу энэ ер нь. Энэ одоо яг одоо ямар утга санаатай, энэний цаана юун нөгөө үзэл баримтлал олон зүйл чинь, нөгөө зах зээл, эдийн засаг, тэр тусмаа дахиад зарим заалт нь өрсөлдөөн үүсгэхгүй байх хууль орчин, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ тухайн салбарт гэсэн ийм заалтуудыг л уншиж харлаа л даа. Энэ дээр тэгээд ажлын хэсэг талаасаа бас тайлбар өгөхийг хүсье.

**Г.Занданшатар:** Цогтгэрэл гишүүн энэ хэлэлцэх эсэх дээр яригдах

ёстой асуудлыг л жил гаруйн өмнө ярьсан юмыг одоо ярьж байна л даа. Тэрнээс чинь хойш ажлын хэсэг ажиллаад, өөрчлөөд, одоо төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх, зөвшөөрлийг мэргэжлийн холбоод олгодог байх энэ тэр гээд маш олон либералчилсан заалтууд ингээд ороод эхний хэлэлцүүлэг дуусаад, тэгээд одоо эцсийн хэлэлцүүлэг дээр явж байхад ийм асуулт болбол. Тэгээд Мөнх-Оргил, Цэндийн Мөнх-Оргил гишүүн ажлын хэсгийн гишүүн хариулъя. Наад заалтууд чинь бүгд өөрчлөгдсөн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа.

Цогтгэрэл гишүүн анх өргөн барьсан хуулийн төсөл, үзэл баримтлалыг нь гол нь яриад байгаа юм л даа. Тэгээд яг тантай Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь санал нэг байсан учраас өргөн барьсан хуулийг хэлэлцэхгүй ингээд удсан шалтгаан нь энэ л дээ. Тэгээд өргөн барьсан гишүүд, ажлын хэсэг хамтарч ажиллаад таны саяын тавьсан бүх асуултуудад хариулт өгөөд, яам зөвшөөрдөг юм байхгүй болоод, яам сунгадаг юм байхгүй болоод, төрийн захиргааны ямар нэгэн байгууллагаас мэргэжлийн нэгдсэн холбоодын үйл ажиллагаа шалтгаалдаг заалтууд байхгүй болчихсон. Одоо бол мэргэжлийн холбоодуудаас бүрдсэн нэгдсэн холбоо байгуулагдана. Нэгдсэн холбоог Улсын дээд шүүх дээр байгуулна. Нэгдсэн холбоо нь тухайн салбартаа нэг л байна, нэг л байна.

Нэг Нэгдсэн холбоотой төрийн байгууллагууд хамтарч ажиллана. Хамтарч ажиллахдаа төрийн захиргааны байгууллагууд эрх мэдлээ гэрээний үндсэн дээр шилжүүлэх, гэрээний үндсэн дээр шилжүүлэхдээ төсвийн хөрөнгөтэй нь хамт шилжүүлэх, өөрөөр хэлбэл төрийн бус байгууллагуудыг, мэргэжлийн холбоодыг мэргэжлийнхээ, салбарынхаа үйл ажиллагааг зохицуулах ажилд нь илүү татаж оролцуулах нэлээн тийм либералчилсан ийм чиглэлийн заалтууд орсон байгаа. Анхны хэлэлцүүлэг дээр энэ

зарчмын өөрчлөлтүүдийг Улсын Их Хурал, Байнгын хороо дэмжээд батлагдсан. Тэгэхээр таны саяын санаа зовж байгаа асуудлууд бол бүгд нэгд нэгэнгүй зохицуулагдсан байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Та жоохон хоцрогдож яваад байна л даа. Одоо ингээд Цогтгэрэл гишүүн нэг минут тодруулъя.

**О.Цогтгэрэл:** Их Хурлын даргаа энэ хуульд хуулийн төсөл хэлэлцүүлгийн явцад ингээд өөрчлөлт орсон тухай ярьж байна л даа. Та өмнө нь шийдэгдчихсэн гэж байна. Гэтэл хуулийн төслийн хэлэлцэх эсэх гэдэг чинь үзэл баримтлалыг нь баталдаг биз дээ. Тэгэхээр энэ төрийн захиргааны байгууллагын асар их өндөр оролцоотой үзэл баримтлалыг баталчхаад ажлын хэсэг дээрээ бүгдийг нь сольчихож болдог юм уу? Хуулийг ер нь. Ажлын хэсэг дээр. Тэгэхээр тэр нөгөө хууль санаачлагч өргөн барьсан үзэл баримтлал нь хаачих юм бэ? 1 дүгээр үе дээр хэлэлцэх эсэх дээр тэр үзэл баримтлалыг чинь яг юу хуулийн анхны хэлэлцүүлэг дээрээ дэмжсэн юм байгаа биз дээ. Гэтэл энэ хэлэлцүүлгийн явцад ингээд тэс өөр буруу, зөвийг нь орхиё л доо зүгээр. Тэс өөр болгочихоор энэ чинь өөрөө бас хууль, эрх зүйн энэ чинь бас нэг тодорхой хэмжээний гажуудал биш үү? Энэ тухай жишээ нь одоо энэ асуудлыг нь.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Та ерөөсөө Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиа ч ойлгоогүй байгаа юм байна. 1 дүгээрт бид нар үзэл баримтлал баталдаггүй. Үзэл баримтлалыг хууль санаачлагчид батлаад, тэрнийхээ дагуу үзэл баримтлалынхаа Хууль тогтоомжийн хуулийн 13.2, 14.2-т байх ингээд заасан заалтуудаар үзэл баримтлалынхаа хүрээнд хуулийн төслөө боловсруулаад өргөн баригдаж байна. Бид нар хэлэлцэх эсэхийг нь шийддэг. Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг нь дэмждэг.

Тэгээд энэ үзэл баримтлал бүрнээр өөрчлөхийг хууль санаачлагчид, ажлын хэсэг хамтран ажиллаад, энэ өөрчлөлтүүдийг оруулаад, яах гэж парламент байж хууль хэлэлцэж байгаа юм. Өөрчлөлт оруулж, олонхоороо асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэгт л байгаа. Ингээд хэлэлцээд шийдвэрлээд явж байна. Энд ямар ч хууль ном зөрчсөн юм байхгүй. Ингээд Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** 2019 онд энэ хуулийг санаачилсан. Тэгээд яах вэ, хуулийн төслийн үзэл баримтлалын хувьд болбол энэ ажлын хэсэг дээр өөрчлөгдсөн зүйл байхгүй. Харин туршилагатай парламентч, манай Мөнх-Оргил гишүүн, манай эдийн засгийн ухааны доктор Баттөмөр гишүүн 2 энэ хуулийг ажлын хэсэг дээр ажиллаад нэлээд ийм чамбай хууль бас гаргаж байгаад бол маш их баяртай байгаа.

Анх 19 онд тухайн үед Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл гээд маш олон төрийн бус байгууллагууд энэ хуулийг өөрсдөө концепцыг нь боловсруулаад, Их Хурлын гишүүдэд энийг танилцуулаач гэж байх үед энэ хуулийг өөрсдийнх нь санаачилгаар анх энэ хуулийн төсөл боловсруулагдсан. Сая ажлын хэсэг дээр жишээ нь энэ Ажил олгогч эздийн холбоо нөгөө Ганбаатар гуай, нөгөө Баялаг бүтээгчдийн холбоо, бүх төрийн бус байгууллагууд нэгдээд энэ саналууд дээр нэгдсэн ажлын хэсэг дээр. Тэгэхээр би бол Цогтгэрэл гишүүний санаа зовж байгаа бол маш зөв. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа манай энэ Баттөмөр гишүүн ажлын хэсгийг ахлахдаа энэ НӨАТын хууль буюу Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль дээр эдийн засгийн ангиллууд гэж байдаг. Түүнийг Сангийн сайд баталдаг. Нэг ёсондоо эдийн засгийн ангиллууд дээр бизнесийн шинэ төрөл үүссэн ч гэсэн тухайн бизнесийн шинэ төрөл дээр шинэ мэргэжлийн холбоо байгуулах нь нээлттэй орхигдож байгаа.

Нэг ёсондоо одоо болбол Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 460 хуулиас бараг 44 хуульд мэргэжлийн холбоо гэдэг үг, нэр томъёо орсон мөртөө мэргэжлийн холбоо гэж юу вэ гэдгээ аль ч хуульд тодорхойлохгүй өнөөдрийг хүрсэн. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа яг нөгөө төр мэргэжлийн байгууллагуудын, хувийн хэвшлийн байгууллагуудын, экспертүүдийн саналыг шийдвэр гаргалтдаа ашиглах бололцоо л энэ хуулиар бий болж байгаа юм. Жишээ нь, өнөөдөр сонгодог мэргэжлийн холбоод гэж нэрлэж болохоор Хуульчдын холбоо байна, Өмгөөлөгчдийн холбоо байна, барилгын салбар Барилгын хөгжлийн ассоциаци гэхэд л тусгай зөвшөөрлийг олгодог ийм сайн жишгүүд байна. Мэргэшсэн үнэлгээчдийн институц байна, Мэргэшсэн нягтлан бодогчдын институц гээд ийм мэргэжлийн холбооны статустайгаар үйл ажиллагаа явуулаад чадавхажсан холбоодууд бий болсон.

Сая Аялал жуулчлалын хууль дээр хүртэл Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог хуульчлаад ороод ирлээ шүү дээ. Түүн шиг төр зарим энэ шийдвэр гаргалтад нөлөөлж байгаа, төр зарим энэ бодлого шийдвэрээсээ салж, мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлтийг оруулахгүй болбол цаашаа эдийн засгийн үйл ажиллагаа дэмжих ийм бололцоогүй болж байна. Ер нь болбол манай төрийн шийдвэр гаргалт байгаа онохгүй байгаа чинь энэ мэргэжлийн санал бодлуудыг сонсохгүй байгаагаар л холбоотой шүү дээ. Жишээ нь нийслэл дээр гэхэд л сая үүссэн энэ олон сонсголдууд, жишээ нь энэ ногоон автобусны асуудал гэхэд л тэр автобус Жагаа шиг нөхдүүдийг л энд оруулж ирүүлээд ногоон автобусны худалдан авалт хийсэн бол ийм байдал үүсэхгүй л байх байсан.

Эмийн сонсгол хийгдлээ яг эм ханган нийлүүлэгч байгууллагууд, эрүүл мэндийн салбарын экспертүүдийг оруулж ирээд тухайн асуудлууд дээр,

хууль дүрэм дээр нь мэргэжлийн холбоонд энэ чиг үүргийг шилжүүлсэн бол өнөөдрийн асуудал үүсэхгүй л байгаа байсан. Жишээ нь Зуун айлыг нүүлгэнэ гээд хэдэн жил ярив, 2 газар зогсоол барьчхаад, нүү гэхээр Зуун айлынхан нүүхгүй л байгаа биз дээ. Тэнд үйл ажиллагаа эрхэлж байгаа хүмүүсийн санал бодлыг сонсохгүйгээр л шийдвэр гаргаад байгаагаар холбоотой шүү дээ. Тэр Дэнжийн мянга дээр гэхэд л тэр махны үнээс болоод үнийн хөөрөгдөл үүсээд байна гэж таамгаар яриад л, яамны 3 мэргэжилтэн, төрийн 3, 4 мэргэжилтэн салбарын бодлогыг тодорхойлно гэдэг болбол өнөөдөр энэ байгаа онохгүй өнөөдрийн олон шийдвэртэй шүүд холбоотой.

Тэгэхээр энэ хууль гарснаараа төр мэргэжлийн холбоодууддаа чиг үүргээ өгөх, тэгээд мэргэжлийн салбар дүгнэлтүүдийг төрийн шийдвэр гаргалтад ашиглах бололцоо бүрдэнэ. Энэ хууль гарснаараа өнөөдрийн мэргэжлийн холбоодууд тогтвортой үйл ажиллагаагаа явуулна. Нэг ч байгууллагыг үйл ажиллагаанд нь ямар нэгэн яам, тамгын газар орохгүй. Энэ ажлын хэсгийн үеэр төрийн бус байгууллагууд болоод Ардчилсан намын бүлгээс өгсөн бүх саналууд туссан юм байна лээ.

**Г.Занданишатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй нэг саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр бол чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал байгаа. Энэ бол Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

“ГУРАВДУГААР БҮЛЭГ

**МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН  
ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ**

10 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

10.1. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, гишүүдээс бүрдэнэ.

10.2. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, дэд зөвлөлийн нийтлэг дүрэм, тэдгээрийн эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3. Мэргэжлийн нэгдсэн холбооны дэргэд тухайн салбарын онцлогоос хамаарсан үйл ажиллагаа, мэргэжлийн чиглэлээр дагнасан дэд зөвлөл ажиллаж болно. Дэд зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, дүрмийг удирдах зөвлөлийн хурлаар батална.

10.4. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд болон бусад албан тушаалтан энэ хуулийн 12.1.10-т заасан ёс зүйн дүрмийг зөрчсөн, тухайн салбарын болон мэргэжлийн эрх ашгийг хөндсөн, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл гаргасан бол хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тухайн албан тушаалтныг чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

10.5. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах ажлын албатай байж болно.

10.6. Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.7. Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.8. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна." Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Нямаагийн Энхболд, цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт явуулъя. Суудалдаа байна. Өнөөдөр төрсөн өдөр нь зохиож байгаа Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. 21 гишүүн дэмжиж, 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Үдээс хойш 2:30-аас чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу эцэслэн батлах санал хураалтууд явуулна. Гишүүд чуулганы танхимд бүрэн цуглана. Гишүүд яагаад бүгд босоод гараад яваад байна. Сууцгаагаарай.

13.51 цаг

**Найм. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Төв банк, дараагийн асуудалд орёе. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Үндэсний баялгийн сангийн хуультай холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл байна. Танилцуулгыг Баагаагийн Баттөмөр гишүүн. Төв банкны тухай хууль. Түүхэн хууль

баталлаа. Энэ их чухал. Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байгуу хороонд шилжүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслийн анхны.../үг тасрав/

**Г.Занданишатар:** Одонтуяа дарга.

**Б.Баттөмөр:** Хэлэлцүүлгийг явуулах үед Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжсэнтэй холбогдуулан Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн зүйлийг баримтлан санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы тухай, дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслийн

анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ, Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан дараах Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Энэ 14 цаг болж байгаа учраас нэг албан бичиг танилцуулъя. Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай. Албан ажлын зайлиггүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр барилга, хот байгуулалтын салбарт авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Ерөнхий сайдын мэдээллийн товыг хойшлуулж өгөхийг хүсье. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан гэсэн байна. Энэ хүсэлт, бичгийн дагуу Ерөнхий сайдын мэдээллийг хойшлууллаа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Монголбанкнаасаа санал авсан байгаа тийм ээ? Бодлогын хүүгээр тэд нар хүү төлөх гэдэг юман дээр жоохон юутай л юм байна лээ шүү. Тэд нар чинь бизнесийн байгууллага биш шүү дээ. Санал хураалт явуулна. Байнгын, энэ юу нь хаана байна вэ? Байнгын хорооны саналаар, наашаа аваад ирээч дээ. Байнгын хорооны саналаар анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргасан байгаа. Байнгын хороо Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжсэе гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулна. Бэлэн байна уу? Үгүй ээ, санал хураалт явуулах гэж байна, та суул даа. Эцэслэн батлах санал хураалт, үгүй ээ энэ анхны хэлэлцүүлгээр нь батлах санал хураалт явуулах гэж байна шүү дээ.

Байнгын хорооны гаргасан горимын саналаар анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжсэе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Манай Пүрэвдорж гишүүн ч бас ухамсартай гишүүн шүү бас, одоо хууль эцэслэн батална. Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53,8 хувиар дэмжсэн учраас Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

13.57 цаг

**Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/**

Одоо чинь. Үгүй ээ, үгүй. Уламжлалт мал аж ахуй чинь юу дуусчихсан. Одоо санал хураалт явуулна шүү дээ, Тогтохсүрэн даргаа. Завсарлагын хугацаа дууссан учраас Уламжлалт мал аж ахуйд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн талаар хуулийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Эднийх биш ээ, одоо цохино. 14 цаг болсон байна. Тэгээд Уламжлалт мал аж ахуйн үзүүлж байгаа уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах талаарх арга хэмжээний тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Хуулийн төсөлд Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан байгаа. 14 цаг болж завсарлагын хугацаа дууссан байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Одоо ингээд бүлгийн дарга үг хэлж болно. Үг хэлэхгүй, ирэхгүй болбол, ингээд үг байхгүй учраас завсарлага дууссан байна. Завсарлага дууссан учраас одоо үргэлжлүүлж хэлэлцэнэ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Уламжлалт мал аж ахуйд яг таны эргэлзээтэй асуудлыг чинь шийдэж байгаа санал байгаа юм. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын төсөв хооронд гэснийг, 6.2 дахь хэсгийн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон гэснийг тус тус хасаж, төсөлд дор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 6.2 гэсний дараа 6.3 гэж нэмэх.

6.3.Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн тухай бүр Улсын Их Хуралд танилцуулж байна. Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. Төсөв хооронд гэдгийг нь авсан, Төсвийн тогтвортой байдлын хууль гэдгийг нь авсан, хассан байна. 21 гишүүн дэмжиж, 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Ингээд Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах



тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна.

14.01 цаг

Одоо 2.30-аас, 2 Байнгын хороо одоо хуралдана, 2.30-аас эцэслэн батлах санал хураалтууд явагдана. Гишүүд, нийт гишүүд энд бэлэн байх ёстой. Зарлана, хоцорсон, тасалсан хүмүүсийг зарлана. Чуулган 2 цаг 30 минут хүртэл түр завсарлалаа. 2 Байнгын хороо хуралдах учраас.

2024 оны 04 дүгээр сарын 19, Баасан гараг,  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
14 цаг 48 минут.

### **ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын хаврын нэгдсэн чуулганы 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн үдээс хойших хуралдаан нээснийг мэдэгдье. 2 Байнгын хороо хуралдаж сая түр завсарласан. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо 2 хамтарсан хуралдаан сая тарлаа. Одоо ингээд хуулийн төслүүдийг эцэслэн батална. Улсын Их Хурлын гишүүд чуулганы танхимд цугларна.

Гишүүдийн ирцийн бүртгэл явуулна. Амгалангийн Адъяасүрэн гишүүн алга байна тас. Ширнэнбаньдын Адъшаа гишүүн алга байна тас. Норовын Алтанхуяг гишүүн байсан яачхав. Алтанхуяг гишүүн өглөө 9:59-өөр бүртгүүлсэн байна, дуудаж байна. Сайнбуянгийн Амарсайхан сайд түрүүн байсан. Цогт-Очирын Анандбазар гишүүн. Энэ гишүүд ирцэд орсон боловч одоо алга байна, дуудаж байна. Анужин гишүүн тас. Аубакир томилолттой.

Баделхан гишүүн байна. Батжаргал гишүүн байна. Өглөө 9:53-д бүртгэгдсэн. Батлут гишүүн байхгүй байн дууд. Жамбын Батсуурь тас. Баагаагийн Баттөмөр гишүүн өглөө байсан, 10 цаг 10 минутаар бүртгэгдсэн байна, одоо дуудаж байна. Энхбаярын Батиугар, Батиугар гишүүн 10 цаг 20 минутаар бүртгэгдсэн, алга байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн байна, өглөө бүртгэлтэй. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн байна. Балжиннямын Баярсайхан гишүүн тас. Буланы Бейсен гишүүн тас. Хаянгаагийн Болорчулуун 10 цагаар бүртгэгдсэн, дуудъя. Булгантуяа гишүүн байна. Сандаагийн Бямбацогт, Жамбалын Ганбаатар сайд нар ирье.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн чөлөөтэй. Дашдондогийн Ганбат гишүүн, Гочоогийн Ганболд гишүүн, Наянтайн Ганибал гишүүн 10 цаг 32 минутаар бүртгэгдсэн дуудаж байна. Хассуурийн Ганхуяг гишүүн 9:53-аар бүртгэгдсэн байхгүй байна. Ганхуяг гишүүнийг дуудъя. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн байна. Дамдинням чөлөөтэй. Тогмидын Доржханд гишүүнийг дуудъя. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн байхгүй байна. Бадарчийн Жаргалмаа 10:11-ээр бүртгэгдсэн дуудъя. Бадарчийн Жаргалмаа гишүүн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн 9:59-өөр бүртгэгдсэн байна. Г.Занданшатар 8 цаг 39 минутаар бүртгэгдсэн, байж байна. Лхагвын Мөнхбаатар 10 цагаар бүртгэгдсэн, байна. Цэндийн Мөнх-Оргил гишүүнийг дуудъя.

Амарсайхан сайд таны карт уншигдаагүй байгаад байх юм. Одоо орлоо. 11:25-аар одоо орж ирж байна. Цэндийн Мөнх-Оргил гишүүн дуудъя. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн байна, өглөө ирсэн байсан. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн байна, 9:57-гоор бүртгэгдсэн байна. Нанзадын Наранбаатар 9:54-өөр бүртгэгдсэн, Нанзадын Наранбаатар гишүүн хаана байна вэ, байна. Жамбалын Ганбаатар

гишүүн байна. Салдангийн Одонтуяа гишүүн байна. Та яагаад бүртгэлд байхгүй байгаад байна. Таных бүртгэлд байхгүй байгаад байгаа юм. Та картаа дахиж уншуулъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн бүртгүүлъя. Манай Саранчимэг гишүүн өглөө эрт ирсэн байна, таслаагүй сайн байна. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн алга байна. Цэдэвийн Сэргэлэн, Тогтохсүрэн гишүүн 9:35-д. Цэвэгдоржийн Туваан гишүүн 11:54-өөр бүртгэгчхсэн алга байна, дуудъя. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн 10:14-д, байна. Чинбатын Ундрэм гишүүн, Ундрэм гишүүн хаачив? Ням-Осорын Учрал гишүүн, Учрал сайдыг дуудъя, 9:48-аар бүртгэгчхсэн. Учрал сайд байна, 9:48-аар өглөө бүртгэгчхсэн. Чимэдийн Хүрэлбаатар сайд алга байна, дуудъя, тас огт ирээгүй.

Дамдины Цогтбаатар сая байсан, бүртгэлээс гарсан байх юм. Дуудуул. Одонгийн Цогтгэрэл гишүүн бүртгэлд алга байна, дуудъя. Цэрэнпунцаг гишүүн 9:55-аар бүртгэгдсэн, байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн 9:58-аар бүртгэгдсэн байна. Дахиад төрсөн өдрийн баярын мэнд хүргэе. Содномын, түрүүн чинь зүгээр саналаа өг гэж хэлсэн юм. Содномын Чинзориг сайд, Чинзориг сайдыг дуудъя, өглөө бүртгүүлчхээд явчихсан байна. Чойжилсүрэн гишүүн 10:17-гоор бүртгэгдсэн, байхгүй байна, дуудъя. Б.Энх-Амгалан гишүүн тас. Л.Энхамгалан байхгүй. Б.Энхбаяр сайд байхгүй. Нямаагийн Энхболд гишүүн 10 цагаар, 10 цаг 06 минутад бүртгэгдсэн байна. Энхтүвшин гишүүн томилолттой. Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн алга байна. Өнөрболор гишүүн танхимдаа орж ирье, нэлээн хоцролттой байна. Оюунчимэг гишүүн 9:45-аар бүртгэгдсэн байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн байна. Санал хураалт явуулна. Байхгүй гишүүдийг дуудаарай.

**Ес.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар**

2024.03.18-ны өдөр өргөн  
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Эцэслэн батлах бэлтгэл хангаж байх хооронд, хуулийн төслүүд бэлтгэл хангаж байх хооронд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Нанзадын Наранбаатар гишүүнийг индэрт урьж байна.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 3 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 4 сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороонд ишлжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороо 2024 оны 4 сарын 19-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн

шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд, шилжүүлчихлээ л дээ. Төсвийн байнгын хороонд шилжүүлчихсэн.

14.58 цаг

**Арав. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороод боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудалд оръё. Энэ дээр Чинбүрэн гишүүн. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг, хамтарсан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг 2024 оны 3 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 4 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Нэгдсэн хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан дотоодын тариалан эрхлэгчдийн болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх, үнийн зохистой түвшнийг хадгалах, шударга өрсөлдөөнийг дэмжих нь зүйтэй гэж Ажлын хэсэг үзсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Байнгын хороодын 2024 оны 4 сарын 19-ний өдрийн хамтарсан хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах тухай горимын санал гаргасныг Байнгын хороодын хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их

Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын хамтарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Байнгын хороод хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 25 гишүүн дэмжиж, 54,1 хувийн санал 64,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлтэй хамт эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна. Тэгэхдээ энэ тогтоол бол 39-өөр биш шүүд баталж болно шүү дээ. Энэ тогтоол бол газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдсэн, үр тариа, ургацын улаан буудайг экспортлох, тариалалтыг дэмжих, улсын нөөцөд худалдан авах үүрэг чиглэлүүд өгөгдсөн. Ер нь газар тариалангаа үйлдвэрлэлээ дэмжихэд чиглэсэн ийм тогтоол батлагдаж байгаа гэж Байнгын хорооны танилцуулгад дурдсан.

15.02 цаг

### **Арван нэг.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах**

Ингээд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хуулийн төслүүд эцэслэн батална. Энэ Гаалийн албан

татвараас чөлөөлөх тухай болон Үндэсний баялгийн сангийн тухай хууль, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиуд, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиуд, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл гээд нийтдээ 17 хуулийн төслийг эцэслэн батална.

Эцэслэн батлах бэлтгэлийг Бүлгийн дарга нар, дэд дарга нар хангаж ажиллана. Ирцийг хангана. Одонтуяа гишүүнээ. Хуулийн төслүүд эцэслэн батална. Нийт 17 хуулийн төсөл батална. Ганибал гишүүн орж ирж байгаа. Доржханд гишүүн ороод ирчихсэн. Ганбат гишүүн орж ирэх ёстой.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, мөн холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д долоо хоногийн баасан гаргийн 10 цагаас хуулийн төслүүдийг эцэслэн батлах бөгөөд хуулийн, хуралдааны ирц, хуулийн төсөл эцэслэн батлуулах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслүүдийг эцэслэн баталж болно гэж заасан. Үүний дагуу Байнгын хороод хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангаж, батлуулах хувилбарыг бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна. Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Ардчилсан намын

бүлгийг төлөөлөөд Бөхчулууны  
Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Баялгийн сангийн хууль орж ирж байгаа. Тэгэхээр ер нь бол үүгээр бол олон, олон стратегийн орд бүхий төрийн өмчийн компани дээр ард иргэдийн хувьцаа бол хувьцаа авах, хувьцаатай болгох энэ ажлыг хийгдэнэ гэж харж байгаа. Тэгэхээр хувьцаа гэдэг бол саалийн үнээтэй адилхан юм л даа. Саалийн үнээ өдөр болгон сүү өгдөг болбол хувьцаа жил бүр ноогдол ашиг өгдөг. Тэгээд харамсалтай нь манай Монголын ард түмэнд өгсөн саалийн үнээ болох Эрдэнэс таван толгой компани маань нэлээн хэдэн жил сувайрч, сувайрч байгаад тэгээд сонгуулийн жил болоод жоохон дэлэгнэж энэ хани нээх өдрөөр нэг хэдэн төгрөг өгсөн байгаа. Тэгээд хааяа нэг л дэлгэнэ гэх юм. Тэгээд сонгуулийн жил болгон л дэлэгнэдэг ийм сувай үнээтэй баймааргүй байна.

Ер нь бол сонгуулийн маргаашаас эхлээд энэ саалийн үнээ маань дахиад л сувайрчихна, 3 жил сувайрна. Тэгээд 28 оны сонгуулиар л дахиад нэг дэлэгнэх байх л даа.

**Г.Занданшатар:** Ганибал гишүүнээ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ тохиолдолд бид нар бол яг энэ миний өргөн барьсан Эрдэнэт үйлдвэрийн 20 хувийг ард түмэнд өгөх, 20 хувийг нь Монголын үндэсний компаниуд, хувийн хэвшлийн компаниудад олгох энэ хуулийг тогтоолын төслийг бас хамтатгаж хэлэлцэх ёстой. Бид нар олон үнээтэй болох ёстой байхгүй юу даа. Ганцхан үнээтэй байвал тэр нь сувайрчихвал тэгээд тэр айл чинь хар цай ууна шүү дээ. Тэрний оронд олон, олон стратегийн орд бүхий төрийн өмчийн компани дээрээ, компани дээрээ хувьцаатай болж, олон саалийн үнээтэй болох юм болбол бид нар нэг нь жоохон муу ажиллавал нөгөөдхөөсөө сайхан сүү аваад ингээд л хувьцааныхаа ноогдол ашиг аваад л би Монголын ард түмэн

сайхан амьдрах амьдрах ийм боломж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ баялгийн сангийн бас нэлээн олон заалт дээр нь би энэ цаашидаа бол энэ төрийн өмчийн компани дээр Монголын ард түмэн бас тодорхой хэмжээний хувьцаатай болж, өдөр болгон сүүтэй цай уудаг ийм л болно гэж үзээд энэ хуулийг бас дэмжээд явж байгаа шүү гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн.

**Г.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр Улсын Их Хуралд суудалтай намуудын зүгээс, ялангуяа намуудын удирдлагын хувьд бол бид нар харилцан тохиролцоод, өнөөдрийн энэ парламентын түвшинд бид нар зайлиггүй эдийн засгийнхаа реформыг хийх ёстой юм байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт буюу тогтолцооныхоо реформыг бид нар амжилттай хийлээ, ард нь гарлаа. Одоо харин эдийн засгийнхаа реформыг хийх нь зүйтэй гэсэн энэ агуулгаар бол харилцан тохиролцож энэ Баялгийн сангийн тухай хуулийн төслийг бол ХҮН намын зүгээс бид нар дэмжиж байгаа. Тэгээд дэмжиж байгаа болохоор өнөөдөр ингээд батлах гэж байна.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бас 2-оос 3 зүйлийг хэлмээр байгаа юм. Дэлхий дээр 200 улс байгаа, үүнээс 30-аас 40 улс нь баялагтай, нөөцтэй, зах зээл рүү гаргаж чаддаг. Тэгээд эдгээр улс яаж хөгжчихөөд байна гээд тэгэхээр зөвхөн ингээд баялгийг олборлоод гаргаж ирээд, иргэддээ тараахаас гадна, энийгээ хөрөнгө оруулалт болгож чадсандаа амжилт нь байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол гадна, дотнын хөрөнгө оруулалтыг татаж, бизнесүүдийгээ дэмжих, гадаад зах зээл рүүгээ экспортыгоо дэмжих энэ боломж бололцоог нь газар доорх нөөцөөсөө гаргаж ирээд байгаа юм. Арабын улсууд байгаа 1960, 1970-аад онд энэ хүмүүс бол ерөөсөө ингээд ядуу байсан, орлогогүй байсан.

Тэгээд газрын тосоо гаргаж ирээд, яаж баялгаа хуваарилах вэ гэхээсээ илүү яаж сан үүсгэх юм бэ, яаж хөрөнгө оруулалт бий болох юм бэ гэдэг дээр илүү анхаараад явсныхаа үр дүнд өнөөдөр Аби Дабигийн сан бол нэг триллион долларын ийм эх үүсвэртэй сан болчихоод байгаа юм. Тэр эх үүсвэртэй сангаараа зөвхөн өөрсдийнхөө газрын доорх бүтээгдэхүүнд биш бусад улсуудын газрын доорх нөөц рүү хөрөнгө оруулаад байгаа байхгүй юу. Ингэхээр шавхагддаг нөөц шавхагддаггүй нөөц гэж байдаг. Шавхагддаг нөөц чинь өөрөө бусад улсуудад үржээд байх энэ боломж нь бол баялгийн сангаараа бий болж байгаа юм.

Тэгээд ийм болохоороо Монгол Улсад өнөөдөр баялгийг тэгш хуваарилна гэхээсээ илүү бас баялгаа ашиглаад бодит эдийн засгаа өсгөх, эдийн засгаа тэлэх ийм байдлаараа бид нар цаашаа харж явах учиртай юм. Энэ ч агуулаараа дэлхий дээр өнөөдөр хөрөнгө оруулалтууд татагдчихаад байгаа ийм үед бол бид нар энэ баялгийн сангийнхаа эх үүсвэрийг гаднын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх, *income investment* буюу бид нар өөрсдийнхөө тодорхой түвшнийг гаргаад явах ийм эх үүсвэр байдлаар ашиглах хэрэгтэй байгаа юм. 100 сая долларыг бид нар өнөөдөр гаргаж ирж ашиглах уу, эсвэл 100 сая дээрээ нэмээд 900 сая буюу тэрбум долларыг оруулж ирээд хөрөнгө оруулалт хийгээд явах уу гэдэг ийм шийдэл байгаа юм шүү.

Ийм болохоороо дэлхийн улсууд баялгийн санг илүү их ашиглаад хөгжөөд байгаа юм. Ийм болохоор хөрөнгө оруулалтаа татаад байгаа юм. Хятадууд ингэж татсан, Япончууд ингэж татсан тухайлбал. Тэгээд Норвегийн сангууд, Аби Дабигийн сангууд, *future fund* гээд энэ Нью Зеланд бүгдээрээ л яг ийм байдлаар концептой явж байгаа юм шүү. Тэгэхээр энэ бол Монголчуудын боломж юм. Цалингаа өсгөх, тэтгэврээ өсгөх, тэгээд цаашаагаа ингээд амьдрал хөөж яваад байгаа, гадагшаа явж байгаа залуучуудынхаа бодит орлогыг нь өсгөх

боломж бол энэ эдийн засгийн реформ. Үүний эх үүсвэр нь болохоор энэ баялгийн сангаар дамжиж орж ирнэ. Энийгээ бид нар харин сайн удирдах ёстой байгаа. Удирдахдаа бол хэн нэгэн дарга шийддэг биш, хэн нэгэн төр шийддэг биш, мэргэжлийн баг нь энийг удирдаад явах ийм зохицуулалт хийх хэрэгтэй байгаа юм.

Нөгөө талдаа бас бид нар тэтгэврийнхээ реформыг тууштай хийх хэрэгтэй байгаа. Энд эх үүсвэр хэрэгтэй байгаа. Тухайлбал, Чили бол баялгийн сангаас орж ирсэн мөнгөөрөө тэтгэврийнхээ реформыг хийгээд хөрөнгийн зах зээлээ босгож ирсэн ийм түүх байгаа юм. Казахстан бас ингэж явж байгаа. Яг тэрэнтэй адилхан Монголчууд өнөөдөр тэтгэврийн реформоо хийх тэр суурь эх үүсвэрээ бол энэ баялгийн сангаасаа олж аваад, тэгээд тэтгэврийнхээ реформыг зоригтой хиймээр байгаа юм. Энэ бол цаашидаа бол урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр болох гээд байгаа юм. 30, 40, 50 жилийн хугацаатай ийм эх үүсвэр чинь энэ тэтгэврийн сан дээр чинь бий болох гээд байгаа. Үр дүнд нь бид нар Оюу толгой мэтийн томоохон ордууд руугаа өөрсдөө хөрөнгө оруулалт хийх ийм боломж бас бүрдэх гээд байгаа юм. Энэ бол ингээд агуулгаараа бол урт хугацаандаа Монгол Улсад маш их хэрэгтэй ийм зохицуулалт юм.

Дараагийн нэг зүйл нь бол Ирээдүйн өв сан гэдэг энэ зохицуулалт маань хэвээрээ цаашаа үргэлжлэх ёстой. Бид нар гадаад зах зээл рүү хөрөнгө оруулалтаа хийгээд л явах ёстой. Дотоод эдийн засгийн халалт руу ерөөсөө оруулж болохгүй. Өнөө үеийнхэн, ирээдүй үеийнхэн яг энэ өгөөжөө ижилхэн хүртэх энэ зохицуулалт бол Ирээдүйн өв сан юм. Тэгэхээр ийм 3 энэ концепц дээр энэ хуулийн төсөл явж байгаа болохоор эдийн засагчдын хувьд бол энийг бүрэн дэмжиж байгаа. Харин цаашаагаа хөгжүүлээд явах боломж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн ХҮН намын дарга Тогмидын Доржханд үг хэллээ. Доржханд гишүүн 3 нам болбол энэ хуулийг гаргая гэж улс төрийн хүсэл зорилгоо илэрхийлж, санамж бичигт гарын үсэг зураад хамтарч ажиллаж, гаргаж байгаа хамтын бүтээл юм. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд үг хэлнэ.

**Л.Оюун-Эрдэнэ:** Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд, бас улс төрийн намын удирдлагууд нэлээдгүй олон жилийн хугацаанд мэтгэлцэж ярилцаж, зарим газраа бас маргаантай ч гэсэн өнөөдөр Монгол Улсад Үндэсний баялгийн сан цогц байдлаар анх удаа одоо юу батлагдах гэж байна. Тэгээд та бүхнийг дэмжиж өгнө гэдэгт бол итгэлтэй байна.

Үүн дээр бас улс төрийн намууд зөвшилцөж, нэгдмэл байр суурьд хүрч, хэлэлцэх тал дээр санамж бичигт бол гарын үсэг зурсан. Би тэгээд Ардчилсан намын дарга Гантөмөр дарга болон ХҮН намын дарга Доржханд, мөн нийт гишүүд дэмжигчдэд нь талархаж байгаагаа илэрхийлж байна. Мэдээж ийм том, том асуудлууд Үндсэн хууль, бүсчилсэн тойрог, нийслэлийг ч гэсэн бүсчилж хуваах гээд ийм том асуудлууд бол мэтгэлцээнтэй. Мэдээж энэ бол парламент, ард түмний төлөөллийн мандатын эрх авсан гишүүд маань өөр өөрийн байр суурийг илэрхийлж байгаа. Дунд нь бас янз бүрийн ч асуудлууд бас болж байгаа. Гэхдээ өнөөдөр ингээд эцэслэн батлах хэмжээнд зөвшилцөж чадна гэдэг бол туйлын чухал зүйл юм.

Тэгээд энэ бол баялаг хүртээмжтэй байх, эдийн засаг илүү хүртээмжтэй байх бас ийм эхлэл, суурь зарчмыг тохирч байгаа гэдгээрээ энэ хууль бол маш их чухал агуулгатай. Хэдийгээр хуудасны хувьд нимгэн ч гэсэн энэ бол яг зарчмын хувьд бол их тийм том агуулга. Монгол Улсын

Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн бас баялагтаа эзэн байх суурь реформ бас энэ эрх зүйн орчин бүрдсэнээр хэрэгжих ийм том эхлэл цэг бол тавигдана гэдэгт бол итгэлтэй байгаа. Ирээдүйн өв сан бол яг Норвегтой адилхан Доржханд гишүүний санал болгодгоор энэ бол яг үржүүлэхийн хурд байх эрх энэ хууль батлагдсанаар ингээд нээгдэж байна гэсэн үг. Нөгөө талаараа Ирээдүйн өв сангийн хуримтлал зөвхөн валютаар хадгалагдана гэдэг байдлаар хуульчлагдаж байгаа. Энэ бол өөрөө одоо бид нар 5 орчим тэрбумд хүрсэн валютынхаа нөөцийг дахиад арвижуулах ийм том боломж бол бас ингээд гарч байгаа. Энэ бол бүх иргэдэд нэлээн хүртээмжтэй ийм зүйл болно.

Хуримтлалын сан энэ бол яг Сингапурын хуримтлалын нэгдсэн сангийн суурь зарчим дээр тулгуурлан боловсруулагдсан ийм хэсэг. Нэг үгээр хэлбэл манайх орон сууцжуулалтын том реформ хийгдэж чадахгүй явсан бол явсан нь бол эх үүсвэр үнэтэй байсанд л байгаад байгаа. Бодлогын хүү өндөр, зээлжих зэрэглэл ЗВ-д хүрэхгүй ийм агуулгатай яваад байсан учраас хаанаас ч мөнгө татсан бид нар дандаа өндөр хүүтэй ийм зээл байгаад байсан. Одоо бол бид нар жилд дунджаар 500-аас 700 орчим тэрбумын, Монголбанкттай ингээд яриад хувийн хэвшлийнхтэй бид нар үржүүлгийн хурд болгож чадвал жил бүхэн 1 их наядаас хамаагүй том эх үүсвэрийг бид нар орон сууцжуулалт руу оруулах, тэр хүүгээ өөрсдөө удирдан зохион байгуулах ийм том боломжийг өнөөдөр энэ хууль батлагдсанаар гаргаж байна гэсэн үг.

Дээрээс нь эрүүл мэнд, боловсрол энэ бол дундаж давхаргыг бүрдүүлэх хүний хөгжлийн хамгийн том суурь асуудал. Боловсролын салбар гэдэг бол өөрөө зөвхөн боловсролын салбар биш, боловсролын салбар бол бүх ирээдүйн, бүх эдийн засгийн салбартай уялдсан ийм том реформ учраас үүнийг Баялгийн сангаас шийдэх ийм боломж бол бүрдэж байна.

Дээрээс нь уул уурхайн ил тод байдал хангагдаж байна. Нэг гэр бүл цаашидаа стратегийн ордуудыг эзэмшээд яваад байх нөхцөл байдал энэ хуулиар өнөөдөр ингээд цэг тавигдан хязгаарлагдаж байна. Тэд бирж дээр нээлттэй компани болно, олон улсын аудитад байнга ордог болно, илүү ил тод байдал дээшлэх ийм нөхцөл байдал үүсэж байгаа юм. Нөгөө талаар өв залгамжилж байгаа тохиолдолд 30 хувийн татвар тавих ийм эрх зүйн орчин энэ хууль батлагдсанаар бас хийгдэж байгаа. Энэ бол бусад улсад 80 хүртэл хувь байдаг. Гэхдээ яах вэ 30 хүртэл хувь гэдэг бол том эхлэл цэг.

Нөгөө талаараа стратегийн ордууд, мөн үүсмэл ордуудыг зүгээр хаягдал гэдэг байдлаар яваад байсан. Олон далд эдийн засаг ил болж байгаа юм. Олон далд эдийн засаг ил болж байгаа. Түрүү жил гэхэд бид нар төсөв 4 их наядаар давж биелсэн. Үүн дээрээ тулгуурлаад бид нар цалин, тэтгэвэр тэтгэмжээ нэмж чадсан. Яг үүнтэй адилхнаар энэ Үндэсний баялгийн сан батлагдсанаар уул уурхайн ил тод байдал хангагдаж, одоо байгаа эдийн засаг илүү их тэлэх, бид 36 их наядаас 74 их наяд хүртэл эдийн засаг бол тэлсэн. Одоо цаашидаа бид нар үүнийг 100 их наяд руу аваачих хэрэгтэй. Энэ бол зөвхөн экспорт биш. Энэ бол ерөөсөө эдийн засагт ил тод байдал ирснээрээ ийм асуудлууд бол болж байгаа юм.

Мэдээж энэ дээр саад хийхийг хүсэж байгаа. Дараа нь энэ хуулийг Цэц дээр унагаахыг эрмэлзэж байгаа хэсэг бүлэг нөхдүүд бол байгаа. Энэ бол хэдхэн гэр бүл, Монголын бүх баялаг дээр эзэн суусан хэдхэн хүмүүс энэ давуу байдал, энэ ил тод байдлыг хийлгэхгүйн төлөө нэгдэх болно. Үүн дээр улс төрийн намууд маш их сонор сэрэмжтэй байж, яг одоо зөвшилцөж байгаа энэ агуулга дээр тогтож чадсан хуулийн төслөө хамгаалаасай гэж хүсэж байна. Дунд нь энэ далд эдийн засгаас авлигал авч байгаа хүмүүс байгаа. Энэ тэнд нууц данстай,

түүнийгээ их тийм гоё, гоё нэрээр нэрлэгчхсэн ийм нөхдүүд байгаа. Эд нар удахгүй бас ил болох нь ойлгомжтой. Тэгээд цагийн аясаар бүх зүйл үнэн дээр л очиж тулна. Мөнгөний ул мөр, хүн амины ул мөр хэзээ ч алга болохгүй. Тэгэхээрээ энэ бүх зүйл одоо үнэний дагуу явж, бодит үнэнийг илчилдэг нь өөрөө ардчилсан нийгмийн хамгийн том үнэт зүйл. Бодит үнэнийг хаах тусам тэр ирээдүйд очиж илүү их тийм өөр газар очиж, их өөр байдлаар дэлбэрдэг нь бас ингээд бүх л улс орны түүхтэй холбоотой ийм асуудал юм.

Тэгээд ярвигтай байсан ч гэсэн, маргаантай байсан ч гэсэн өнөөдөр ингээд парламентын гишүүд нам харгалзахгүйгээр энэ зарчим дээр ингээд ёсчлон батлахад бэлэн болсон гэж Ерөнхий сайдын хувьд ойлгож байна. Тэгээд би бас та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Яагаад гэхээр энэ бол Монгол Улсын маш том түүхэн эргэлтийн цэг бол өнөөдөр болж байна. Яах вэ одоохондоо энэ бүтэн ойлгогдохгүй байж магадгүй. Энэ удахгүй яг энэ концепцоор явж чадвал уул уурхайн баялаг хүртээмжтэй байна гэж бид нар олон жил ярьсан. Одоо бол бүх стратегийн ордуудын 34 хувь шууд иргэдийн сайн сайханд, гэхдээ бэлнээр биш орон сууцжуулалтын реформ, боловсрол, эрүүл мэндэд зарцуулагддаг болж байгаагаараа энэ бол туйлын одоо чухал юм. Тэгээд парламентын эрхэм гишүүд та бүхэндээ бас талархаж байгаагаа гүйцэтгэх засаглалын нэрийн өмнөөс илэрхийлье.

**Г.Занданиатар:** Баярлалаа. Одоо санал хураалт явуулна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Энэ бүртгэлийн санал хураалт, туршилтын санал хураалт явуулсан. Үдээс хойших анхны санал хураалт учраас энэ бүртгэлийн санал хураалт. Одоо санал хураалт явуулна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний энэ хурууны хээ уншигдахгүй



байсан уу сая тийм ээ. Карт чинь сугарчихсан байна. Буруу карт дээр суучихсан. Ингээд техникийн, техникийн хяналтын санал хураалт явууллаа.

Одоо Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал, эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Ирээдүй өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Ямар ч тийм санаа байгаа шүү. Би сая хуруугаа буруу хийгээд эсрэг санал гарчихлаа. Хумсныхаа толиогоор хийчихлээ. Тэгээд дахиж.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Та бол дэмжсэн санал өгсөн юм байна тийм ээ?

**Б.Пүрэвдорж:** Тийм. Уул нь.

**Г.Занданшатар:** Ингээд 38 учраас дэмжсэнд тооцвол.

**Б.Пүрэвдорж:** Хэрэггүй, хэрэггүй. Одоо яачихъя. Тэгээд би дахиж санал хураалт өгөөч гэж горим гаргаж байна.

**Г.Занданшатар:** Саяын санал хураалтыг хүчингүйд тооцож, хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүний горимын саналаар санал хураалт явуулж байна. Олонхын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Саяын санал хураалтыг 95 хувийн саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. 95 хувийн саналаар хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулна. Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт дахиж

явуулъя. Санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Сайнбуяны Амарсайхан гишүүн.

**С.Амарсайхан:** Сая өгсөн дэмжиж өгсөн санал эсрэг гарсан учраас горимын санал гаргаж дахин санал, энэ саналыг хүчингүй болгож өгөхийг хүсье.

**Г.Занданшатар:** 2 санал хураалт явуулна. 1 дэх нь энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт, Сайнбуяны Амарсайхан гишүүний саналаар санал хураалт явуулъя. Манай Дашдондогийн Ганбат гишүүн орж ирлээ. Ингээд энэ 97,4 хувийн саналаар энэ горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулна. Энэ хариуцлагатай санал хураалт дээр бас хөдөө гадаа олон гишүүн томилолтоор ажиллаж байгаа. Техникийн саатлууд ингээж гараад байгаа учраас гар өргөж санал хураалт явуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Тэр санал хураалт. Тэгэхгүй бол ингээд байсхийгээд дахин, дахин санал хураагаад баймааргүй байна. Гар өргөөд явчхаж болно. Горимын саналаар бол. Тэгвэл ингээд горимын саналыг дэмжихгүй гэж байгаа болбол, одоо санал хураалтыг дахиж явуулъя. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Тогтохсүрэн даргаа. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Засгийн засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн баталъя. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн. Өнөрболор гишүүн. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн горимын санал хэлнэ.

**Д.Өнөрболор:** Миний төхөөрөмж ажилласангүй даргаа, энэ саналыг хүчингүй болгож өгч, шинээр санал хураалгаж өгнө үү. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Өнөрболор гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. 97,5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Энэ санал хураалтыг горимын саналаар хүчингүй болгосон тул санал хураалтыг дахиж явуулъя. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Миний төхөөрөмж дээр алдаа гарчихлаа. Дахин санал хураалт явуулж өгөөч.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 97,5 хувийн саналаар 39 дэмжиж Даваасүрэн гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Ерөөсөө энэ олон хууль батална өнөөдөр. Горимын санал ер нь бүгд дэмжиж байгаа юм чинь гар өргөж санал хураалт явуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн гишүүд гараа, санал хураалт явуулъя. Зүгээр ээ, тоолчихно. Эсрэг гаргаж байгаа нь гараа өргөөд л болно, илүү хурдан явна. Горимын саналыг дэмжиж 92,5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг гар өргөж явуулна. Энэ чинь ашигт малтмал байх тийм ээ.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Татгалзаж байгаа хүн гараа өргөнө үү. Татгалзаж байгаа хүн байхгүй, 40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 40 гишүүн дэмжиж байна. Татгалзаж байгаа гишүүн, дэмжихгүй байгаа гишүүн байна уу? Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байхгүй. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Алга байна. 40 гишүүн дэмжиж тогтоол батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 40 гишүүн дэмжиж байна. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Алга байна. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөе. 40 гишүүн дэмжиж байна. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Алга байна. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 40 гишүүн дэмжиж байна. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Алга байна. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Дараагийн хууль. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргө. Эцэслэн батлах дээр үг байхгүй. Тоолоорой. 40 гишүүн дэмжиж, татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байна уу? Пүрэвдорж гишүүнээ, татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байна уу? Алга байна. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдана.

Хамт өргөн мэдүүлсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 40 гишүүн дэмжиж байна. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Алга байна. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хоршооны тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 40 гишүүн дэмжиж байна. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Алга байна. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 40 гишүүн дэмжиж байна. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байхгүй. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Мэргэжлийн нэгдсэн холбооны. Татгалзаж, түдгэлзэж байгаа хүн байвал гараа өргөнө үү. 1 гишүүн татгалзаж, 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Ганбат гишүүн. 40. Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байна уу? 1 гишүүн татгалзаж, 39 гишүүн дэмжиж Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 40 гишүүн дэмжиж байна.

Татгалзаж, түдгэлзэж байгаа гишүүн байвал гараа өргөнө үү. Байхгүй байна. 40 гишүүн дэмжиж тогтоолын төсөл эцэслэн батлагдлаа. Хууль, тогтоолын төслүүд эцэслэн батлагдлаа.

15.53 цаг

### **Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох**

Эцсийн найруулгыг уншиж танилцуулъя. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Нөгөө 5 сарын 1-нээс учраас энэ хоригийн хугацаа өнөөдөр эцсийн найруулга сонсох шаардлагатай байна. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолтой, тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хуультай дагалдан гарсан Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Дагалдан гарсан Хоршооны тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга

байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Тогтоолын төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндэсний баялгийн сангийн хууль. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Холбогдуулж боловсруулсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын эцсийн найруулга дээр, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Хууль буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга

байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагалдан гарсан Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн

байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.56 цаг

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг та бид баталлаа. Тэгээд энэ хуулийг заавал хэлэлцэн батлах ёстой. Энэ бол бидний үүрэг хариуцлага гэсэн итгэл үнэмшил энэ удаагийн Улсын Их Хурал, Засгийн газарт байсан. Ард иргэд ч итгэл найдвар тавьж хүлээсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын манлайлал дор, парламентад суудалтай улс төрийн намууд зөвшилцөж тохиролцож, Улсын Их Хурлын гишүүд идэвх санаачилгатай ажиллаж, богино хугацаанд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталлаа. Манай Баагаагийн Баттөмөр гишүүнээр ахалсан ажлын хэсэг бол хуулийн төслийг улам чамбайруулж, байгалийн баялаг ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж энэ хуулийг бол их үр өгөөжтэй түүхэн хууль болгож баталсан.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялаг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны төрийн бодлогод тулгуурлах бөгөөд одоо ба ирээдүй үеийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо ба ирээдүй үеийн бүх иргэдэд тэгш, шударга, хүртээмжтэй байх, байгалийн баялаг ашигласнаас олох орлого, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж Үндсэн хуульчилсан. Энэ үзэл санааны дагуу энэ Үндсэн хуулийн нэмэлт,

өөрчлөлтийн тулгуур үзэл баримтлал дээр тулгуурлаж, Засгийн газар манлайлан энэхүү чухал хуулийн төслийг боловсруулж, тэгээд энэ хууль батлагдсанаараа Монгол хүн Монгол газартаа, Монголын баялагтаа эзэн байх, түүний үр шимийг тэгш шударга хүртэх эрх зүйн үндэс баталгаажиж байна.

Цөөхөн гэр бүлийн гэж нэрлэгдэж байгаа Монгол Улсын Ерөнхий сайдын тодорхойлсноор одоо тэгш шударга, хүртээмжгүй байгаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс эхлээд энэ байгалийн баялгийн үр өгөөж ард түмэнд өгөөж багатай байгаа гэсэн энэ шүүмжлэл дээр тулгуурлаж байгалийн баялгийн үр өгөөж дийлэнх нь ард түмэнд оногдох эрх зүйн үндсийг энэ хуулиар тогтоолоо.

Өмнө нь Хөгжлийн сангийн тухай, Ирээдүйн өв сангийн тухай хууль батлагдсан ч байгалийн баялгийн орлогоос үр өгөөжөөс нь иргэдийг хүртээх зарчмыг зохистой хэрэгжүүлж чадаагүйг бид хүлээх ёстой. Баялгийн хулгай газар авсан. Баялгийн хулгайтай тэмцэх ажлыг Засгийн газар, Улсын Их Хурал манлайлж, энэ түүхэн 4 жилийн хугацаанд олон өөрчлөлтийг хийлээ. Улсын Их Хурал, Засгийн газраас энэ онд олон нээлттэй сонсголудыг зохион байгуулж, нотлох баримтыг шинжлэн судалж, энэ бодит байдлыг ил тод болгосон. Одоо ч гэсэн Ашигт малтмалын лицензийн асуудлаар хяналт шалгалтын түр хороо байгуулж, нээлттэй сонсгол зохион байгуулж ажиллахаар ажиллаж байна. Энэ бүхэн бол Үндэсний баялгийн сангийн тухай хууль бодитой хэрэгжих ийм суурь нөхцөл болно.

Баялаг хэсэг бүлэг, цөөн хүмүүсийн гарт төвлөрсөн, тэд улс орныхоо хөгжих, ард түмнийхээ сайн сайхан амьдрах боломжийг хулгайлж байсан. Энэ талаар Монгол Улсын Ерөнхий сайдын манлайлал дор энэ 4 жилд маш их өөрчлөлт хийсний үр дүнд

өнөөдрийн байдлаар бол улсын төсөвт бодит үр дүн гарлаа. Энэ хулгайтай Улсын Их Хурал, Засгийн газар хамтран тэмцэж, тодорхой үр дүнд хүрч байна. Зөвхөн Таван толгойн ордоор жишээ татахад 2022 оны 10 дугаар сарын 26-нд Эрдэнэс таван толгой ХК-д 6 сарын хугацаатай онцгой дэглэм тогтоосноор нүүрсний үнэ уурхайн ам дээрээ 60-аас 115 ам.доллар байсан бол дэглэм тогтоосны дараа 180 ам.доллар-т хүрсэн, 70-аас 100 ам.доллар дунд нь цавчигдаж хулгайлагдаж байсан гэснийг илрүүлсэн гэсэн үг. Энэ бүхний үр дүнд Монгол Улсын гадаад валютын нөөц 5,2 тэрбум долларт хүрлээ. Экспортын нөөц нэмэгдлээ, төсвийн орлого давж биелж байна. Энэнийхээ үр дүнд одоо төсвийн тодотгол хийж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх, Үндэсний баялгийн сангийн хуулийг бодитой хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

Баялгийн ийм хулгайг таслан зогсоосноор, зогсоох бол одоо бидний эхний зорилт байсан. Баялгийг ашигласнаас олох орлогоос тусгайлсан санд хуримтлуулж, улс орны хөгжил, иргэдийн амьжиргааг дэмжихэд зарцуулах нь 2 дахь зорилт юм. Энэ 2 чухал зорилт бодитоор хэрэгжиж эхэлж байгаад баяртай байна. Энэ хуулиар Баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлтэй байна. Ирээдүйн өв сан нь баялгийн үр өгөөжийг хуримтлуулах, хуримтлагдсан хөрөнгийг олон улсын санхүүгийн зах зээлийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар үнэ цэнийг нь өсгөх, арвижуулахад чиглэгдэнэ.

Хуримтлалын санд хуримтлуулсан орлогоор Монгол Улсын иргэдэд эрүүл мэндийн, боловсролын, тэр дотроо хамгийн чухал нь орон сууцын зэрэг зориулалтаар дэмжлэг үзүүлнэ. Хөгжлийн сангийн хөрөнгөөр Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ. Монгол Улсын иргэн бүр хуримтлалын нэрийн данстай байна. Хуримтлалын сангийн

мөнгөн хөрөнгийг энэ дансан дээр бүртгэнэ. Энийг хэрэгжүүлэх ажил дээр Монголбанк Төв банк бол бас өндөр үүрэг хариуцлагатай орохоор хуульчиллаа. Бодлогын хүүгээр өсгөн үржүүлж байх, бодлогын хүүгээс дээш өгөөжтэйгөөр өсгөн үржүүлж байх ийм үүргийг хуульчиллаа.

Монгол Улс бол байгалийн асар их баялагтай орон. Монгол Улсын газрын хэвлий, эрдэс баялгаар дүүрэн. Ийм баялагтай ард түмэн бол ядуу байх, ийм хөгжлөөс хоцрогдож байж таарахгүй. Эцэг өвгөдөөс үр хойч бидэндээ үлдээсэн энэ баяндэлгэр газар нутаг, хөрс шороонд буй баялгаа зөв ашиглаж, үр дүнтэй зарцуулж, ашгийг нь хүртэх нь, амьдрах нь Монгол хүмүүсийн үндсэн эрх. Монгол хүн болж төрсөн хүн бүхэн энэ эрхийг хэнтэй ч хуваалцахгүйгээр эдлэх

ёстой. Хуулиар бид одоо энэ Үндэсний баялгийн сангийн хуулиар бид баялагтаа эзэн болж, хуулиар энэнийхээ үр өгөөжийг хүртэх боломж ингээж бүрдэж байна. Баялгийн эзэн, түүний үр өгөөжийг хүртэх бүрэн эрхт гишүүн Монгол хүн бүрд энэ Баялгийн сан зориулагдах учиртай. Баялгийн сангийн хууль эцэслэн батлагдлаа.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулган хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА